

Байгаль орчны үнэлгээ ба хяналтын хүрээ

2019 оны 5 дугаар сар

МОН 49430: Аймаг, сумын хөгжлийн
хөрөнгө оруулалтын хөтөлбөр (АСХХОХ)

Азийн хөгжлийн банкинд зориулан Барилга, хот байгуулалтын яам боловсруулав.

Валютийн ханш
(2019 оны 9 сарын 3)

Валютийн нэр	–	Төгрөг (төг)
1.00 төг	=	0.00038 ам.дол.
1.00 ам.дол.	=	2,620 төг

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АХБ	-	Азийн хөгжлийн банк
ГЗБГЗЗГ	-	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
АСХХОХ	-	Аймаг, сумын хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр
ГБОМТ	-	Гүйцэтгэгчийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОГ	-	Аймгийн Байгаль орчны газар
БОНБУ	-	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
БОМТ	-	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОХТ	-	Байгаль орчны хяналтын тайлан
МУЗГ	-	Government of Mongolia
ГБМ	-	Гомдол барагдуулах механизм
БОТБУ	-	Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ
БОАЖЯ	-	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
төг	-	Монгол төгрөг
БХБЯ	-	Барилга, хот байгуулалтын яам
ХХААХҮЯ	-	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ТХН	-	Төсөл хэрэгжүүлэх нэгж
ТБТТ	-	Төсөлд бэлтгэх техникийн туслалцаа
БОТУ	-	Байгаль орчны түргэвчилсэн үнэлгээ
НШТ	-	Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө
ХБББ	-	Хамгааллын бодлогын баримт бичиг (2009)
ам.дол	-	АНУ-ын доллар

ХЭМЖИХ НЭГЖ

км	-	километр
км ²	-	хавтгай дөрвөлжин километр
кг	-	килограм
га	-	гектар
м	-	метр
м ³	-	куб метр
мг	-	миллиграм
мг/л	-	нэг литрт агуулагдах миллиграм
т	-	тонн метр

Тус тайланд "\$" тэмдэгээр АНУ-ын долларыг илэрхийлнэ.

Тус байгаль орчны үнэлгээ ба хяналтын хүрээ нь зээлдэгчийн баримт бичиг. Энд илэрхийлэх үзэл бодол АХБ-ны Захирлуудын зөвлөл, удирдлага, ажилтнуудын үзэл бодлыг төлөөлөхгүй бөгөөд бүрэн дүүрэн боловсруулагдаагүй байж болно. АХБ-ны вэб хуудсан дах “ашиглах нөхцөл” хэсэгт анхаарлаа хандуулна уу.

Азийн хөгжлийн банк тус баримт бичигт улс орны аливаа хөтөлбөр, стратеги боловсруулах, төслийг санхүүжүүлэх эсвэл тодорхой нутаг дэвсгэр, газар нутгийг ямар нэгэн байдлаар тодорхойлох, иш татахдаа аль нэг нутаг дэвсгэр, газар нутгийн хууль эрх зүйн эсвэл бусад статусын талаар ямар нэгэн дүгнэлт хийгээгүй болно.

АГУУЛГА

I.	ТАНИЛЦУУЛГА	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
A.	ОШСЗШ-ын төслийн үндэслэл	6
B.	Байгаль орчны үнэлгээ ба хяналтын хүрээ (БОҮХХ)-ний үндэслэл	7
C.	Институцийн зохион байгуулалт ба хүлээх үүрэг	8
D.	Үнэлгээний орчин	Error! Bookmark not defined.
II.	ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА ИНСТИТУЦИЙН ЧАДАВХИД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ	10
A.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	Error! Bookmark not defined.
B.	Байгаль орчныг хамгаалахтай холбоотой хууль, бодлого, стандартууд	11
C.	БОНБУ-ний талаарх АХБ-ны шаардлага	12
III.	АСХХОХ-ИЙН I ШАТЛАЛААС ХҮЛЭЭГДЭЖ БУЙ БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛӨЛ	12
A.	АСХХОХ-өөс аймаг, сумын төвд үүсэх эерэг нөлөөлөл	12
B.	Нөлөөлөл ба түүнийг бууруулах	14
C.	Уур амьсгалын өөрчлөлт	Error! Bookmark not defined.
IV.	АСХХОХ-ИЙН ДАРААГИЙН ШАТЛАЛУУДЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ	20
A.	АСХХОХ-ийн дараагийн шатлалууд	20
B.	Нөлөөллийн үнэлгээний тайлан	24
C.	Монгол Улсын болон АХБ-ны байгаль орчны хамгааллын арга хэмжээний нэгдсэн хэрэгжилт	25
D.	Олон нийттэй зөвлөлдөх ба мэдээллийг нээлттэй байлгах	Error! Bookmark not defined.
E.	Гомдол барагдуулах механизм	Error! Bookmark not defined.
V.	ИНСТИТУЦИЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ХҮЛЭЭХ ҮҮРЭГ	28
A.	БОҮХХ-г хэрэгжүүлэх үүрэг	28
VI.	СУРГАЛТ БА ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
VII.	ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ БА ТАЙЛАГНАХ	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
	ХАВСРАЛТ А: АСХХОХ-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТҮРГЭВЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ (БОТУ)	33
	ХАВСРАЛТ В: АСХХОХ-Т ХОЛБОГДОХ БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ БА СТАНДАРТУУД	38
	ХАВСРАЛТ С: МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН КОНВЕНЦУУД	44
	ХАВСРАЛТ D: БОТБУ, БОТУ, БОМТ-НИЙ ХУРААНГУЙ АГУУЛГЫН ТОВЧООН	45
	ХАВСРАЛТ E: АСХХОХ-ИЙН ОЛОН НИЙТТЭЙ ЗӨВЛӨЛДӨХ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН УДИРДАМЖ	48
	ХАВСРАЛТ F: ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ	51
	ХАВСРАЛТ G: БОНБУ-НИЙ ДОТООДЫН МЭРГЭЖИЛТНИЙ ЖИШИГ АЖЛЫН ДААЛГАВАР	54
	ХАВСРАЛТ H: БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР	59
	ХАВСРАЛТ I: БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАГАС ЖИЛИЙН МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН	60
	ХАВСРАЛТ J. АСХХОХ-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭРСДЭЛ БА БАТАЛГАА	67

Хүснэгт 1. АСХХОХ-өөс аймаг, сумын төвд оруулахаар төлөвлөж буй хот байгуулалтын

хөрөнгө оруулалт	6
Хүснэгт 2. АСХХОХ-өөс аймаг, сумын төвд оруулахаар төлөвлөж буй ХАА-н бизнесийн хөрөнгө оруулалт	7
Хүснэгт 3. I шатлалын газар чөлөөлөх ба нүүлгэн шилжүүлэх (ГЧНШ) төлөвлөгөө.....	14
Хүснэгт 4. ТХН, ХА-д зоиулсан сургалтын жишиг сэдэв	30
Зураг 1. АСХХОХ-ийн институцийн зохицуулалт.....	9

I. ТАНИЛЦУУЛГА

A. ОШСЗШ-ын төслийн үндэслэл

1. Аймаг, сумын хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр (АСХХОХ) нь орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжиж, эхний шатанд авч үзэж буй аймгууд¹ дахь хот, суурин газруудын нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулах юм. Энэхүү хөтөлбөр нь зорилтот бүс нутагт байгаль орчинд ээлтэй, хүртээмжтэй, өрсөлдөх чадвартай нутаг дэвсгэрийн хөгжлийг дэмжих мөн уур амьсгалын өөрчлөлтөд өртөх эмзэг байдал болон бэлчээрийн доройтлыг багасгахад чиглэсэн бодит хөрөнгө оруулалт хийж, өнөөгийн бодлогын хүрээг бэхжүүлэхэд чиглэх болно. Газарзүйн байршлаар нэгтгэн цогцоор авч үзэж буй энэхүү аргачлал нь эдийн засгийн өсөлт, төрөлжилтийн гол хөдөлгүүр болох боломж бүхий бүс нутаг, орон нутгийн эдийн засгийн тэргүүлэх салбаруудад чиглэх болно.

2. АСХХОХ-өөс дараах 4 үр дүн² гарах болно:

- (i) Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, хүлэмжийн хийн ялгаруулалт бага, хүмүүсийг урин дуудсан аймаг сумын төвүүд болж хөгжинө.
- (ii) Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, хүлэмжийн хийн шингээлт өндөр тогтвортой мал аж ахуй бүхий бэлчээрийн менежменттэй болно.
- (iii) Хүлэмжийн хий бага ялгаруулдаг, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон хүртээмжтэй өртгийн сүлжээг үүсгэж бэхжүүлнэ.
- (iv) Байгаль орчинд ээлтэй нутаг дэвсгэрийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулах болон чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3. АСХХОХ нь олон шатлалт зээлийн санхүүжилтийн шугам (ОШСЗШ)-аар санхүүжигдэнэ. ОШСЗШ-ын төслийн I шатлал нь Увс аймгийн төв Улаангом, Баян-Өлгий аймгийн төв Өлгий, Ховд аймгийн төв Жаргалант, мөн түүнчилэн Увс аймгийн Өмнөговь, Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын төвийг тус тус хамарч байгаа болно.

4. Төслийн үр дүнг сайжруулах үүднээс олон салбарын АСХХОХ нь сонгосон гурван аймгийн төв болон хоёр сумын төвд дараахь хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсэгт хөрөнгө оруулалт хийх болно. Үүнд:

- (i) Хотын нийтийн аж ахуйн үндсэн үйлчилгээ, байгууламж, дэд бүтэц,
- (ii) Агро-бизнес (ХАА-н үйлдвэрлэл)-ийг хөгжүүлэх.

Төлөвлөж буй хөрөнгө оруулалтыг доорхи хүснэгтэд нэгтгэж харууллаа. Хот нийтийн аж ахуйн хөрөнгө оруулалт нь үндсэндээ яг аймаг, сумын төвүүдэд очих бол агро-бизнесийн хөрөнгө оруулалт нь аймаг сумын төвд ойрхон орших газруудад оногдох болно.

Хүснэгт 1. АСХХОХ-өөс аймаг, сумын төвд оруулахаар төлөвлөж буй хот байгуулалтын хөрөнгө оруулалт

¹ Аймаг нь Монгол Улсын засаг захиргааны нэгж бөгөөд мжутай дүйнэ. 21 аймагтай, аймаг бүр аймгийн төвтөй. Аймаг нь сумдаас бүрдэх ба сум нь бас сумын төвтөй. Монгол Улс нийт 304 сумтай (аймгуудын төвийг эс тооцон). Сум дундажаар 4 000 хүн амтай, 5 000 орчим км² нутаг дэвсгэртэй.

² Төслийн мэдээлэл цуглуулах баг (11/19) төслийн үндэсний оролцгчид (БХБЯ, ГЗБГЗЗГ, ХХААХҮЯ, БАХХ)-той хамтран.

Хот байгуулалтын хөрөнгө оруулалт	
Гэр хорооллын дахин төлөвлөлт³	Дулааны шугам сүлжээг сайжруулах
Зам засаж сайжруулах, ус зайлуулах дренаж	Үерээс хамгаалах голын эрэг далангийн бэхэлгээ
Бохир ус зайлуулах сүлжээг сайжруулах, бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барих буюу өргөтгөх (ХУЦБ)	Ус зайлуулах суваг
Ус цэвэршүүлэх, түгээх сүлжээг сайжруулах	Хог хаягдлын менежментийг сайжруулах
Цахилгаан хангамжийг өргөтгөх	Сургууль, эмнэлэг, захиргааны барилгыг засах
Харилцаа холбооны цамхаг, шилэн кабелийн сүлжээ	

Хүснэгт 2. АСХХОХ-өөс аймаг, сумын төвд оруулахаар төлөвлөж буй ХАА-н бизнесийн хөрөнгө оруулалт

ХАА-н бизнесийн хөрөнгө оруулалт *	
- Бэлчээр ашиглагчдын бүлгүүдэд⁴ зориулсан олон нийтэд суурилсан төсөл: - МАА-н үйлдвэрлэл, - хадлангийн талбай, агуулах, - бага оврын усалгаа, - худаг усыг сайжруулах, - жигжиг гол дээр гүүр барих	- Агро-парк - Хорио цээрийн бүс - Мах боловсруулах үйлдвэр - Мал эмнэлэг, лабораторийн үйлчилгээ - Судалгааны төв - Бизнес инкубатор төвүүд - Боловсруулах үйлдвэрүүд
Услалтын систем, тэжээлийн аж ахуй**	

* ХАА-н бизнесийн хөрөнгө оруулалт нь өмнөх хүснэгт 1-д үзүүлсэн дэд бүтцээр дэмжигдэх болно

** Ховд аймагт услалтын систем, тэжээлийн аж ахуй төлөвлөгдөөгүй.

В. Байгаль орчны үнэлгээ ба хяналтын хүрээ (БОҮХХ)-ний үндэслэл

5. АСХХОХ нь олон шатлалт зээлийн санхүүжилтийн шугам (ОШСЗШ)-аар санхүүжигдэх мөн түүнчилэн төслийн хамрах хүрээ нь i) олон төрлийн дэд бүтэц, ii) ХАА-н бизнес ба бэлчээрийн менежмент гэсэн хоёр тусдаа, цогцолбор хөрөнгө оруулалтын хэсгүүдээс бүрдэж байгаа учраас байгаль орчны үнэлгээ ба хяналтын хүрээг (БОҮХХ) боловсруулах шаардлагатай. АСХХОХ нь БХБЯ, ХХААХҮЯ-ны зүгээс бодлого, техникийн шууд дэмжлэг тусалцаа авах шаардлагатай (зураг 1-ийг үзнэ үү). Төлөвлөсөн дэд бүтцийн хөрөнгө оруулалт нь Монгол Улсын хувьд шинэ зүйл биш бөгөөд харин ХАА-н бизнес,

³ Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөлд (ОНОСХШТ), ТА 9030, 2017.

⁴ Бэлчээр ашиглагчдын бүлэг

бэлчээрийн менежментийн хөрөнгө оруулалт нь нэлээд онцлог шинэ сэдэв болж байна.

6. АСХХОХ-ийг бусад аймаг, сумын төвүүд рүү өргөтгөх үүднээс I шатлалын дараачаар нэмэлт II шатлалыг хийж гүйцэтгэнэ. Иймд БОҮХХ нь БОАЖЯ-аас тавигддаг шаардлага болон АХБ-ХБББ-т (2009) заагдсаны дагуу дараачийн ээлжийн төслүүдийн байгаль орчны талаар хүлээх үүрэг хариуцлага, менежментэд чиглэл өгнө. Энэхүү БОҮХХ-г АСХХОХ-ийн I шатлалын Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний үр дүнд суурилж боловсрууллаа.

7. БОҮХХ нь АСХХОХ-ийн дараачийн ээлжийн төслүүдэд зориулж I шатлалд тогтоогдсон болзошгүй нөлөөллүүдийг нэгтгэн дүгнэж үүнийгээ хамгааллын үндсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх удирдамж чиглэл болгох ба үүнд төслийн ерөнхий үнэлгээ, төслийн ангилал, нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, олон нийттэй зөвлөлдөх хэлэлцүүлэг, мэдээллийн ил тод байдал, тайлагнал, институцийн зохицуулалт, үүрэг хариуцлагын хүрээ хамрагдана.

С. Институцийн зохион байгуулалт ба хүлээх үүрэг

8. Сангийн Ямаар ахлуулж БХБЯ, ХХААХҮЯ, БОАЖЯ, Монгол Улсын Хөгжлийн банк (МУХБ), зорилтот аймгуудын удирдлагууд оролцсон, төслийн хэрэгжилтэд хяналт тавих, бодлого стратегийн чиглэл өгөх, яам, агентлагуудын уялдаа холбоог хангах зорилго бүхий Төслийн удирдах хороог (ТУХ) байгуулна. Төслийн хэрэгжилтийг шууд удирдах, хяналт тавих зорилгоор БХБЯ, ХХААХҮЯ, МУХБ, аймгуудын удирдлагыг оролцуулсан Гүйцэтгэх ажлын хэсэг (ГАХ) байгуулагдана. Төслийн гүйцэтгэгч агентлаг (ГА) нь БХБЯ байх бөгөөд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж төслийн хэрэгжилтэд хяналт тавина. ГА нь ТУХ болон ГАХ-ын удирдлага дор ажиллана. БХБЯ-ны дэргэд Хөтөлбөрийн удирдах нэгж (ХУН) байгуулагдах бөгөөд захирал нь ГЗБГЗЗГ-ын дарга байх болно. ХУН-ийг албаны захирал удирдах ба гурван дэд зохицуулагч бүхий гурван хэлтэстэй байна. Үүнд (i) хот суурин, нутаг дэвсгэрийн хөгжлийн асуудал хариуцсан хэлтэс БХБЯ-тай уялдаж хамтран ажиллана, (ii) бэлчээрийн менежмент, хөдөө аж ахуйн бүрэлдэхүүн хэсгийг хариуцсан хэлтэс ТУН-ийн захирал, зохицуулагчид тайлагнах, ХХААХҮЯ-тай уялдаж хамтран ажиллана, (iii) худалдан авалт, санхүү, хамгааллын асуудал, магадлан шинжилгээний асуудлыг хариуцсан хэлтэс ТУН-ийн захирал болон зохицуулагчид шууд тайлагнана. Төслийн Санхүүгийн зуучлалын зээлийн (СЗЗ) бүрэлдэхүүнийг удирдах төсөл хэрэгжүүлэх нэгжийг (ТХН) Хөгжлийн банкны шууд удирдлага дор ХБ-ХУК-ийн зүгээс байгуулах ба энэ нэгж нь ХМА-ны захирал, зохицуулагчтай хамтран уялдаж ажиллана.

9. Аймгийн хэмжээнд Аймгийн төслийн нэгж (АТН), төслийн зорилтот сумдад сумын төслийн нэгж (СТН) байгуулагдана. Алба тус бүр хот байгуулалт, бэлчээрийн менежмент, агро-бизнес, хамгаалал, магадлан шинжилгээний багтай байна. АТН тус бүрт зохицуулагч байх бөгөөд ТУН-ийн захирал, зохицуулагчдад тайлагнах бөгөөд Аймгийн ЗДТГ-тай хамтран уялдаж ажиллана. Мах, ноос, ноолуур, арьс шир, нэхий бүтээгдэхүүн үйлдвэрлэгдийн холбооны төлөөлөл, МҮХАҮТ, малчдын байгууллага, хоршоодоос бүрдсэн орон нутгийн ХАА-н бизнесийн зөвлөлийг байгуулах ба эдийн засгийн болон өртгийн сүлжээг хөгжүүлэх чиглэлээр ГАХ болон ТУН-д удирдамж, дэмжлэг үзүүлнэ. Төслийн зорилтот сум дундын төв бүрт Сум дундын төсөл хэрэгжүүлэх нэгж (СДТХН) байгуулагдах бөгөөд хот байгуулалт, бэлчээрийн менежмент, агробизнесийн багаас бүрдэнэ. СДТХН-ийн үйл ажиллагааг нэгжийн зохицуулагч удирдах ба АТН-ийн зохицуулагчид тайлагнах бөгөөд сумын ЗДТГ-тай уялдаа холбоотой ажиллана.

10. Төслийн ГА болох БХБЯ нь БОМТ-г гурван аймгийн төвд хэрэгжүүлэх ажлыг нийтэд нь хариуцах ба шаардлагатай тохиолдолд ГАХ эсвэл ТУХ-оос өндөр түвшний шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлнэ. БХБЯ-ны дэргэд байгуулах ТУН-ийн худалдан авалт, санхүү, хамгаалал, магадлан шинжилгээний асуудал хариуцсан хэлтсийн зохицуулагчаас (зураг 1)

нийгмийн хамгааллын ажилтантай хамтран ажиллах байгаль орчны хамгааллын ажилтныг (БОХА) томилно. БОХА нь БОМТ-г амжилттай хэрэгжүүлэх асуудлыг хариуцна. БОХА нь АТН-ийн зохицуулагчтай нягт хамтран ажиллана. Аймгийн зохицуулагч нь АТН-ийн хамгаалал, магадлан шинжилгээний багт ажиллах аймгийн байгаль орчны хамгааллын ажилтныг (АБОХА) томилно. АБОХА нь аймаг, сумын БОМТ-г зохих түвшинд хэрэгжүүлэхийн тулд төслийн талбай дээр ажиллах ба БОХА-ны дэмжлэг авна. АБОХА нь эргээд сум дахь БОМТ-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан сумын төслийн хэрэгжилтийн нэгжтэй (СДТХН) нягт хамтран ажиллаж, удирдан чиглүүлэх болно. АБОХА нь БОХА-ийн дэмжлэгтэйгээр барилгын ажлын гэрээт гүйцэтгэгчдийн зүгээс хийж буй ГБОМТ-ний гүйцэтгэлийг удирдаж хянана. Гүйцэтгэгч нь аймгийн төслийн барилгын тендерийн баримт бичигт тусгагдсан БОМТ-нд үндэслэж ГБОМТ-г боловсруулах ба тендерийн саналдаа тусгасан байна.

11. Төслийн санхүүгийн зуучлал (СЗ)-ын бүрэлдэхүүн хэсэгт зориулан бэлтгэсэн БОНМС-ийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд ХБ-ХУК дахь ТХН нь ТУН-ийн хамгаалал ба магадлан шинжилгээ хариуцсан дэд зохицуулагчидтай нэгэн адил байгаль орчин, нийгмийн хамгааллын ажилтнуудыг ажиллуулна.

Зураг 1. АСХХОХ-ийн институцийн зохион байгуулалт



12. Монгол Улсын БОНБУ хийх эрх бүхий ААН-ийг зураг 1-т тусгаагүй бөгөөд энэ ААН нь аймаг, сумын төвд хийгдэх төслийн БОМТ-д тусгагдсан байгаль орчны хяналт шинжилгээ, лабораторийн шинжилгээг хийж гүйцэтгэнэ. АСХХОХ-ийн I шатлалын нарийвчилсан зураг төсөл, түүний хэрэгжилтэд хяналт тавихаар томилогдсон төсөл хэрэгжүүлэх, хяналт тавихад дэмжлэг үзүүлэх зөвөх (ТХХТЗ) багийн байгаль орчны олон улсын мэргэжилтэн (ОУБОМ) нь АХБ-ны Хамгааллын асуудал хариуцсан ажилтны хамтаар БОМТ-г хэрэгжүүлэхээр ажиллаж буй ТХН-д дэмжлэг үзүүлэх болно. Барилгын ажил гүйцэтгэгч компаниуд өөрсдийн бэлтгэсэн тендерийн баримт бичгийн нэг хэсэг болох БОМТ-г боловсруулсан гүйцэтгэгчийн хамтаар уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

D. Үнэлгээний орчин

13. АСТХХОХ нь байгаль орчны хувьд Б ангилалд хамаарах бөгөөд бүх болзошгүй сөрөг нөлөөлөл нь богино хугацаатай, БОМТ-ний дагуу нөхөн сэргээж зохицуулах боломжтой гэсэн үг юм. I шатлалын хувьд БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газраас байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБУ) хийхийг шаардах болно.

II. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА ИНСТИТУЦИЙН ЧАДАВХИЙН ҮНЭЛГЭЭ

A. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ

1. Монгол Улсын хууль эрх зүйн хүрээ

14. Монгол Улсад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн (2012) дагуу гүйцэтгэдэг бөгөөд БОАЖЯ-ны зүгээс удирдан зохицуулдаг. БОНУ-ний журмын дагуу бүх төслүүдийг хэрэгжүүлэхийн өмнө байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ (БОНЕУ) буюу урьдчилсан үнэлгээ, үүний дараагаар байгаль орчны нөлөөллийн бүрэн хэмжээний нарийвчилсан үнэлгээ (БОННУ), эсвэл нөлөөлөл маш бага байх төслийн хувьд байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) гэсэн хоёр шатлалтайгаар хийж байна. БОМТ нь төсөл эхлэхээс өмнө онцлог нөхцөл байдлыг шийдвэрлэхэд шаардлагатай арга хэмжээг зааж өгдөг. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл бага гэж тооцогддог төслүүдийн хувьд тухайн төсөл хэрэгжих гэж буй аймаг, хотын байгаль орчны газраас БОНЕУ болон шаардлагатай БОМТ-г хянан баталж болно.

15. БОНУ-г гүйцэтгэх үйл явцын эхний алхам нь төслийг өмчлөгч (БХБЯ) нь БОАЖЯ, эсвэл орон нутаг/хотын байгаль орчны газарт хандаж уг төслийн БОНЕУ-г хийлгэх хүсэлт гаргана. Үүнд дараах үндсэн мэдээллийг агуулсан байна: i) төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт, ii) хэрэгжүүлэх төслийн талаарх техникийн зураг хавсаргасан нарийвчилсан тодорхойлолт, iii) төслийн техник эдийн засгийн үндэслэл. БОНЕУ-нээс дараах шийдлүүдийн аль нэг гарна:

1. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ) хийхгүйгээр төслийг хэрэгжүүлэхийг зөвшөөрөх,
2. Тусгай нөхцөлүүдийг хэрэгжүүлэх юм уу эсвэл БОМТ-д заагдсан нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг авснаар төслийг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ) хийхгүйгээр хэрэгжүүлэхийг зөвшөөрөх;
3. Төслийг хэрэгжүүлэхэд БОННУ хийх шаардлагатай,
4. Холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн, эсвэл хүрээлэн буй орчинд тоног төхөөрөмж, технологийн зүгээс учрах сөрөг нөлөө маш их, газрын менежментийн төсөл байхгүй гэсэн шалтгаанаар төсөл хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх.

16. **БОННУ-ний тайлан дараах бүрэлдэхүүн хэсгүүдтэй байна:**

1. Байгаль орчны төлөв байдал,
2. Төслийн болон технологийн хувилбарууд,
3. Болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж,
4. Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл, тэдгээрийн эрчим, тархалт, үр дагаврыг тогтоосон тооцоо, судалгааны үр дүн,
5. Эрсдэлийн үнэлгээ,
6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон хяналтын хөтөлбөр,
7. Төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн санал,
8. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргааны албан ёсны санал,
9. Шаардлагатай бол төсөл хэрэгжих газрын түүх соёлын үнэт зүйлс, төслийн онцлогтой уялдсан бусад асуудал,
10. Шаардлагатай тохиолдолд нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө.

17. Засгийн газрын БОМТ-ийн тайлан дараах бүлгүүдээс бүрдэнэ. Үүнд:

1. **Сөрөг** нөлөөний нэгдсэн үнэлгээ,
2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө,
3. Дүйцүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө,
4. Нүүлгэн байрлуулах, нөхөн олговор олгох үйл ажиллагааны төлөвлөгөө,
5. Түүхийн болон соёлын өвийн төлөвлөгөө,
6. Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө,
7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
8. Жил тутмын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүтэц, зохион байгуулалт, хэрэгжүүлэлт,
9. Байгаль орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө,
10. Нөлөөлөлд өртсөн оршин суугчид, оролцогч талуудад зориулсан жил тутмын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь.

18. Төслийг батлахын тулд хамгаалалтыг хангах баримт бичиг болгож БОННУ эсвэл БОМТ-г төрөөс шаарддаг. Үүний зэрэгцээ эдгээр баримт бичгүүд нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээ мөн АХБ-ХБББ-ийн (2009) дагуу шаарддаг байгаль орчны аюулгүй байдлыг хангах ерөнхий нөхцөлд зориулсан чухал мэдээллүүдээр хангадаг. Ялангуяа байгаль орчны талаархи анхны суурь мэдээлэл, төслийн нийгэм, соёлын нөлөөллийн дүн шинжилгээ чухал байдаг. Энэхүү мэдээлэл нь БОТБҮ-нд тухайн орон нутгийн нөхцөлийн талаарх чухал дүр зургийг гаргаж өгдөг. Төсөл АХБ-аар батлагдахаас өмнө БОАЖЯ эсвэл орон нутгийн байгаль орчны газраас БОННУ, БОМТ-г баталсан байх ёстой.

В. Байгаль орчныг хамгаалахтай холбоотой хууль, бодлого, стандартууд

19. Монгол Улсын Засгийн газар байгаль орчин, байгалийн нөөц баялаг, тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах ба бохирдлын менежментийн чиглэлээр тусгайлсан хуулиудыг батлуулан, байгаль орчны стандартыг тогтоосон байдаг. АСХХОХ-т хамааралтай өргөн хүрээг хамарсан хуулиудын холбогдох хэсгүүдийг Хавсралт В-д нэгтгэж харуулсан. АСХХОХ-ийг хэрэгжүүлэхэд мөрдөх байгаль орчны чанарын болон техникийн холбогдох стандартуудын жагсаалтыг Хавсралт Б-д үзүүлэв. Түүнчилэн Монгол Улсын гарын үсэг зурж нэгдсэн АСХХОХ-д хамаарах олон улсын байгаль орчны гэрээ, конвенцуудаас жагсаалтыг Хавсралт С-д харуулав.

С. АХБ-ны БОНБУ-ний шаардлага

20. Хөгжлийн төслүүдэд тавигддаг АХБ-ны БОНБУ-ийн шаардлагыг Хамгааллын бодлогын баримт бичигт тусгасан байдаг. АХБ-ХБББ (2009) нь Хамгаалалтын арга хэмжээний тэргүүн туршлагын эмхэтгэл, үйл ажиллагааны гарын авлага, хянан шалгах журмуудаар дэмжигддэг. АХБ-ХБББ (2009)-т тавигдсан шаардлагыг хангахын тулд байгаль орчины хамгаалах зайлшгүй шаардлагыг хэрхэн дагаж мөрдөх тухай удирдамжийг АХБ-ХБББ (2009) болон Туршлагын эмхэтгэлд нарийвчилж тусгасан байдаг. АХБ-ны баримт бичигт заасан хөгжлийн төслүүдэд хийгдэх нөлөөллийн үнэлгээний дөрвөн түвшинг дор харуулав:

Ангилал А:

Байгаль орчинд ноцтой буюу их хэмжээний нөлөөлөл үзүүлэх, нөхөн сэргээх боломжгүй, олон төрлийг хамарсан, урьд өмнө байгаагүй сөрөг нөлөөлөл үзүүлэх төслүүд хамаарна. БОНБУ-ний тайлан мөн байгал орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) шаардлагатай.

Ангилал В:

Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл харьцангуй бага бөгөөд төслийн тухайн нутаг байршлаас хамааралтай, ихэнх тохиолдолд нөхөн сэргээгдэх боломжтой төслүүд. БОТБУ, БОМТ шаардлагатай.

Ангилал С:

Байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэй буюу нөлөөлөл үзүүлдэггүй төслүүд. Байгаль орчны ерөнхий үнэлгээн дээр нэмж БОТБУ, БОНБУ хийх шаардлагагүй.

Ангилал FI-ийг АХБ-ны хөрөнгө оруулалтыг санхүүгийн зуучлагчаар дамжуулан, эсвэл тэдэнд олгож буй төслүүдэд хамааруулдаг. АСХХОХ-ийн I шатлал нь төслийн зарим бүрэлдэхүүн хэсэгтээ FI ангиллыг ашиглана.

III. АСХХОХ-ИЙН I ШАТЛАЛЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨСӨӨЛЖ БУЙ НӨЛӨӨЛЛҮҮД

21. АСХХОХ-ийн I шатлалын байгаль орчны төлөв байдлын (БОТБУ) үнэлгээний үр дүнг дор нэгтгэж үзүүлээ. Үүнийг АСХХОХ-ийн дараачийн үе шатуудад удирдамж болгон ашиглах болно. Гэхдээ АСХХОХ-ийн I шатлалын БОТБУ-ний үр дүнг цаашдаа бусад аймгуудад энэхүү хөтөлбөрийг үе шатаар хэрэгжүүлэх явцад гарч болох байгаль орчны болзошгүй нөлөөллийг тодорхойлох загвар жишээ гэж авч үзэж болохгүй. АСХХОХ-ийн дараагийн үе шатууд нь АХБ-ны Хамгааллын бодлого, Засгийн газрын БОНБУ-ний шинжилгээнд бүрэн хамрагдах ёстой.

А. АСХХОХ-өөс аймаг, сумын төвүүдэд бий болох үр шим

1. Амьдралын нөхцөл, гэр бүлийн эрүүл мэнд сайжрах

22. АСХХОХ-ийн I шатлалаас гарах бодитой үр өгөөж нь зорилтот аймаг болон сумын төвүүдийн дэд бүтцийг олон талаар сайжруулсанаар тэнд оршин суугчдын амьдралын нөхцөл дээшлэх явдал юм. Амьдралын нөхцөл, гэр бүлийн эрүүл мэндийг дээшлүүлэхэд чиглэсэн ажил хийгдсэнээр аймаг, сумын төвд амьдарч буй иргэдэд хүрч мэдрэгдэх шинж чанаруудыг дараах үзүүлэлтээр тодорхойлж болно:

1. Аймгийн төвд уламжлалт гэрийг орчин үеийн, эрчим хүчний хэмнэлттэй орон сууцаар орлуулсанаар байшин доторх агаарын чанар нэн даруй сайжирна (нүүрс, мод түлэхтэй харьцуулахад $PM_{2.5}$ буурах г.м.), нүхэн жорлонг халж орчин үеийн бие засах газар, ариутгах татуурга хэрэглэснээр ходоод гэдэсний замын өвчлөл буурна.
2. Шугам сүлжээнд холбогдсон ундны усан хангамж.
3. Шинэ, сайжруулсан бохир ус зайлуулах сүлжээ, цэвэрлэх байгууламж.
4. Өргөжүүлж сайжруулсан төвлөрсөн халаалтын систем.
5. Цахилгаан хангамж сайжирна.
6. Хатуу хог хаягдлыг зохион байгуулалттай цуглуулж зайлуулах мөн цэвэр, сайтар далдалсан хогийн цэг.
7. Үерийн усны хяналт сайжирч, борооны ус зайлуулах суваг дренаж сайжирна.
8. Сургууль, эмнэлэг, олон нийтийн төв зэрэг байгууламжуудад хүрэх нийтийн ажахуйн үйлчилгээ сайжирна.
9. Бохир ус цэвэрлэх байгууламжийг сайжруулсанаар гадаргын усны чанарт мэдэгдэхүйц ахиц гарна.
10. Уур амьсгалын ногоон сан (УАНС)-д өргөн барьсан тусдаа санхүүжилтийн санал (СС)-аар хэрэгжиж уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хэрэгжих хотын цахилгаан эрчим хүчний хэмнэлт болон сэргээгдэх эрчим хүчний дэд бүтцийн ажлын үр дүнд 1,1 сая tCO_2 шууд ялгарал буурна.

23. АСХХОХ-ийн хоёр дахь гол үр өгөөж нь аймаг, сумын төвүүдэд орчин үеийн ХАА-н бизнесийн технологи, практикийг нэвтрүүлэх төслийн хөдөө аж ахуйн бүрэлдэхүүн хэсэг байна. Энэ нь агро-паркийн цогцолбор байх бөгөөд үүнд хорио цээрийн бүс, мал эмнэлгийн үйлчилгээ, мал төхөөрөх орчин үеийн үйлдвэр, судалгаа шинжилгээний төвүүд, усалгаатай тэжээлийн аж ахуй байх болно. ХАА-н бизнес ба бэлчээрийн менежментийн бүрэлдэхүүн хэсгүүдийн гол үр өгөөж нь:

1. Мах боловсруулах, савлах, хадгалах орчин үеийн технологи нэвтрүүлэх (НҮБ-ХХАБ 1988, ДЭМБ-ын 1984), хог хаягдлын менежментийг зохистой болгох замаар байгаль орчны бохирдлыг мах боловсруулах өнөөгийн практикийн хэмжээнээс бууруулах.
2. #1-ээс дотоодын болон олон улсын зах зээлд зориулж үйлдвэрлэх махны чанарыг сайжруулснаар урьд өмнө нь хүрч чадахгүй байсан өндөр ашигтай олон улсын зах зээлд гаргах махны экспортоос малчид, экспортлогчдын амьжиргааны орлогыг нэмэгдүүлэх.
3. #2-оос мал сүргийн тоо толгой буурсанаар бэлчээрийн даац хэтрэлт багасах ба улмаар бэлчээрийн чанар сайжирна.
4. #3-аас малаас гарах метаны хий (CH_4) ба азотын исэл (NO_3)-ийн ялгарлыг бууруулж, нөхөн сэргээсэн бэлчээрт нүүрсхүчлийн хийн (CO_2) шингээлтийг нэмэгдүүлэх, улмаар төсөлд хамрагдаж буй Монгол орны баруун аймгуудын хүлэмжийн хийн ул мөрийг эрс бууруулах болно. Уур амьсгалын ногоон сан (УАНС)-д өргөн барьсан тусдаа санхүүжилтийн санал (СС)-аар хөрөнгө оруулалтын нийт хугацаанд хөрсний карбон хуримтлал нэмэгдэж, 94,0 сая tCO_2 ялгарал шууд буурах ба малын тоог бууруулж, метан, азотын ислийн 17,2 сая tCO_2 ялгарал шууд буурна.

Нийт хөрөнгө оруулалтын хугацаанд хотын цахилгаан эрчим хүчний хэмнэлт болон сэргээгдэх эрчим хүчний бүрэлдэхүүн хэсгүүдийн үр дүнд 1,1 сая tCO_2 шууд ялгарал, нийт 112,3 сая tCO_2 ялгарал буурна.

В. Нөлөөлөл ба бууруулах арга хэмжээ

1. Барилгын ажлын өмнөх үе шатанд гарах нөлөөлөл ба үндсэн үйл ажиллагаа

24. I шатлалын барилга угсралтын ажил эхлэхээс өмнөх үе шатны нөлөөлөл нь газар чөлөөлөлт, болзошгүй албадан нүүлгэн шилжүүлэлт юм. Инженерийн шугам хоолой, барилга байгууламж, авто зам, голын эрэг, далангийн тохижилтыг хамруулсан шинэ, сайжруулсан дэд бүтцийг барьж байгуулах ажлын нөлөөгөөр I шатлалд хот суурин газарт бага хэмжээний газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэлт хийх шаардлага үүснэ. I шатлалд шаардагдах газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн арга хэмжээг хүснэгт 3-т нэгтгэв.

Хүснэгт 3. I шатлалын газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх (ГЧНШ) тооцоо

ГЧНШ-ийн нөлөө	Өртөж буй иргэд, ААН			Өртөж буй хашаа			
	Иргэд	ААН	Нийт	Бүрэн	Хагас	Нийт хашаа	Өртөж буй нийт талбай м2
Баян-Өлгий	5	2	7	1	6	7	1043
Увс	21	1	22		14	14	1138
Ховд	-	-	-	-	-	-	-
Нийт			29	1	20	21	2181

а. Усны хангамж

25. Барилга угсралтын өмнөх үе шатанд хийх гол ажлууд болон I шатлалын нарийвчилсан зураг төслийн нэг хэсэг нь усны хэрэглээ бүхий төслийн бүрэлдэхүүн хэсэг болох тэжээл тариалах талбайн усалалтын систем, мах боловсруулах үйлдвэр мөн түүнчилэн цаашид нэмэгдүүлэхээр төлөвлөж буй хот суурин газрын ундны усны хангамжид шаардлагатай гадаргын болон гүний усны олдоц, хүртээмжийг баталгаажуулах явдал юм. Дараах шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг тогтоох зорилгоор төслийн талбайд орон нутгийн гадаргын болон гүний усны баланс хэмжээг тооцох гидро-геологийн үнэлгээг ялангуяа урсгал татарч багассан үед хийх ёстой:

(i) төслийн усны хэрэглээний шаардлагыг тогтвортой хангахуйц байх,

(ii) ус авч хэрэглэх цэгээс доошхи хэрэглэгчдэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх.

26. БОТБУ-ний IV бүлэгт нэгтгэж үзүүлсэн төслийн талбайн ойролцоох голын хамгийн бага тооцоот урсацыг ус авахаар эцэслэн тогтсон цэг дээр илүү нарийвчлалтай, улирлын бүрэн хэмжилт хийж, тэжээлийн ургамлын 500 га болон 200 га талбайг услахад шаардлагатай гэж тооцоолсон $0.315\text{м}^3/\text{сек}$, $0.126\text{м}^3/\text{сек}$ хэмжээ нь тогтвортой байх эсэхийг баталгаажуулах шаардлагатай. Түүнчилэн БОТБУ-д тусгагдсан агро-парк дахь ус хэрэглэгчдэд (т: төхөөрөх үйлдвэр, ХЦБ) шаардагдах тооцоолсон усны хэмжээг орон нутгийн гүний болон гадаргын усны хамгийн бага урсацтай харьцуулах нь зүйтэй.

б. БОМТ ба БОУХХ-г шинэчлэх

27. I шатлалын барилгын ажлын өмнөх үе шатанд хийгдэх эцсийн бөгөөд чухал үйл ажиллагаа бол гурван аймгийн БОМТ ба БОУХХ-г шинэчлэх явдал юм. Эцсийн зураг төслөөс гарах нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээг бүхэлд нь зөв удирдан зохион байгуулах үүднээс дэд бүтэц, ХАА-н бизнесийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нарийвчилсан зураг төслийг

тусгах зорилгоор энэхүү стандарт үйл ажиллагааг гүйцэтгэдэг. Төсөл хэрэгжүүлэх, хяналт тавих зөвлөх (доорхийг үзнэ үү) ТУН-д дэмжлэг үзүүлж, ТХХТЗ гэрээгээр олгох санхүүжилтийг ашиглан энэ 2 баримт бичгийг шаардлагын дагуу шинэчилж өгнө.

2. Болзошгүй нөлөөлөл – Барилгын ажлын үе шат

28. Хөтөлбөрийн I шатлалд хамрагдаж байгаа төслийн 5 талбай нь тусгай хамгаалалттай газар нутагт эсвэл түүний ойролцоо ямар нэг сөрөг нөлөөлөл үүсгэхгүй (АХБ-ХБББ 2009). Хот, суурин газар болон хот, суурингийн захаар баригдах ХАА-н бизнесийн бүрэлдэхүүн хэсгүүдээр дэд бүтэц (т: нийтийн аж ахуйн гол шугам [ундны ус, халуун ус, холбоо харилцаа, хаягдал ус], зам, барилга, дренаж, голын эрэг, даланг сайжруулах, усан хангамжийн суваг)-ийг сайжруулах, шинээр барих үед барилгын ажлын улмаас богино хугацаагаар бий болох төвөг, нөлөөллийг бууруулахад төвлөрнө.

29. Аймаг төв, сумын төвүүдэд хийгдэх барилгын ажлын улмаас үүсэх нийтлэг нөлөө, саад нь дараах байдлаар илэрнэ: нийтийн тээврийн хөдөлгөөнийг хаах, эсвэл багасгах; цахилгаан хангамжийн тасалдал; бизнес болон амралт чөлөөт цагийн үйл ажиллагаа тасалдах; газар шорооны ажил, хүнд даацын ачааны машин, тоног төхөөрөмжийн ашиглалтаас үүсэх сул тоос шороо; тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний улмаас үүсэх хөрсний бохирдол; оршин суугчид болон ажиллагсдын осол, гэмтлийн эрсдэлүүд; замын хөдөлгөөний түгжрэл болон осол, гэмтэл нэмэгдэх; хөрсний элэгдэл, гол горхины урсгалын дагуу лаг тунах; хэсэгчилсэн талбайд түр зуур үүсч болзошгүй ус зайлуулах сувгийн бөглөрөл болон ус халих асуудлууд. Барилгын ажилчдын байрлах хотхоноос хатуу хог хаягдал, ахуйн бохирдол гарч таарах бөгөөд мөн явуулын ажилчдаас үүдэлтэй болзошгүй халдварт өвчин, нийгмийн асуудал гарч болох талтай. Эдгээр богино хугацааны нөлөөлөл, хангамжийн тасалдал нь барилгын ажлын явц дараалал, аймаг сумын төвын хаана хийгдэж байгаа байршил зэргээс хамаараад янз бүрийн хэмжээ түвшинтэй байх болно. I шатлалын барилгын ажлын үед шатанд үүсэх нөлөөлөл, төвгийг дор хураангуйлан танилцуулав.

3 аймгийн төв болон Өмнөговь, Дэлүүн сумдын төвд

Аюулгүй, тогтвортой усан хангамж

30. Төслийн бүх 5 хэсгийн айл өрх, аж ахуйн нэгжүүд ундны усаа ойрхон байдаг ус түгээх цэгээс авдаг бөгөөд гол төлөв гэр, аж ахуйн нэгж рүүгээ өөрсдөө явганаар зөөдөг. Гэр бүлд хүүхдүүд ихэнхдээ ус зөөж авчрах үүрэгтэй байдаг.

31. Дэд бүтцийн барилгын ажил, гэр хорооллын дахин төлөвлөлт хийгдэх явцад өрхийн энэхүү үндсэн чухал ажил тасалдахгүй байх нь чухал юм. Өдөр тутмын эсвэл долоо хоногийн усаа зөөх үедээ хүүхэд, эхчүүд барилгын талбайн хажуугаар аюулгүй, чөлөөтэй явах боломжтой байх ёстой. Барилгын талбайн нийт хэсэг болон явган хүний зам хооронд тусгаарласан хамгаалалтын хашлага хийж одоо байгаа явган хүний замыг хамгаална. Хүмүүсийн аюулгүй байдлыг хангах шаардлагатай тохиолдолд ус зөөхөд зориулсан түр зуурын, хамгаалалттай маршрутыг бий болгох ёстой. Түүнчилэн барилгын ажлаас шалтгаалж гэр хороолол дахь ус түгээх цэгүүдэд ус хүргэх ажилд саад учруулж болохгүй.

Асфальт, бетон зуурмагийн үйлдвэр

32. Асфальт, бетон зуурмагийн түр үйлдвэрийг хот суурин газрын дэд бүтцийн ажилд ашиглах болно. Энэ үйлдвэр нь тухайн газар, орон нутгийн хувьд хүрээлэн буй орчины бохирдлын эх үүсвэр болдог. Элс, бусад агрегат түүхий эд материалын овоолгоос үүсэх салхи, усны элэгдэл (тоос шороо, лаг хурдас) болон зуурмаг үйлдвэрлэх, хүнд даацын тэргээр зөөвөрлөх явцад үүсэх байнгын чимээ шуугиан, хөдөлмөр хамгааллын эрсдэл зэрэг

асуудлууд үүснэ. Түүхий эдийг зохисгүй хэрэглэх, хадгалахаас үүдэж цемент дэх бэхжүүлэгч химийн бодис болон асфальт хийх материал дахь нүүрсустөрөгч нь (газрын тос, шингэлэгч зэрэг) хөрсний болон гадаргын усны бохирдол үүсгэж болзошгүй.

33. Түр үйлдвэр байгуулах, ажиллуулах, эцсийн байдлаар буулгаж зөөх ажлыг гүйцэтгэхдээ ийм ажилд хэрэглэдэг сайн туршлагын аргуудыг хэрэгжүүлэх ёстой. Гүйцэтгэгч нь БХБЯ-ны хяналтын дор Дэлхийн Банк (ОУСК)-ийн Байгаль орчны эрүүл ахуй, аюулгүй байдлын удирдамжийн (EHS 2007) 1) *Цемент, шохой үйлдвэрлэх*, 2) *Барилгын материал олборлох*, 3) *Газрын тосны жижиглэнгийн сүлжээ* гэсэн олон улсын дүрэм журмыг баримтлах ёстой. Саяхан батлагдсан АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлагийн (USEPA 2014) Бетон зуурмаг үйлдвэрлэх практикийн журмыг мөн ашиглаж болно.

Нийтийн аж ахуйн үйлчилгээний тасалдал

34. Аймаг, сумын төвүүдэд дэд бүтэц, шугам сүлжээг засварлах, өргөтгөх ажлын явцад оршин суугчид болон аж ахуйн нэгжүүдэд түгээх нийтийн үйлчилгээний хангамжид тасалдал үүсэх нь дамжиггүй. Орон нутагт гарах саад бэрхшээлийг багасгахын тулд боломжтой бол тухайн үед нөөц болон туслах төхөөрөмж ашиглах болно.

Улаангом

Нуурын эргийн дагуу үерийн хамгаалалтын даланг сайжруулах

35. Уулнаас буух уруйн үерээс урьдчилан сэргийлэх зорилгоор Улаангомьн баруун урд байх 5.0км шороон даланг шинэчлэн сайжруулна. Далангийн хойд төгсгөлийн хэсгийг орон нутгийн ундны усан хангамж, усжуулалтад зориулсан жижиг нуур үүсгэхэд ашиглана. Нуурт лаг тунах, даланд элэгдэл үүсэхээс урьдчилан сэргийлэхийн тулд далан дээр ажиллах хэсгүүдийн хооронд лаг шавар шүүгч хөшиг юм уу давхар налуу байрлуулахад онцгой анхаарах хэрэгтэй.

Өмнөговь сумын төв

Хогийн цэгийг нөхөн сэргээх

36. I шатлалаар төсөлд хамрагдаж буй бүх талбай дахь хатуу хог хаягдлын менежментэд нарийвчилсан үнэлгээ хийх ба үүнд одоо байгаа 5 хогийн цэгийг мөн хамруулна. Тус хэрэгцээ шаардлагын үнэлгээгээр одоо байгаа нөхцөл байдал, үүнд: хог хаягдал, физик профиль (хөрс, топографи, газрын доорх ус)-ийн шинж чанар болон АСХХОХ-ийн дараагийн шатлалд засаж залруулах шаардлагатай байгаль орчны аюултай зүйлсийг тодорхойлно. Газрын доорх усны дээж авч, шинжлэн бохирдол байгаа эсэхийг тогтооно. Газрын доорх усны үнэлгээ Өмнөговь суманд нэн чухал, учир нь орон нутгийн удирдлагын шийдвэрээр хог хаягдал салхинд хийсэхээс сэргийлэн, сумын төвийн ундны усны түвшин болон газрын доорх усны гүнийг үл харгалзан, сумын хогийн цэгийн газрыг ухаж, хог хаягдлыг хийж байгаа. Гүний усны түвшин болон усны чанарыг тодорхойлж, хог хаягдлаас болж бохирдоогүй гэдгийг баталгаажуулна.

Өлгий

Үерээс хамгаалах голын эргийн бэхэлгээ

37. Өлгийд үерээс хамгаалах зориулалтаар голын эргийн 1250м хэсгийг засаж тохижуулна. Улаангомд хийгдэх далангийн ажилтай ижлээр энд мөн голын усанд лаг тунах, даланд элэгдэл үүсэхээс урьдчилан сэргийлэхийн тулд далан дээр ажиллах хэсгүүдийн хооронд лаг шавар шүүгч хөшиг юм уу давхар налуу байрлуулахад онцгой анхаарах хэрэгтэй.

3. Болзошгүй нөлөөлөл – Үйл ажиллагааны үе шат

Дэд бүтцийн бүрэлдэхүүн хэсгүүд

Гэр хорооллын дахин төлөвлөлт

38. Дээр дурдсанчлан 3 аймгийн төвд орчин үеийн төвлөрсөн халаалт, угаалгын өрөө бүхий гэр хорооллын дахин төлөвлөлт хийх ажлын үр өгөөж нь хамрагдаж буй айл өрхүүдийн амьдралын нөхцөл ихээхэн сайжирна. Гэхдээ барилга байшингийн нягтрал нэмэгдсэнээр амьдралын нөхцөлд үзүүлэх бусад нөлөөллүүд болон асуудлууд үүсч болзошгүй. Нэгж талбайд оногдох гэр бүлийн нягтрал нэмэгдэж, нэг дор амьдрах өрхийн тоо нэмэгдэж болзошгүй нь шинээр баригдаж буй орон сууцны ашиглалт, эзэмшилтэй холбоотой үүсч болох нийгэм, гэр бүлийн асуудлуудад орно. Бусад болзошгүй асуудлууд нь шинэчлэгдсэн, орчин үеийн инженерийн шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ, эрчим хүчний хэмнэлттэй барилгын технологи зэргээс урган гарч болох юм.

Тогтвортой ундны усны хангамж

39. I шатлалын хувьд үүсэж болзошгүй нөлөөлөл бол хэт их хэрэглээнээс шалтгаалж усны хомсдол үүсэх явдал юм. Нэмэлт насос ашиглаж эсвэл худгаас татсан өргөтгөж сайжруулсан усан хангамжийн сүлжээгээр дамжуулан аймаг, сумын төвүүдэд хүргэхээр төлөвлөж буй ундны усан хангамж тогтвортой байх ёстой. Усан хангамжийн эх үүсвэрийг хэмжээ, чанарын хувьд найдвартай байх байдлыг нь тогтоох үүднээс зураг төслийн нарийвчилсан шатанд гүний болон гадаргын уснаас хангах эсэхээс үл хамааран хүртээмжтэй байх эсэхийг нь шалгаж баталгаажуулах шаардлагатай. Уур амьсгалын өөрчлөлтөөс бүс нутгийн усны нөөцөд үзүүлэх нөлөөллийг харгалзан ундны усны хангамжийн ирээдүйн тогтвортой байдлын талаар мэдэж байх нь чухал болно.

Агаарт бохирдуулах бодис ялгарах

40. I шатлалд үүсч болзошгүй нөлөөлөл нь 3 аймгийн төв (Улаангом, Өлгий, Жаргалант)-д агаарын бохирдол (CO_2 , NO_x ба SO_x) нэмэгдэх явдал. I шатлалд нүүрсээр галладаг дулааны станцуудын шинэчлэлт өргөтгөл нь одоо гарч буй утааны ялгаруулалтыг (CO_2 , NO_x , SO_x) ихэсгэж болзошгүй. Эдгээр дулааны станцууд нь одоогийн байдлаар үндэсний болон олон улсын утааны хийн найрлагын стандартыг хангаж чадахгүй байна. Энэ нь II, III шатлалын төлөвлөлтөөр дээрх хоёр дулааны станцын утаа цэвэрлэх технологийг ОУСК-ийн БОЭААБ-ын удирдамж (ДЭМБ) дахь үйлдвэрийн утааны хийн найрлагын стандартад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай гэсэн үг юм.

ХАА-н бизнесийн бүрэлдэхүүн хэсэг

i. Тогтвортой усан хангамж

(i) Гадаргуугийн ус

41. ХАА-н бизнесийн бүрэлдэхүүн хэсгийн нөлөөлөл нь зарим ХАА-н бизнесийн хэсгүүдэд усны хомсдол үүсэж болзошгүй бөгөөд улмаар тухайн байршлаас доош орших (урсгалын доорх) ус хэрэглэгчдэд усны хомсдол бий болгох явдал юм. Нөлөөлөл бүх төлөвлөсөн 200 га-гийн ба 500 га-гийн услалтын системд гарч болзошгүй. Иймд техник-эдийн засгийн тооцоо (бүлэг III)-оор 200 га (сумын төвд), 500 га (аймгийн төв)-д шинэ услалтын систем барьж, тэжээлийн аж ахуй эрхлэхэд шаардлагатай, орон нутгийн голоос авах $0.126 \text{ м}^3/\text{сек}$ -аас $0.314 \text{ м}^3/\text{сек}$ хүртэл усны хэрэгцээ шаардлагыг I шатлалын зураг төслийн шатанд нарийвчилан

тооцоолно.

42. Цаашилбал, голын урсацын 2018 оны мэдээллээс үзэхэд тэжээлийн ургамал тарих 500га талбайд шаардлагатай гэж тооцсон $0.314\text{м}^3/\text{сек}$ усалгааны усны хэмжээ нь ойролцоо байгаа усны эх үүсвэр болох голын хамгийн бага урсацын 35%-ийг эзэлж байгааг харуулж байна. Эцсийн байдлаар тогтсон голоос суваг татах цэг дээр усалгааны усны хэрэгцээ, голын усны хамгийн бага урсацын хэмжээг нарийвчилсан зураг төслийн үе шатанд баталгаажуулах шаардлагатай. Түүнчлэн Тариалан сумын Тээлийн голын доод хэсгээр байгуулахаар төлөвлөж буй 500 га-гийн услалтын системийн усны тогтвортой хангамжийг үндэсний гидрогеологичоор баталгаажуулах шаардлагатай ба тэнд хийсэн олон нийттэй зөвлөлдөх уулзалтын дүнгээс үзвэл Тээлийн голын доод хэсэг зуны хэдэн сардаа хуурай байдаг гэдгийг тодорхой хэлсэн байна.

(ii) Гүний ус

43. Услалтын системтэй нэг адилаар, нарийвчилсан зураг төслийн үе шатанд агро-паркад төлөвлөж буй байгууламжуудын буюу мал төхөөрөх газар, хорио цээрийн бүсийн усны хэрэгцээг гүний усны боломжит нөөцөд тулгуурлан тодорхойлох шаардлагатай.

(iii) Гидро-геологийн үнэлгээ

44. Иймд I шатлалын нарийвчилсан зураг төслийн үе шатанд хийх гол ажил бол эцсийн байдлаар тогтоосон голоос суваг татах цэг дээрх урсацын хамгийн бага хэмжээг гидрологийн үнэлгээ хийж тодорхойлох, мөн түүнчилэн голоос доош орших хэрэглэгчдийн нийт хэрэглээний хэмжээг тогтоох явдал юм. Ингэж нийлүүлэн тооцох нь төлөвлөж буй усалгаатай тариалангийн болон бусад хэрэглээ, ус ашиглагчдын хувьд голоос усыг тогтвортой авч хэрэглэх хэмжээг тодорхойлох болно. Төслийн ажлын талбайнуудад хийх гидро-геологийн судалгааны нэгэн адилаар агро-паркад ашиглах газрын дорх усны нөөц төслийн нөлөөлөлд өртөх газрын дагуух бусад хэрэглэгчдийн хувьд мөн хангалттай байгаа эсэхийг баталгаажуулах шаардлагатай. Усны төсвийн мэдээллийн хамт судалж, төслийн хувьд усны тогтвортой нөөц байгаа эсэхийг тодруулна.

ii. Тариалангийн услалтын системээс Увс нуурийн дархан цаазат газарт үүсэх нөлөөлөл

45. Тариалан суманд төлөвлөгдсөн 2 төрлийн услалтын систем дархан цаазт Увс нууранд цутгадаг нэг голоос ус авна. Гэхдээ тухайн голоос авах усны хэмжээ харьцангуй бага, мөн Хархираа-Тээлийн голын мэдээллээс үзвэл тус гол зундаа Увс нуур хүрэхээсээ өмнө хатаж тасардаг тул Увс нууранд үзүүлэх нөлөөлөл бараг байхгүй байхаар байна.

АСХХОХ-ийн бэлэн байгаа байгууламжууд

46. 3 аймгийн төвд "бэлэн байгаа байгууламж" (АХБ-ХБББ 2009 он) нь хаягдал ус цэвэршүүлэх байгууламж (ХУЦБ) ба дулааны станц юм. 3 аймгийн ХУЦБ-ийг I шатлалын хугацаанд хаягдал ус цуглуулах, цэвэршүүлэх системийн ерөнхий сайжруулалтын хүрээнд бүрэн солих юмуу дахин төлөвлөнө. ХУЦБ-ийг анх байгуулах үеийн Зөвлөлтийн технологи тэр үед төлөвлөснийхөө дагуу явагдах боломжгүй болж, улсын эсвэл ОУСК-БОЭААБУ-ийн ажлын болон байгаль орчныг хамгаалах стандартуудын шаардлагыг хангахгүй болсон тул ХУЦБ-ийг шинэчлэнэ. Иймд ХУЦБ-ийн засаж, залруулах арга хэмжээ (ХБББ 2009)-ний үр дүн нь АСХХОХ-ийн I шатлалаар шинээр барих эсвэл бүрэн сайжруулах ХУЦБ байна.

47. Төсөл 3 аймгийн төвийн дулаан (халуун ус)-ны шугам сүлжээг сайжруулахад төвлөрнө. 3 аймгийн одоо байгаа ДС шугам сүлжээг сайжруулахаар төлөвлөж буй ажилд багтаагүй,

зөвхөн нэг ДС-д насос солино. I шатлалын нарийвчилсан зураг төслийн шатанд ДС-ийн технологи, ажиллагаа, байгаль орчны хамгааллын менежмент зэргийг нарийвчилан судалж, II шатлалд ДС-ийн засварлах шаардлага бий эсэхийг тогтооно. ДС-ийн компаниудад очиж, зөвлөлдөх уулзалт хийх явцад тэдгээр станциас гарч байгаа ялгарлын хэмжээ улсын, улмаар олон улсын чанарын стандартуудад хүрэхгүй байгаа нь тогтоогдсон. Иймд одоо байгаа ДС-дад шаардлагатай, II шатлалын хугацаанд хэрэгжүүлэх *залруулах арга хэмжээ* I шатлалын нарийвчилсан зураг төслийн шатанд гүйцэтгэнэ.

Хуримтлагдсан болон өдөөгдсөн нөлөөлөл

48. Өмнө дурдсанчилан АСХХОХ-өөс гарах хамгийн гол хуримтлагдах нөлөөлөл бол хотын дэд бүтэц, нийтийн аж ахуйн үйлчилгээг иж бүрэн сайжруулснаар төсөлд хамрагдсан орон нутгийн иргэдийн амьжиргааны түвшин дээшлэх явдал юм. Түүнчилэн гэр хорооллын дахин төлөвлөлтөөс үүдэж гарах өдөөгдсөн нөлөөлөл нь гэр бүлийн хөгжилд хувь нэмэр оруулсанаар хувь хүний болон гэр бүлийн эрүүл мэндийн байдал дээшилж улмаар гэр хорооллын нийгэм, эдийн засгийг бэхжүүлэх явдал болно.

49. АСХХОХ-өөс үзүүлэх өөр нэг эерэг өдөөгдсөн нөлөө бол ирээдүйд малын тоо толгойг багасгаснаар сэргээн сайжруулсан бэлчээрт CO_2 -ийн шингээлтийг нэмэгдүүлэх, малаас ялгарах метаны (CH_4) хийг бууруулах гэсэн хоёр хэлбэрээр уур амьсгалын өөрчлөлтийг багасгахад хувь нэмэр оруулах явдал юм.

50. Төслөөс хуримтлагдан үүсч болзошгүй сөрөг нөлөөлөлд төслийн ус ашиглах бүрэлдэхүүн хэсгүүдийн улмаас усны хомсдол үүсгэх эсвэл одоо байгаа усны хомсдлыг улам нэмэгдүүлэх нөлөөлөл орно. Ус ашиглах бүрэлдэхүүн хэсгүүдэд хотын ундны усны хангамжийн өргөтгөл (гүний ус), шинэ услалтын систем (гадаргуугийн ус) болон мах боловсруулах үйлдвэр (гүний ус) зэрэг ХАА-н бизнесийн төлөвлөгдөж буй хэсгүүд орно.

С. Уур амьсгалын өөрчлөлт

51. АСХХОХ-ийг хамтран санхүүжүүлэхээр Уур амьсгалын ногоон санд (УАНС) явуулсан хүсэлтэд АСХХОХ-өөс авч хэрэгжүүлэх уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах арга хэмжээг тооцож тусгасан. Түүнчилэн тусад нь боловсруулсан АСХХОХ-ийн Уур амьсгалын эрсдлийн үнэлгээгээр (УАЭҮ) I шатлалын дэд бүтцийн зарим бүрэлдэхүүн хэсгүүдийн цаг уурын өөрчлөлтөд дасан зохицоход зориулагдсан нэмэлт зардлын тооцоог гаргасан.

1. Карбоны ул мөрийг бууруулах

52. АСХХОХ-ийн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авах арга хэмжээ нь малын ашиг шимийг нэмэгдүүлснээс үүдэж малын тоо толгойг бууруулснаар ирээдүйд сэргээгдэх бэлчээрт хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлж, малаас ялгарах метан хийг (CH_4) багасгахад чиглэнэ. Уур амьсгалын ногоон сан (УАНС)-д өргөн барьсан тусдаа санхүүжилтийн санал (СС)-аар хөрөнгө оруулалтын нийт хугацаанд хөрсний карбон хуримтлал нэмэгдэж, 94,0 сая $\text{tCO}_2\text{э}$ ялгарал шууд буурах ба малын тоог бууруулж, метан, азотын ислийн 17,2 сая $\text{tCO}_2\text{э}$ ялгарал шууд буурна. Нийт хөрөнгө оруулалтын хугацаанд хотын цахилгаан эрчим хүчний хэмнэлт болон сэргээгдэх эрчим хүчний бүрэлдэхүүн хэсгүүдийн үр дүнд 1,1 сая $\text{tCO}_2\text{э}$ шууд ялгарал, нийт 112,3 сая $\text{tCO}_2\text{э}$ ялгарал буурна.

2. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээний өртөг

53. I шатлалаар хийгдэх аймаг, сумын төвийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авах арга хэмжээний нэмэгдэл зардал нь ус зайлуулах ажилд

309 035 ам. доллар, үерийн хяналтанд 4 851 143 ам.доллар, хог хаягдлын менежментэд 202 900 ам.доллар, усан хангамжид 89 647 ам.доллар тус тус болж байна.

IV. АСХХОХ-ИЙН ДАРААГИЙН ШАТЛАЛЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ

54. Энэ бүлэгт АСХХОХ-ийн цаашдын ээлжийн төслүүдэд БОАЖЯ, АХБ-ны шаардлагад нийцсэн байгаль орчны магадлан шинжилгээ (МШ) хийх, байгаль орчны хамгааллын баримт бичгүүдийг боловсруулах үе шатуудыг тоймлож тусгасан болно. Хамгаалалтын үйл явц нь I шатлалын ТЭЗҮ боловсруулах явцад маш нягт нямбай гүйцэтгэсэн байгаль орчны хамгааллын арга хэмжээнүүдэд суурилж, түүнийг залгамжлан үргэлжлүүлэх бөгөөд инженерийн болон хөдөө аж ахуйн төслийн багуудтай хамтран ажиллах явцад олж авсан төслийг хэрхэн тухайн газар нутагт нь боловсруулах тухай мэдлэгийг онцлон харуулж байгаа болно.

A. АСХХОХ-ийн дараагийн шатлал

55. II шатлалыг боловсруулах үед I шатлалын бүрэлдэхүүн хэсгүүдийг цаашид хөгжүүлэхээр төлөвлөж байгаа боловч АСХХОХ-ийг шинэ аймаг сумдыг хамруулан өргөжүүлэх нь илүү чухал байна. II, III шатлалд дэд бүтэц, ХАА-н бизнесийн хөрөнгө оруулалтын хамрах хүрээ өөрчлөгдөхгүй гэж үзэж байна. I шатлалын БОТБҮ-ний гол үр дүнгүүдийг (өмнөх бүлгээс авлаа) АСХХОХ-ийн цаашдын хөгжилд шаардлагатай байгаль орчны менежментийн болон болзошгүй нөлөөллийн тухай ойлголт өгөх зорилгоор БОҮХХ-д оруулсан болно. БОҮХХ нь АСХХОХ-ийн дараа дараачийн ээлжийн хувьд хүрээлэн буй орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийг тодорхойлох, ерөнхий зохицуулалтыг нь удирдан чиглүүлэх болно.

1. Шинжилгээ ба ангилал

а. Эхний шинжилгээ

56. Аймаг, сумын төвүүдийг АСХХОХ-ийн ээлжид хамруулж болох эсэхийг тодорхойлдог байгаль орчны бус болон төслийн бүрэлдэхүүн хэсэгт тавигдах онцлог бүхий олон тооны шалгуурууд байдаг. Төр засаг, нийгмийн сонирхол, одоо байгаа дэд бүтцийн нөхцөл байдал, нийгэм эдийн засгийн хэрэгцээ, агро-бизнесийн чадавхи зэрэг бусад байгаль орчны бус шалгуурууд байдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. I шатлалын байгаль хамгааллын талаарх үүрэг хариуцлагаас ургаж гарсан мөн ялангуяа АХБ-ны шинжилгээний үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг дурдвал:

- (i) АСХХОХ-ийн I шатлал нь байгаль орчны чиглэлээр В ангилалд орж байгаа тул дараагийн ээлж нь АХБ-ХБББ-т (2009) тодорхойлсоны дагуу А ангилалд хамаарахгүй харин зөвхөн В юм уу С ангилалд л хамаарагдана гэсэн үг болно.
- (ii) АСХХОХ-ийн ХАА-н бизнесийн болон МАА-н бүрэлдэхүүн хэсгүүд нь хот сууринаас зайтай, бэлчээрийн задгай орчинд байрладаг. I шатлалын туршлагаас үзэхэд төлөвлөж буй хөрөнгө оруулалт нь Дархан цаазат газар, Байгалийн цогцолборт газар, Байгалийн нөөц газар зэрэг Тусгай хамгаалалттай газар (ТХГ) нутагт эсвэл түүний ойролцоо биш гэдгийг баталгаажуулахад чиглэсэн үнэлгээ шаардлагатай байгааг харуулж байна.

Тухайлбал тухайн орон нутагт очиж ажиллах явцад хийсэн хяналт шинжилгээний дараа I шатлалд төлөвлөж байсан Ховд аймгийн Манхан, Мянгад сумууд дахь ХАА-н бизнесийн бүх бүрэлдэхүүн хэсгүүдийг байгалийн нөөц болон цогцолбор газрын нутагт байрлаж байсан тул төслөөс хассан.

Иймд байгаль орчны А ангиллын шаардлагууд I шатлалаас шигшигдэж хасагдсан болно (дор үзнэ үү). Тусгай хамгаалалттай газар нутаг руу урсдаг гол дагуу барихаар төлөвлөж буй услалтын систем тухайн ТХГН-т сөрөг нөлөөлөлгүй, учир нь гол зундаа хуурай болж, ТХГН-т хүрдэггүй, мөн услалтын системд зориулан чиглэлийг нь өөрчлөхөөр төлөвлөж буй усны хэмжээ маш бага, гол урсацын 3%-тай тэнцүү байна.

- (iii) Өмнөх (ii)-р хэсэгт нэмж хэлэхэд тухайн ээлжийн бүрэлдэхүүн хэсгүүдийн байршлыг тогтоохдоо ховор эсвэл нэн ховордсон амьтдын амьдардаг орчинд буюу түүний ойр орчмын нутаг дэвсгэрт (АХБ-ХБББ 2009) байршуулах ёсгүй.
- (iv) Орон нутгийн тогтвортой усны нөөц (гүний болон гадаргын ус) нь АСХХОХ-ийн хөрөнгө оруулалтын бүрэлдэхүүн хэсэг болон бусад хэрэглэгчдийн усны хэрэгцээг хангахуйц байх ёстой.

Тухайлбал төлөвлөж буй тэжээлийн ургамал тариалах усалгаатай 500 га талбай руу Жаргалант орчимд Буянт голоос ус татаж өгөх нь одоо тулгараад буй усны хомсдолын бэрхшээлийг улам хурцатгаж голоос доош орших хэрэглэгчдэд асуудал үүсгэнэ гэж аймгийн Усны сав газрын захиргаанаас үзсэн учраас төлөвлөж байсан услалтын системийг хассан. Ийнхүү А ангилалд заагдсан байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нөхцөл I шатлалаас хасагдсан болно (доорхийг үзнэ үү).

- (v) Тухайн шатлалд хамрагдах бүрэлдэхүүн хэсгүүдэд зөвхөн Монгол Улсын Засгийн газрын дүрэм журамд нийцсэн хөрөнгө оруулалт, мөн БОНБУ-ний тухай хууль болон Соёлын өвийн тухай хуулиар хориглоогүй үйл ажиллагаа л хамрагдах ёстой (Хавсралт Б-г үзнэ үү).
- (vi) Тухайн ээлжийн бүрэлдэхүүн хэсгүүдэд ХБББ-ийн 5-р хавсралтад (2009) заагдсан АХБ-аас хориглосон үйл ажиллагааг оруулах ёсгүй.

2. АХБ-ны төслийн ангилал

57. Дээр дурдагдсан АСХХОХ ба АХБ-ны үндсэн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу эхний хяналт шинжилгээг гүйцэтгэсний дараа хийгдэх хамгааллын алхам нь АХБ-аас тавьдаг үнэлгээний эцсийн шаардлагатай түвшинг тодорхойлохын зорилгоор АХБ-ны бүрэн шалгуур шинжилгээг хийх явдал юм. Энэхүү шалгуур шинжилгээ нь төслийн талаар олон нийттэй хийх зөвлөгөө, түүнээс урган гарах шаардлагатай байгаль орчны менежментийн хэр хэмжээг тодорхойлдог.

58. Тусгай хамгаалалттай газар нутаг, зэрлэг ан амьтдын амьдрах орчин, биологийн ховор эсвэл нэн ховордсон зүйлүүд, сүм дугана зэрэг аливаа экологийн болон соёлын үнэт нөөц байгаа эсэх талаар хяналт шинжилгээ хийх, төслийн болзошгүй нөлөөллийн ерөнхий хамрах хүрээг тодорхойлох зорилго бүхий Байгаль орчны түргэвчилсэн үнэлгээг (БОТҮ) БХБЯ гүйцэтгэдэнэ. БОТҮ нь хөгжлийн янз бүрийн салбаруудад учирч болзошгүй нөлөөллүүдийг тодруулах олон төрлийн хяналтын жагсаалттай байна. Жишээ болгож АСХХОХ-ийн I шатлалын анхны БОТҮ-ийн шалгах хуудсыг Хавсралт А-д үзүүлээ.

59. АХБ-ны төслүүдэд хийсэн шалгуур шинжилгээний үр дүнд тухайн төслийг А эсвэл В ангилалд (эсвэл С ангиллын) хамааруулна. Үүнд:

- (i) **Ангилал А** нөхөн сэргээх боломжгүй, олон төрлийг хамарсан, урьд өмнө хийгдэж байгаагүй, байгаль орчинд ноцтой буюу их хэмжээний нөлөөлөл үзүүлэх төслүүдийг хамааруулдаг. Эдгээр нөлөөлөл нь төслийн бодит ажилд хамаарах талбай, барилга байгууламжаас илүү өргөн хэмжээний газар нутагт нөлөөлж болно. Энд БОМТ-г багтаасан БОНБУ хийх шаардлагатай. Төсөлд А

ангиллын нөхцлөөс (байршил г.м.) зайлсхийх боломжтой. Гэхдээ АСХХОХ-ийн ОШСЗШ-ын ээлжүүдийн зураг төслийг зөвхөн В ангиллаар хийх болно.

- (ii) **Ангилал В** төсөл нь хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөө багатай, орон нутгийн онцлогтой, тун цөөн тохиолдолд л нөхөн сэргээх боломжгүй, ихэнх тохиолдолд нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг А ангиллын төслийнхөөс илүү хялбар дөхмөөр төлөвлөх боломжтой. БОМТ-г багтаасан БОТБҮ хийх шаардлагатай.
- (iii) **Ангилал С** төсөл нь хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй эсвэл маш бага байх магадлалтай. Шалгуур шинжилгээ хийсний дараа БОНБҮ юм уу БОТБҮ шаардлагагүй боловч байгаль орчны нөлөөллийг хянан шалгаж, мэдээлж байх шаардлагатай.

60. Төслийн байгаль орчны ангилал нь шууд, шууд бус, өдөөгдсөн болон хуримтлагдсан нөлөөллүүдийг багтаасан хамгийн байгаль орчинд мэдрэмтгий бүрэлдэхүүн хэсгүүдээр тодорхойлогддог. Төслийг сонгоход баримтлах жишээ удирдамжийг харуулбал:

- (i) Техникийн шалтгаанаас хамаарч зайлсхийх боломжгүй л биш бол төслийг байгалийн цогцолборт болон нөөц газар, чийгтэй намгархаг газарт байрлуулахгүй байх.
- (ii) Боломжтой тохиолдолд одоо байгаа аливаа ойн нөөцийг огтолж тайрахаас зайлсхийх, хэрэв зайлшгүй шаардлагатай бол тэдгээрийг үндэсний дүрэм зааврын дагуу хамгийн бага хэмжээгээр гүйцэтгэх, нөхөн төлбөр олгох.
- (iii) Нийгмийн барилга байгууламжийн зураг төсөлд хамрагдаагүй тохиолдолд түүх соёлын ач холбогдолтой хөшөө дурсгал, сүм дугана зэргийг төслийн талбайд хамруулахаас зайлсхийх ёстой.
- (iv) Барилга угсралтын ажил нь хот суурин болон хөдөө орон нутаг дахь төслийн талбайд буюу түүний ойролцоо амьдардаг иргэд оршин суугчдад сөргөөр нөлөөлөхгүй, мөн нийгэм, оршин суугчдын оршин тогтнох байдал, эсвэл тэдний хэвийн амьдралын нөхцөлд ямарваа нэг аюул занал учруулахгүй байх ёстой бөгөөд үүнд ялангуяа угсаатан ястан болон сургууль, цэцэрлэгт хүрээлэн, эмнэлэг зэрэг нийтийн үйлчилгээний газруудыг онцгойлон анхаарах ёстой.
- (v) Шинэ тоног төхөөрөмж, барилга байгууламж, хог хаягдлын үзүүлэлтүүд нь хүлэмжийн хий үүсгэдэг химийн бодис ашиглахаас зайлсхийхэд чиглэсэн олон улсын стандарт, тэргүүн туршлагыг дагаж мөрдөх ёстой. Худалдан авсан бүх тоног төхөөрөмжүүд полихлорбифенилээс (ПХБ) ангид байх ёстой. Хэрэв SF6 (хүхрийн гексафлюорид – хор багатай хүлэмжийн хий (ХХ)) ашигладаг тоног төхөөрөмж суурилуулсан бол агаар мандалд гарах хүлэмжийн хийн талаарх олон улсын хэм хэмжээнээс хэтрүүлэхгүй байх үүднээс хий алдагдахаас урьдчилан сэргийлэх засварын зохистой менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай болно.

61. Дараачийн ээлжид санал болгож буй бүрэлдэхүүн хэсгүүдийг шалгаж, ангилах явцын үр дүнг EAOD SU-ээр хянуулж батлуулах ба АСХХОХ-ийн үе шат нарийн төвөгтэй эсвэл өндөр эрсдэлтэй элемент агуулж буй эсэхийг баталгаажуулна.

62. АСХХОХ-т А ангиллын төлөвлөгдсөн бүрэлдэхүүн хэсэг байхгүй. Гэхдээ олон шатлалт зээлийн нэг хэсэг болохын хувьд, мөн зохих магадлан шинжилгээ хийх АХБ-ХБББ-ийн (2009) заалтын дагуу АСХХОХ-ийн бүх цаашдын шатлалд БОТУ хийж, байгаль орчны ангиллыг баримтжуулах шаардлагатай.

63. АСХХОХ-ийн тухайн ээлжийн зураг төсөлд өөрчлөлт орсон эсвэл болзошгүй гэж үзэж буй нөлөөллүүдэд өөрчлөлт гарсан тохиолдолд төслийн АХБ-ны БОТБУ болон БОМТ-г зураг төсөлтэй уялдуулах, шинээр үүссэн байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг арилгах арга хэмжээний хамт БХБЯ-наас шинэчлэх шаардлагатай. Эдгээрийг бүхэлд нь EAOD SU хянан үзэж батлана.

64. БОАЖЯ, АХБ-ны хамгааллын бодлогын шаардлагыг хангах, дээр дурдагдсан төслийн байршлын онцлог нөхцөлд өртөхгүй байх үүднээс БХБЯ нь АСХХОХ-ийн цаашдын үе шатуудын байршил, зураг төсөл, технологи, бүрэлдэхүүн хэсгүүдийн хувилбаруудыг судалж, шалгуур шинжилгээ хийх шаардлага үүсч болзошгүй. БХБЯ нь шалгуур шинжилгээний үр дүнг АХБ-ны төвд хүргүүлэн хянан шийдвэрлүүлнэ.

3. Төслийн хувилбарын үнэлгээ

65. I шатлалын байгаль орчны магадлан шинжилгээнд үндэслэж БХБЯ нь АСХХОХ-ийн цаашдын үе шатуудын байршил, зураг төсөл, технологи, бүрэлдэхүүн хэсгүүдийн хувилбаруудыг судалж, шалгуур шинжилгээ хийх шаардлагатай болж магадгүй. БХБЯ нь шалгуур шинжилгээний үр дүнг АХБ-ны төвд хянан шийдвэрлэхээр хүргүүлэх ёстой. "Шатлалгүй" хувилбарыг байнга авч үзэж байх хэрэгтэй.

4. МУЗГ-ын төслийн ангилал

66. Монгол Улсын хувьд БОНУ-г гүйцэтгэх үйл явцын эхний алхам бол төсөл эзэмшигч (БХБЯ) нь БОАЖЯ, эсвэл орон нутгийн байгаль орчны газарт хандаж төслийн БОНЕУ-г хийлгэх хүсэлт гаргана. БОАЖЯ эсвэл орон нутгийн БОГ нь БОНЕУ хийлгэх хүсэлтийг хүлээн авах эсэх нь тухайн төслийн ангиллаас хамаарна. АХБ-ны БОТУ-тэй адилаар БОНЕУ нь уг төсөлд шалгуур шинжилгээ хийж, шаардлагатай нөлөөллийн үнэлгээний түвшинг тодорхойлдог. БОНЕУ хийлгэх хүсэлт нь дараах үндсэн мэдээллийг агуулсан байна:

- (i) Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт
- (ii) Хэрэгжүүлэх төслийн талаарх техникийн зураг хавсаргасан нарийвчилсан тодорхойлолт
- (iii) Төслийн техник эдийн засгийн үндэслэл.

67. Дээр танилцуулсанчилан БОАЖЯ юм уу орон нутгийн БОГ-ын аль нэгийн гүйцэтгэсэн АСХХОХ-ийн хөгжлийн төслийн БОНЕУ-ээс гарах үр дүн нь дараах үнэлгээний ангиллын аль нэгд хамаарна:

- (i) Төслийг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгүй (БОННУ)-ээр хэрэгжүүлж болно
- (ii) Төслийг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгүй (БОННУ)-ээр хэрэгжүүлж болох хэдий ч БОМТ-д тусгасан тусгай нөхцөлүүдийг хэрэгжүүлэх болон/эсвэл нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг авах
- (iii) Төсөлд байгаль орчны нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-г бүрэн хийх шаардлагатай
- (iv) Холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн, тоног төхөөрөмж, технологийн зүгээс хүрээлэн буй орчинд ихээхэн сөрөг нөлөөтэй, газрын менежментийн төсөл

байхгүй гэсэн үндэслэлээр төсөл хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй.

68. АСХХОХ-ийн I шатлал нь төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн цар хүрээ, нарийн төвөгтэй байдлаас шалтгаалан БОННУ хийх шаардлагатай. Тиймээс мөн дараагийн ээлжүүдэд ч БОННУ хийх шаардлагатай болно.

В. Нөлөөллийн үнэлгээний тайлан

69. Төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээ нь АХБ-ХБББ-ийн (2009) Хавсралт 1-д тусгагдсан АХБ-ны БОТБҮ-ний тодорхой шат дарааллуудын дагуу хийгдэх ёстой. Үнэлгээний үйл явц нь төслийн үйл ажиллагааны нарийвчилсан тайлбарыг нөлөөлөлд өртөж буй байгаль, нийгмийн орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн нарийвчилсан тайлбартай системтэйгээр холбож өгдөг. Түүнээс гадна БОТБҮ-г барилга үгсралтын өмнөх, барилгын ажлын, ашиглалтын гэсэн төсөл хэрэгжүүлэх гурван үе шатын дагуу логиктой хийж, тайлагнана.

70. Зайлшгүй мөрдөх шаардлагын дагуу (АХБ-ХБББ 2009) цаашдын АСХХОХ-ийн үе шат дахь нөлөөлөл, эрсдлүүдийг тогтоохдоо төслийн дараахь нөхцөл байдлыг харгалзан үзэх ёстой:

- (i) одоо байгаа газар орон, барилга байгууламжууд
- (ii) хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд санхүүжигдээгүй боловч амьдрах чадвар, оршин тогтнох байдал нь тухайн төслөөс гарцаагүй хамааралтай, тэдгээрийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ нь уг төсөл амжилттай хэрэгжихэд зайлшгүй шаардлагатай *холбогдох байгууламжууд*.

Тухайлбал, I шатлалын БОТБҮ-ээр 2 аймгийн төв буюу Улаангом, Жаргалант суманд 2 дулааны станц дагалдах байгууламжийн хамт тодорхойлсон.

- (iii) тухайн хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон тэр нутагт хийгдэж буй ижил төстэй төслүүдээс үүсэх хуримтлагдах нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд, олон нийт
- (iv) тухайн төслөөс үүдэлтэй төлөвлөгдөөгүй боловч урьдчилан таамаглаж болохуйц, хожим буюу өөр байршилд хийгдэж болох арга хэмжээнээс шалтгаалж бий болох нөлөөнд өртөж болзошгүй газар нутаг, олон нийт.

71. БОТБҮ-ийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг доор хураангуйлан харуулав. Үнэлгээний агуулгын жагсаалт тухайлбал АХБ-ны БОТБҮ эсвэл БОНБҮ-ний тайлангийн жишээг Хавсралт D-д үзүүлэв. ЗГ-ын БОННУ, БОМТ-ийн агуулгын жагсаалтыг 16, 17-р зүйлд нэгтгэн харуулав.

- (i) Техникийн бус хураангуй
- (ii) АСХХОХ-ийн хөгжлийн танилцуулга, тодорхойлолт
- (iii) Нөлөөлөлд өртөж буй байгалийн ба нийгмийн орчны талаарх танилцуулга
- (iv) Нөлөөллийн үнэлгээ
- (v) Олон нийттэй зөвлөлдөх, мэдээлэл түгээх, гомдол барагдуулах механизм
- (vi) Үнэлгээний хувилбарууд
- (vii) Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
 - (a) Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
 - (b) Хяналт шинжилгээний төлөвлөгөө

- (c) Институцийн үүрэг ба чадавхийг сайжруулах хэрэгцээ
- (d) Тайланд тавих шаардлага
- (e) Төсөв.

1. АХБ-ны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

72. АСХХОХ-ийн бүх шатлалд аймгийн БОМТ бэлтгэх шаардлагатай. БОМТ БОТБҮ-ийн үр дүнг уламжилж, төслийн шаардлагагүй нөлөөллийг бууруулж, хүлээгээгүй нөлөөллийг тодорхойлж, төсөл хэрэгжүүлэх хугацаанд байгаль орчны хяналт шинжилгээ хийлгэнэ. БОМТ-ийн жишиг агуулгыг Хавсралт D-д танилцуулав.

С. Монгол Улсын болон АХБ-ны байгаль орчны хамгааллыг нэгтгэн хэрэгжүүлэх

73. АСХХОХ-ийн дараагийн шатлалд АХБ, Монгол Улсын БОНБҮ-ийн шаардлагыг хэрэгжүүлнэ. Энэ 2 протоколыг Төслийн хэрэгжилтэд хяналт тавих зөвлөх багийн (ТХХТЗБ) байгаль орчны мэргэжилтэн болон БОНБҮ хийх эрх бүхий ААН (хариуцагч талуудын тодорхойлолтыг G бүлгээс үзнэ үү) хамтран хийнэ. Тодруулбал, БОНБҮ хийх эрх бүхий ААН нь засгийн газрын БОНБҮ-ний шаардлагыг бүрэн хангасан, байгаль орчны төлөв байдлын суурь мэдээг боловсруулж, АХБ-ны БОТБҮ-д шаардагдах олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулна.

74. Давхар хамгааллын арга хэмжээний хэрэгжилтийн явцыг дараах байдлаар нэгтгэв:

- (i) Аймаг, сумын хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шатлалыг АХБ батлана.
- (ii) БХБЯ нь аймагт ажиллах ТХН-ийг байгуулна. ТХН нь БОНБҮ хийх эрх бүхий ААН болон БОТБҮ хийх байгаль орчны мэргэжилтнүүдийг батална.
- (iii) БХБЯ нь АСХХОХ-ийн шатлалын зураг төсөл, хэрэгжилтэд хяналт тавих олон улсын мэргэжилтнийг авч ажиллуулна.
- (iv) ТХХТЗБ нь БОНБҮ хийх эрх бүхий ААН-д БОНБҮ хийх чиглэлээр АХБ болон Монгол улсын ЗГ-аас тавьдаг шаардлагыг хангаж ажиллах техникийн удирдамжийг гаргаж өгөх ба АХБ-ХБББ-ийн (2009) шаардлагыг биелүүлж буй эсэхэд хяналт тавьдаг. БОНБҮ хийх эрх бүхий ААН-ийг ажиллуулж эхэлнэ. БОНБҮ хийх эрх бүхий ААН-ийн ажлын удирдамж, түүнээс урган гарах АСХХОХ-ийн ээлж шатанд зориулсан АХБ-ны БОТБҮ-ний ажлын удирдамжийг Хавсралт Н ба I -ээс тус тус үзнэ үү.
- (v) БОНБҮ хийх эрх бүхий ААН нь Монгол Улсын БОНБҮ-нд тавьдаг шаардлагыг бүрэн хангаж, байгаль орчны суурь нөхцлийн талаархи мэдээллийг боловсруулж, олон нийттэй зөвлөлдөх ажлыг гүйцэтгэнэ.
- (vi) ТХХТЗБ нь шатлалын БОТБҮ/БОМТ-г боловсруулж, БОНБҮ-ийн үндэсний зөвлөхийн оролцоотойгоор БОТБҮ бүрэн хийгдэж дуусна.
- (vii) АСХХОХ-д зориулсан Монгол Улсын болон АХБ-ны хамгааллын арга хэмжээний шаардлагуудыг батална.

D. Олон нийтийн хэлэлцүүлэг, мэдээллийг ил тод болгох

1. Олон нийтийн хэлэлцүүлэг

75. АХБ-ХБББ-ийн (2009) дагуу БХБЯ нь төсөлд хамрагдаж буй аймаг, сумдын төвүүдэд өртсөн иргэд болон холбогдох талуудын зүгээс АСХХОХ-ийн талаархи санал бодол, сэтгэл зовоож буй асуудлыг тодорхойлох зорилгоор утга учиртай хэлэлцүүлэг явуулах ёстой. Нөлөөлөлд өртсөн иргэд төслийн талаархи үзэл бодлоо өөрсдийн оршин суугаа баг, хороондоо өөрсдийн хэлээр чөлөөтэй, тав тухтай байдлаар илэрхийлэх боломжтой үед хэлэлцүүлэг утга учиртай болдог. Олон нийтийн хэлэлцүүлэг нь мэдээ материал эмхэтгэсэн тайлбар тараах, биечлэн уулзаж ярилцах, олон нийтийн албан ёсны уулзалт хэлбэрээр байж болно. АСХХОХ-д зориулсан АХБ-ХБББ-ийн (2009) шаардлагыг хангахуйц олон нийтийн хэлэлцүүлэг, зөвлөгөөн явуулах ерөнхий удирдамжийг Хавсралт Е-д үзнэ үү.

76. Төслийн өмчлөгчийн (доорхийг үзнэ үү) хувьд БХБЯ нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд (2012) заасан олон нийт болон оролцогч талуудтай зөвлөлдөх шаардлагыг хангаж, төслийн талаар олон нийтэд ил тод мэдээлэх, зөвлөлдөх уулзалтыг нөлөөлөлд өртөж буй оролцогч талуудтай хийсэн байх ёстой.

77. Байгаль орчны талаархи бүх баримт бичгийг нийтэд мэдээлнэ. Эдгээр баримт бичгийг Монгол Улсын Засгийн газрын мэдээллийг нээлттэй байлгах журмын дагуу олон нийтийн зүгээс хүссэн тохиолдолд олж авч болохуйцаар нээлттэй байх ёстой. Боломжтой бол олон нийт цахим хуудаст байршуулсан баримт бичигтэй танилцах нь маш үр дүнтэй байдаг. Байгаль орчны магадлан болон хяналт шинжилгээний тайлан зэрэг бүхий л үнэлгээний бичиг баримтыг БХБЯ зохих ёсоор, системтэй хөтөлж, хадгалах ёстой. АСХХОХ-ийн үйл ажиллагаанд агуулгын болон өөр ямар нэг өөрчлөлт орсон тохиолдолд нөлөөлөлд өртсөн өрхүүдийн байгаль орчны талаар тулгарч буй бүх асуудлыг шийдвэрлэх зорилгоор БХБЯ-наас дараагийн зөвлөгөө, хэлэлцүүлгийг зохион байгуулах шаардлагатай.

2. Мэдээллийг ил тод болгох

78. АХБ-ны Олон нийттэй харилцах бодлого болон ХБББ-т (2009) заасны дагуу барилга угсралтын ажил эхлэхээс өмнө АХБ-ны БОТБҮ болон Монгол Улсын Засгийн газрын БОМТ, БОННУ-ний үр дүнгийн талаар орон нутгийн иргэдэд мэдээлэх ёстой. АХБ, АСХХОХ-ийг хэрэгжүүлэгчид болон нөлөөлөлд өртсөн олон нийт, талууд хоорондоо ил тод харилцан уялдаатай байх нөхцлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн тодорхой удирдамж, зааврыг Шинэчлэгдсэн Олон нийттэй харилцах бодлого (ОНХБ)-д тусгасан байна. Салбарын зээлийн хүрээнд олон нийт нь АХБ-ны БОТБҮ, БОМТ-г АХБ-ны цахим хуудаснаас, мөн боломжтой бол БХБЯ-ны цахим хуудаснаас үзэж танилцах боломжтой байх ёстой. БОҮХХ нь төслийн хамгааллын бусад баримт бичгийн хамтаар АСХХОХ-ийн дараа дараачийн үе шатуудыг хэрэгжүүлэхэд АХБ, БХБЯ-ны хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлоход чухал нөлөөтэй. Мэдээллийг ил тод болгох чиглэлээр одоо дагаж мөрдөж буй дүрэм журам нь дор дурдсан гомдол барагдуулах механизмтай шууд холбогдож, түүнд тулгуур дэмжлэг болдог.

E. Гомдол барагдуулах механизм

79. Төслийн нийгэм болон байгаль орчны гүйцэтгэлийн талаархи санал, гомдлыг хүлээн авч үнэлэх, тэдгээрийг шийдвэрлэх ажлыг хөнгөвчлөх зорилгоор төслийн онцлог бүхий Гомдол барагдуулах механизмыг (Хавсралт F) бий болгоно. ГБМ нь төсөлтэй холбоотой нийгмийн болон хүрээлэн буй орчны асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн хурдан шуурхай, ил тод байдлыг бий болгох зорилготой. Төслийн бүх агентлагууд болон нөлөөлөлд өртөж буй талууд ГБМ-ын тухай, мөн төслийн талаар гарч буй аливаа санал, гомдлыг ХА юм уу ТХН-д хэрхэн мэдээлэх тухай мэдсэн байх ёстой.

80. Аймгийн төвүүд дэх төслийн нэгжүүд төслийн талаархи нийгэм болон байгаль орчинтой холбоотой аливаа санал, гомдлыг хүлээн авах, түүнийг шийдвэрлэж байх зорилгоор төслийн ГБМ-ыг бий болгож, ажиллуулна. Аймгийн төвүүд дэх нэгжүүдээс Өмнөговь, Дэлүүн сумдын төвд яг ижил үүрэг бүхий гомдол барагдуулах орон тооны ажилтнуудыг томилж ажиллуулна. ГБМ нь жендерийн баримжаатай, соёл уламжлалын хувьд зохистой, бүх оролцогч талуудад хүртээмжтэй бөгөөд аливаа дарамт залхаалтаас ангид, үнэ төлбөргүй, ойлгомжтой, ил тод үйл явцыг ашиглан нөлөөлөлд өртсөн этгээдүүдийн асуудлыг шуурхай шийдвэрлэнэ. ГБМ нь үндэсний хууль эрх зүйн тогтолцоонд хандах эрхэд садаа болохгүй.

81. Олон нийттэй зөвлөлдөх уулзалтын үеэр нөлөөлөлд өртөж буй иргэд оршин суугчдад ГБМ-ыг танилцуулах ба мөн энэ талаар гурван аймаг, хоёр сумын төвын оролцогч мэдээлнэ. Ямарваа нэг асуудал гомдол гарсан тохиолдолд аймаг, сумын төв бүрт дараах байдлаар 3 хүртэлх үе шаттай арга хэмжээ авна:

- (i) Эхний шат (7 хоногоос хэтрэхгүй): Барилгын ажлын явцад санал гомдол гарсан бол гомдол гаргагч нь асуудлыг гэрээт гүйцэтгэгч, ТХН-ийн ГБМ-ын ажилтнууд, төсөл хэрэгжүүлэх, хяналт тавих зөвлөх (ТХХТЗ) эсвэл олон нийтийн төлөөлөгчид хандан тавьж болно. ГБМ-ын талаар төсөлд хамрагдах бүх байгууллагууд мэдэж байх ёстой бөгөөд, аливаа санал гомдлыг ТХН-ийн ГБМ-ын ажилтнуудад нэн даруй мэдээлэх хэрэгтэй. Хэрэв уг асуудал нөлөөлөлд өртсөн иргэн болон гүйцэтгэгчийн хооронд шууд шийдвэрлэгдсэн бол гомдлын дагуу нэмэлт арга хэмжээ авах шаардлагагүй. Гэхдээ энэ тухай аймаг, сумын төв дэх ТХН дээр байх ГБМ-ын бүртгэлд бичиж тэмдэглэнэ.
- (ii) 2-р шат (15 хоногоос хэтрэхгүй): Хэрэв асуудал аймгийн төслийн нэгжид шийдэгдээгүй бол гомдол гаргагч гомдлоо ТУН-ийн Иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээ (БХБЯ, ГЗБГЗЗГ, ХХААХҮЯ, БАХХ оролцож ажилладаг)-ний албанд амаар юм уу бичгээр гаргаж болно. БХБЯ-ны Нэг цэгийн үйлчилгээний алба ба ТУН-ээс хариуг хоёр долоо хоногийн дотор өгч, болсон бүх үйл явцын талаар тэмдэглэл хөтлөнө.
- (iii) 3-р шат (15 хоногоос хэтрэхгүй): Асуудал шийдэгдээгүй хэвээр байгаа бол ТХН нь шийдэлд хүрэх зорилгоор гомдол гаргагчийн зөвшөөрөлтэйгээр БХБЯ, ТУН болон холбогдох олон нийтийн төлөөллийг оролцуулсан уулзалт зохион байгуулна. Хэрэв асуудлыг огт шийдвэрлэж чадахгүй бол холбогдох дээд шатны байгууллагад шилжүүлнэ. ТУН нь БХБЯ-аар дамжуулж асуудлын явцыг 1-3 дахь шатны аль нэгд байхад нь АХБ-д мэдээлж болох боловч 3-р шатанд хүрсэн тохиолдолд нэн даруй мэдээлэх ёстой.

Хэрэв (I – iii) шатанд асуудлыг амжилттай шийдвэрлэж чадахгүй бол, тухайн асуудлыг АХБ-ны ТТЗА болон НХЗ алба руу уламжилж, шийдвэрлүүлнэ.

82. АСХХОХ-ийн явцад дараах төрлийн санал гомдол гарч болно:

- (i) Гэр хороололд хийгдэж буй барилгын ажил болон замын хөдөлгөөнөөс шалтгаалж дуу чимээ, тоос шороо үүсэх.
- (ii) Барилгын машин механизмын хөдөлгөөний улмаас гэр хороололд замын түгжрэл үүсэх.
- (iii) Зам барилгын ажил хийгдэж, явган хүний зам, гарц хаагдсанаас ус түгээх цэг, худаг руу очих зам төвөгтэй болох эсвэл бүр хаагдах.
- (iv) Барилгын ажлын үе дэх замын хөдөлгөөн, газар шорооны ажлаас шалтгаалж

- иргэд оршин суугчдад учрах бэртэл гэмтлийн эрсдэл нэмэгдэх.
- (v) Дэд бүтцийн барилга угсралтын ажлаас шалтгаалж нийтийн аж ахуйн хангамж үйлчилгээ тасалдах.

V. ИНСТИТУЦИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

A. БОҮХХ-г хэрэгжүүлэх үүрэг

83. АСХХОХ-ийн БОҮХХ-г хэрэгжүүлэх гол этгээдүүд нь БХБЯ, тус яамнаас томилогдсон, ГЗБГЗЗГ-аар ахлуулсан, Улаанбаатар дахь ТУН-ийн байгаль орчны хамгааллын мэргэжилтэн (БОХМ), төсөл хэрэгжүүлэгч агентлагууд, ХБ-ХУК-ийн байгаль орчны хамгааллын ажилтан, аймгийн ТХН-д ажиллах хамгааллын ажилтан (ХА)-ууд, Төсөл хэрэгжүүлэх, хяналт тавих зөвлөх (ТХХТЗ) болон АХБ байна. Холбогдох харьяа газар, агентлагууд болон засгийн газрын яам, байгууллагуудын төлөөллөөс бүрдэх Төслийн удирдах хорооны (ТУХ) болон Гүйцэтгэх ажлын хэсэг (ГАХ) АСХХОХ-ийн БОҮХХ-нд хязгаарлагдмал хэмжээгээр оролцоно. ХБ-ХУК хувийн хэвшлийн санхүүгийн зуучлагчид (СЗ)-ын хүлээх хамгааллын үүргийг хянаж, зохицуулна.

84. АСХХОХ-ийн Гүйцэтгэгч агентлаг (ГА) нь БХБЯ байна. БОҮХХ-ын хэрэгжилт, байгаль орчинтой холбоотой үндэсний болон АХБ-ын хамгааллын бодлого, шаардлагуудын хэрэгжилтийг зохих ёсоор хангах ерөнхий үүргийг БХБЯ хүлээнэ. ГЗБГЗЗГ нь дэд бүтцийн, ХХААХҮЯ нь ХАА-н бизнес, бэлчээрийн бүрэлдэхүүн хэсгүүдэд техникийн мэдээлэл, туслалцаа үзүүлэх болно.

85. ГА нь ТУН болон 3 аймгийн ТХН-ийн ХА-уудаар дамжуулан БОҮХХ-г хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагааг хариуцах ба АХБ болон Засгийн газрын байгаль орчны чиглэлийн дүрэм журмын дагуу гүйцэтгэх АСХХОХ-ийн урьдчилсан үнэлгээний хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавина. УБ-ТУН-ийн БОХА нь аймгуудын ТХН-ийн ХА-уудтай ажлаа сайн уялдуулна. ХА-ууд нь ТУН-ийн БОХА-нд ажлаа тайлагнана.

86. БОХА нь аймгийн ХА-уудтай хамтран дараах үүрэг гүйцэтгэнэ: (i) АСХХОХ-ийн хүрээнд хийгдэх ажлуудыг байгаль орчны шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулж нягтлах, (ii) БОТҮ-г хийж дуусган ангиллыг баталгаажуулахаар АХБ-нд нэн даруй хүргүүлэх, (iii) АСХХОХ-т Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг (БОНЕҮ) БОАЖЯ эсвэл аймгийн Байгаль орчны газраар хийлгэх тухай хүсэлтийг шаардлагатай баримт бичгүүдийн хамт боловсруулж хүргүүлэх, (iv) БОТБҮ боловсруулах, үүний дотор байгаль орчны үнэлгээ хийх Ажлын даалгавар боловсруулах, байгаль орчны үнэлгээ хийх явцад хяналт тавих, БОТБҮ-ний тайлангийн төслийг хянуулж, батлуулахаар АХБ-нд нэн даруй хүргүүлэхэд нь ТХХТЗ-д дэмжлэг үзүүлэх, (v) БОНЕҮ-ний нөхцлийн дагуу байгаль орчинд нөлөөлөх үнэлгээ, шаардлагатай олон нийтийн хэлэлцүүлэг, мэдээлэл түгээх ажлыг БОАЖЯ-д бүртгэлтэй дотоодын БОНБҮ-ний зөвлөх компаниар гүйцэтгүүлэх, (vi) БОННҮ, БОМТ-ний тайлангуудыг зохих хугацаанд нь БОАЖЯ эсвэл аймгийн Байгаль орчны газраар батлуулах, (vii) БОНЕҮ-ний дүгнэлт, БОННҮ болон БОМТ-г хянасан дүгнэлт, баталгаажуулалтын хувийг АХБ-нд хүргүүлэх, (viii) Гомдол барагдуулах механизмын гүйцэтгэл, хэрэгжилтийг хангуулах, (ix) ТХН-ийн хариуцах байгаль орчны хяналт шинжилгээний ажлуудыг гүйцэтгэх; (x) БОҮХХ-ний баримтлал/хэрэгжилт болон БОМТ-ний хэрэгжилтийн байдлыг тайлагнах үүрэгтэй. БОХА болон аймгийн ХА-ууд нь ТХХТЗ-төй нягт хамтран ажиллана.

87. Төсөл хэрэгжүүлэх, хяналт тавих зөвлөх (ТХХТЗ) нь АСХХОХ-ийн нарийвчилсан зураг төслийг гүйцэтгэж дуусгах явцыг ерөнхийд нь хянаж, төслийн хэрэгжилтийн явцад хяналт тавина. ТХН-ийн хамгааллын мэргэжилтэн, ТХХТЗ-ийн байгаль орчны олон улсын мэргэжилтэн (БООУМ)-ний дэмжлэгтэйгээр АХБ-ны БОТБҮ-г хийж, АСХХОХ-ийн БОМТ-г

боловсруулна. БООУМ нь БОНБУ хийх эрх бүхий ААН-тэй хамтран төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны суурь судалгааг хийж, байгаль орчны талаархи олон нийттэй зөвлөлдөх зохистой хэлэлцүүлгийг хийх чиглэлээр зөвлөлгөө өгнө. АСХХОХ-ийн чадавхийг хөгжүүлэх, институцийг бэхжүүлэх бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд БООУМ нь БОНБУ-ний дотоодын компанитай хамтран ТХН-ийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэнд зориулан БОУХХ-г хэрэгжилт, байгаль орчны үнэлгээ ба менежментийн чиглэлээр сургалт зохион байгуулж, техникийн дэмжлэг үзүүлнэ. ТХН-ийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн нь цаашдаа БОНБУ хийх эрх бүхий ААН-тэй хамтран АСХХОХ-ийн байгаль орчны менежментийн сургалтыг ТХН болон гүйцэтгэгчид зориулан зохион байгуулна.

88. БОАЖЯ эсвэл аймгийн Байгаль орчны газар (БОГ) нь: (i) АСХХОХ-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой БОНБУ-г (анхны шалгуур үнэлгээ) хийнэ, (ii) БОНБУ-нд АСХХОХ-ийг хэрэгжүүлэхэд хийгдэх байгаль орчны үнэлгээний шаардлагатай түвшин (БОМТ, БОННУ-ний аль нь болох) болон байгаль орчны үнэлгээний дэлгэрэнгүй агуулгыг тодорхойлон тусгана, (iii) шаардлагатай тохиолдолд бодлогын баримтлал/шаардлагын талаар зөвлөмж, чиглэл өгнө, (iv) БОННУ, БОМТ-ний гүйцэтгэлийг баталгаажуулна.

89. АХБ нь: (i) БОТУ-ний шалгах хуудсыг нягтлан хянаж, төслийн дараачийн үе шатуудын ангиллыг батална, (ii) ОНОСХШТ-ийн дараачийн үе шатуудын БОТБУ/БОНБУ-г батлаж, ил тод мэдээлэхийн өмнө хянана; (iii) байгаль орчны мониторингийн явцын тайлангуудыг хянана, (iv) байгаль орчны хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгүүдийг ажиллуулна, (v) шаардлагатай тохиолдолд АХБ-ны ХБББ-ийн (2009) шаардлагуудын талаар зөвлөлгөө, чиглэл өгнө, (vi) АХБ-ны мэдээллийн ил тод байдлын бодлогод нийцүүлэн байгаль орчны мониторингийн тайлангуудыг тус банкны цахим хуудсанд нээлттэй байршуулна, (vii) Салбарын зээлийн хувьд хамгаалалтай холбоотой эрсдэл болон асуудлууд, эрсдлийг бууруулах, аливаа асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээг АСХХОХ-ийн батлагдсан үе шатуудын гүйцэтгэлийн жилийн нэгдсэн тайлангуудад тусгана.

90. Гүйцэтгэх ажлын хэсэг (ГАХ) болон шаардлагатай бол Төслийн удирдах хороо (ТУХ) нь: (i) холбогдох бодлого, зээлийн гэрээний дагуу байгаль орчны хамгааллын шаардлагуудын талаар шаардлагатай тухай бүр удирдамж чиглэл өгнө, (ii) төрийн түвшинд арга хэмжээ авах шаардлагатай байгаль орчны менежментийн асуудлуудаар шийдвэр гаргана.

VI. СУРГАЛТ БА ЧАДАВХИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

91. Байгаль орчны менежментийн чиглэлээр ТХН, ГА болон БХБЯ-ны ажилтнуудын чадавхийг дээшлүүлж, сургаснаар БОУХХ-г үр дүнтэй хэрэгжүүлэхэд түлхэц үзүүлнэ. Сургалт болон чадавхи дээшлүүлэх ажлыг ТХХТЗБ-ийн байгаль орчны ажилтнуудаас ТХН-ийн хамгааллын асуудал хариуцсан ажилтнууд болон хэрэгцээтэй гэж үзвэл БХБЯ-ны бусад ажилтнуудад явуулна. ТХХТЗБ-БООУМ нь техникийн дэмжлэг туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ БОУХХ-тэй холбоотой сэдвээр лекц, семинар зохион байгуулах ба БОУХХ-ний хэрэгжилт нь ТХН, ялангуяа ТХН-ийн байгаль орчныг хамгаалах болон бусад чиглэлийн ажилтнууд, хэрэгжүүлэгч агентлаг, гүйцэтгэгч компанийн хувьд “биечилсэн сургалт” болно. Боломжтой бол сургалт, чадавхийг хөгжүүлэх үйл ажиллагаанд БОНБУ-ийн чиглэлээр мэргэжсэн дотоодын шинжээчдээр хичээл заалгана. Сургалт, чадавхижуулах үйл ажиллагааны хүрээнд боломжтой бол үндэсний БОНБУ-ний мэргэжилтнүүд семинар өгдөг байх нь зүйтэй. Сургалтын сэдвүүдийн ерөнхий жишгийг Хүснэгт 4-д үзүүлэв.

VII. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ БА ТАЙЛАГНАХ

92. АХБ-ны БОМТ-ний нэг хэсэг болгон БХБЯ-аас ТУН болон ТХХТЗБ-ийн дэмжлэгтэйгээр АСХХОХ-ийн үе шатуудын байгаль орчны нөлөөлөл болон байгаль орчны ерөнхий менежментэд хяналт шинжилгээ хийж, баримтжуулах тайлангийн протоколыг боловсруулна. Төслийн барилгын ажил болон үйл ажиллагааны үе шатанд АХБ-нд илгээх жил тутмын БОМТ-г ТУН-ийн байгаль орчны хамгааллын ажилтан аймгийн нэгжийн ХА-ууд болон ТХХТЗ-ийн ажилтнуудын дэмжлэгтэй бэлтгэнэ. Үүнтэй нэгэн адилаар аймгийн ТХН-ийн дотоодын дүрэм журмын дагуу аймгийн ТХН дотоодын БОМТ-ний хэрэгжилтийн жилийн тайланг БХБЯ-ны нэрийн өмнөөс бэлтгэж, ХА болон АСХХОХ-ийн БОННУ-г хийсэн байгаль орчны газарт тухайн оны 11 дүгээр сарын 1-ний өдөр хүргүүлнэ. Төсөл хэрэгжих явцад зохион байгуулагдсан олон нийттэй зөвлөлдөх аливаа уулзалт хэлэлцүүлгийн үр дүнг мөн уг тайланд тусгана.

93. АХБ-ны БОМТ-нд тусгагдсан нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн үр дүн болон төслөөс хүлээгдээгүй байсан байгаль орчин, нийгмийн аливаа нөлөөллийг байгаль орчны тогтмол тайлангуудад баримтжуулан тусгана. БОМТ хэрхэн амжилттай хэрэгжиж байгаад хяналт хийхээс гадна зөвшөөрөлтэй холбоо бүхий үүргийн гүйцэтгэлд хяналт тавина.

Хүснэгт 4. ТХН ба ГА-т зориулсан сургалттын сэдвийн жишээ

1.0 Монгол улсын хууль эрх зүйн орчин ба АХБ-ны хамгааллын шаардлагууд

- A Монгол Улсын байгаль орчны үнэлгээ, менежментийн холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартууд
- b АХБ-ны ХБББ 2009
- c АХБ ба Монгол Улс: АСХХОХ-ийн БОУ-ний журам

1.1 БОУ-ний үйл явц ба байгаль орчны менежментийн асуудлууд

- a Зохистой зөвлөлдөх хэлэлцүүлэг, мэдээлэл
- b Мэдээллийн ил тод байдал ба гомдол баргадуулах механизм
- c Байгаль орчны хариуцлагатай худалдан авалт
- d Хөдөлмөрийн болон олон нийтийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа

1.2 Аймгийн БОМТ-ний хэрэгжилт

- a Хэрэгжүүлэлтийн зохицуулалт
 - Байгууллагуудын хүлээх үүрэг
 - Орчны хяналт шинжилгээ ба тайлан
- b Онцгой байдлын үед авах арга хэмжээ
- c Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд

94. Хяналт хийх, тайлагнах үйл явц нь дээр дурдсан олон нийттэй зөвлөлдөх,

мэдээллийн ил тод байдлыг хангах, гомдол барагдуулах ажлын хүрээнд БХБЯ болон нөлөөлөлд өртсөн иргэд, олон нийтийн хооронд үүсгэх харилцааны механизмын үүргийг гүйцэтгэнэ. Төслийн хэрэгжилтэд хийсэн хяналтын тайланг нөлөөлөд өртсөн олон нийтэд нээлттэй байлгана.

95. Барилга угсралтын шатанд БОМТ-ний явцыг гүйцэтгэгч болон ТХН хамтран ТХХТЗ-ийн дэмжлэгтэйгээр ГА/БХБЯ-нд тайлагнана. Энэ ажиллагааг эхлүүлэхийн тулд эхлээд гүйцэтгэгчийн байгаль орчны мэргэжилтэн Гүйцэтгэгчийн БОМТ-ний сар тутмын тайланг ТХН-ийн хамгааллын ажилтанд хүргүүлнэ. Гүйцэтгэгчийн сар тутмын тайланг ТХН дээр улирлаар нэгтгэн ГА, ХА-д хүргүүлэх бөгөөд дээр дурдсанчлан уг тайлангуудыг нэгтгэн жилийн тайлан болгож Аймгийн байгаль орчны газарт хүргүүлнэ. Төслийн хэрэгжилтийн туршид ТХН нь ТХХТЗБ-ийн дэмжлэгтэйгээр байгаль орчны хяналт шинжилгээний улирлын тайлангуудыг хагас жилээр нэгтгэн АХБ-нд хүргүүлнэ. БОМТ-ний хэрэгжилтэд гарсан ахиц, ялангуяа нөлөөллийг бууруулах болон хяналт шинжилгээний талаар тус төлөвлөгөөнд тусгагдсан шаардлагуудын хэрэгжилтийг уг тайлангуудад тусгана. Байгаль орчны тайлангийн загварыг Хавсралт G-д үзүүлэв.

ХАВСРАЛТ А: АСХХОХ-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТҮРГЭВЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ (БОТУ)

ХОТ БАЙГУУЛАЛТ

Байгаль орчны түргэвчилсэн үнэлгээний (БОТУ) шалгах хуудас

ХОТ БАЙГУУЛАЛТ
ХУУДАС 1/5

Байгаль орчны түргэвчилсэн үнэлгээний (БОТУ) шалгах хуудас

Заавар:

- (i) Тус төслийн баг нь төслийн байгаль орчны ангиллыг дэмжихийн тулд энэхүү шалгах хуудсыг бөглөнө. Байгаль орчны ангиллын маягтад тус шалгах хуудсыг хавсарган Байгаль орчин, хамгааллын хэлтэс (БОХХ) рүү илгээн, БОХХ-ийн дарга болон нийцлийн ахлах ажилтнаар батлуулна.
- (ii) Энэхүү шалгах хуудас нь байгаль орчны тулгамдаж буй асуудалд төвлөрнө. Нийгмийн хэмжигдэхүүнийг зохих хэмжээгээр харгалзан үзсэн байхын тулд мөн АХБ-ын (а) сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт ба уугуул иргэдийн шалгах хуудас, (б) ядуурлыг бууруулах гарын авлага, (в) зөвлөлдөх ба оролцоог хангах ажилтнуудад өгөх удирдамж болон (г) жендэрийн шалгах хуудас зэргийг харгалзан үзнэ.
- (iii) **“Нөлөөллийг бууруулах ажил хийгдээгүй” тохиолдол гэж үзэн асуултанд хариулна уу. Ингэснээр боломжит нөлөөллийг тодорхойлох зорилготой. Аливаа урьдчилан төсөөлсөн нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэлэлцэхдээ “тайлбар” хэсгийг ашиглана уу.**

Улс/төслийн нэр:
Салбар:

MON (49430): Аймаг, сумын хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр
(I шатлал)
Хот байгуулалт

Шалгах асуултууд	Тийм	Үгүй	Тайлбар
А. Төслийн хамрах газар			
Төсөл хэрэгжүүлэх газар			
▪ Хүн ам нягт суурьшсан?		✓	
▪ Бүтээн байгуулалтын үйл ажиллагаа ихтэй?		✓	
▪ Байгаль орчны эмзэг нутаг дэвсгэртэй хөрш залгаа эсвэл дотор нь байрладаг?			
• Соёлын өвийн дурсгалт газар	✓		Баруун кластерт Казак үндэстний цөөнхийн соёлын газар байж болзошгүй.
• Тусгай хамгаалалттай газар нутаг	✓		Ховд хотын зүүн хил нь дархан цаазат “Хар ус нуур”-ын орчмын буфер бүсийн баруун хилийн нутаг дэвсгэрээс 20 км-ын зайд оршдог. Улаангом хотын зүүн хойд хил нь байгалийн цогцолбор газар болох “Увс нуур”-ын баруун хилээс 25 км-ын зайд байрладаг.
• Намагт газар	✓		Баруун кластерт харъяалагдах Ховд хотын залгаа намагт газартай. Бусад газрын ойр орчимд намагт газар байхгүй.
• Ой мод		✓	
• Голын ай сав		✓	
• Тусгай хамгаалалттай газрын буфер бүс	✓		Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай дээрхийг үзнэ үү.

Шалгах асуултууд	Тийм	Үгүй	Тайлбар
• Биологийн олон янз байдлыг хамгаалах тусгай газар нутаг		✓	Хот суурингийн кластертэй залгаа биологийн олон янз байдалт чухал газар байхгүй болно.
• Далай, тэнгисийн булан		✓	
Б. Байгаль орчинд үзүүлэх боломжит нөлөөлөл Тус төсөл нь дараах нөлөөллийг үүсгэх үү? Үүнд:			
• Холбогдох ариун цэврийн байгууламж ба хог хаягдлыг зайлуулах системийн тогтвортой байдал, хотын бусад үйлчилгээнд харилцан хамаарах байдалд үүсэх нөлөөлөл		✓	Төсөлд хамрагдсан газрууд зохистой ариун цэврийн байгууламж ба хог хаягдал зайлуулах байгууламжгүй байна. Тус төслийн оролцоотойгоор тохирох ариун цэврийн байгууламж болон хог хаягдлыг зайлуулах системийг байгуулна.
• Хотын хүн амын хурдацтай өсөлт, арилжааны болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас эргэн тойрны байгаль орчинд доройтол, хог хаягдлын хэмжээ нэмэгдэж хүний гараар бүтсэн болон байгалийн системүүд хэт ачааллалтай болсон, эдгээр системийн менежмент хийх хүчин чадал хэтэрсэн эсэх		✓	Төслийн оролцооны үр дүнд хот суурингийн кластерт хүрэн буй орчны нөхцөл байдал сайжирна.
• Газар, эко систем (т: намагт газар, онгон дагшин газар нутаг, эргийн бүс, цэвэр усны сан ба ой)-ийн доройтол үүссэн эсэх		✓	Тус төслийн дэд бүтэц нь газрын доройтол цааш нэмэгдэхийг зогсоох ба хүрээлэн байгаа орчны экосистемийг тогтворжуулна.
• Иргэдийг өөр байршил руу шилжүүлэх эсвэл сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт хийх эсэх	✓		Дэд бүтэц байгуулах тул иргэдийг өөр байршил руу шилжүүлэх эсвэл сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт бага хэмжээнд байна. Дэд бүтцийн үр шим сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлтийн сөрөг үр нөлөөллөөс хамаагүй их байна.
• Ядуу иргэд, эмэгтэйчүүд ба хүүхэд, уугуул иргэд эсвэл бусад эмзэг бүлэгт ялгавартай нөлөөлөл үүсэх эсэх		✓	Тус төсөл нь нийгмийн эмзэг, өртөмтгий бүлгийн амьдрах нөхцөлд эерэгээр нөлөөлнө.
• Соёлын биет хөрөнгийн доройтол, соёлын өв ба аялал жуулчлалын орлогын алдагдал үүсэх эсэх		✓	Соёлын биет хөрөнгөд хор хөнөөл учруулахгүй ба төслийн сайжруулсан дэд бүтцийн үр дүнд аялал жуулчлалын орлого нэмэгдэнэ.
• Нам дор газар, үерийн усанд автах газар болон эгц уул зэрэг газарт зөвшөөрөлгүй оршин суух хүмүүс, орлого багатай иргэд, бохирдолтой үйлдвэрлэлийн улмаас эрүүл мэндийн аюул, эрсдэлд өртөж болзошгүй эсэх		✓	Газрын зөвшөөрөлгүй болон орлого багатай иргэдэд сөрөг нөлөөлөл үүсэхгүй.
• Усны нөөцийн асуудал (т: усан хангамжийн хомсдол, бууралт, гадаргуугийн ба газрын доорх усны чанар муудах, хүлээн авах усны бохирдол) үүсэх эсэх		✓	Тус төсөл усан хангамж, усны чанарт эерэг нөлөөлөл үүсгэх ба ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
• Хотын утааны ялгарлаас болж агаарын бохирдол үүсэх эсэх	✓		Барилгын ажлын явцад богино хугацаанд агаарын бохирдлоос зайлсхийх боломжгүй. Төслийн ажлын талбайн ойролцоо амьдрах хүн амд үүсэх агаарын бохирдлын сөрөг нөлөөлийг бууруулах хяналт, арга хэмжээг хэрэгжүүлнэ.
• Төслийн барилгын ажил, угсралтын явцад хими, биологийн бодит аюулын			Төслийн барилгын ажил, угсралтын явцад ажлын байрны ноцтой эрсдэл гарна гэж

улмаас ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдалтай холбоотой эрсдэл үүсэх эсэх		✓	тооцоогүй. Эрүүл ахуй, аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлэх ба төслийн нийт хугацаанд үр дүнтэй хяналтыг системийг хэрэгжүүлнэ.
---	--	---	---

**ХОТ БАЙГУУЛАЛТ
ХУУДАС 3/5**

Шалгах асуултууд	Тийм	Үгүй	Тайлбар
• Борооны улирлын үед газар малтлагын улмаас зам хаагдах, түр зуурын үерт автах эсэх		✓	Хагас хуурай бүсэд ийм тохиолдол бага. Гол, горхины ойролцоо төслийн байршил байх тохиолдолд ийм нөхцөл үүсэхээс зайлсхийх зохих арга хэмжээг авна.
• Барилгын үйл ажиллагааны дуу чимээ, тоосжилт үүсэх эсэх	✓		Барилгын ажлын явцад түр хугацаанд дуу чимээ, тоосжилт гарна. Эдгээр сөрөг нөлөөг багасгах зорилгоор төслийн БОМТ ба гүйцэтгэгчийн БОМТ-г боловсруулах бөгөөд орон нутаг, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.
• Барилгын материал, хог хаягдал тээвэрлэх үед замын хөдөлгөөний түгжрэл үүсэх эсэх		✓	Төсөлд хамрагдах кластер замын хөдөлгөөн багатай тул түгжрэл үүсэхгүй.
• Барилгын ажлын улмаас түр зуурын шавар лаг үүсэх эсэх		✓	Төслийн талбай хагас хуурай бүсэд орших учир ийм нөлөөлөл үүсэхгүй.
• Орчны, ахуйн болон ажлын байрны бохирдол, дулааны урвуу байдал болон утааны улмаас олон нийтийн эрүүл мэндэд аюул үүсэх эсэх		✓	Төслийн үйл ажиллагаанаас ийм төрлийн аюул үүсэхгүй.
• Усны хомсдол, доройтол үүсэх эсэх		✓	Төслийн үйл ажиллагааны улмаас усны хомсдол, доройтол үүсэх магадлал бага.
• Гүний усыг хэт хэрэглэснээр газрын хөрсний суулт үүсгэн, гүний усны түвшин багасах, давсжилт үүсэх эсэх		✓	Сөрөг нөлөөлөлгүй.
• Хог хаягдлыг зохисгүй хаясны улмаас хөрс, гүний усны бохирдол үүсэх эсэх		✓	Сөрөг нөлөөлөлгүй. Гэвч төслийн үйл ажиллагааны үр дүнд хог хаягдлыг зайлуулах системийг сайжруулахад эерэг үр дүн гарна.
• Усны бохирдлын улмаас орчны тав тух алдагдах, загасны нөөц ба далайн нөөцийн хомсдол болон эрүүл мэндийн асуудал үүсэх эсэх		✓	Сөрөг нөлөөлөлгүй.
• Төслийн барилга, үйл ажиллагааны явцад хүн амын томоохон шилжилт хөдөлгөөний улмаас нийгмийн дэд бүтэц, үйлчилгээ (т: усан хангамж, цэвэрлэх байгууламжийн систем)-ний ачаалал нэмэгдэх эсэх		✓	Төслийн кластер дэх хүн амын нягтрал бага учир сөрөг нөлөөлөлгүй. Гэвч төсөл үндсэн дэд бүтцийг сайжруулах тул орон нутгийн иргэд төслийн үр шимийг хүртэнэ.
• Хэрэв өөр бүс эсвэл орноос ажилчид ажиллуулбал нийгмийн зөрчил үүсэх эсэх		✓	
• Төслийн үйл ажиллагаа, барилгын ажлын явцад тэсэрч дэлбэрэх материал, шатахуун болон химийн бусад бодисыг тээвэрлэх, хадгалах, ашиглах эсвэл устгах үед орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл үүсэх эсэх		✓	Төсөлд тэсэрч дэлбэрэх материал ашиглагдахгүй. Төслийн явцад шатахуун болон барилгын химийн бодисыг дотоодын ба олон улсын зааварчилгаа, барилгын БОМТ-ний дагуу зохицуулна.
• Осол ба байгалийн аюулын улмаас иргэдийн аюулгүй байдалд эрсдэл үүсэх эсэх, төслийн бүтцийн элемент эсвэл бүрэлдэхүүн хэсгүүдийг төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй		✓	Ийм эрсдэлээс сэргийлэхийн тулд аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө болон асал, аюулын менежментийн төлөвлөгөө бэлтгэх ба төсөл хэрэгжүүлэгчид зохих ёсоор хэрэгжүүлнэ.

иргэдэд нээлттэй байлгах эсэх, тэдгээрийг үл мөрдсөний улмаас төслийн барилгын ажил, ашиглалт, ашиглалтыг зогсоох үед иргэдэд гэмтэл үүсгэх эсэх			
--	--	--	--

ХОТ БАЙГУУЛАЛТ
ХУУДАС 4/5

Уур амьсгалын эрсдэлийн урьдчилсан үзлэгийн шалгах хуудас

Улс/төслийн нэр : MON (49430): Аймаг, сумын хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр (I шатлал)

Салбар : Хот байгуулалт

Дэд салбар : Хот, эдийн засаг, нийгмийн дэд бүтэц, байгууламж

Газар/хэлтэс: БОХХ/ЗАГ

Шалгах асуултууд		Оноо	Тайлбар ¹
Төслийн байршил, зураг төсөл	Төслийн байршилд үер, ган, шуурга, хөрсний нуралт зэрэг цаг агаарын эрс тэс үзэгдэл бүхий уур амьсгалын нөхцөл нөлөөлөх магадлалтай эсэх	0	Цаг агаарын эрс тэс нөхцөл нь төслийн дэд бүтцэд нөлөөлөх магадлал бага.
	Төслийн зураг төсөл (гүүр барих газрыг суллах г.м)-д гидро-цаг уурын ямар нэгэн үзүүлэлт (т: далайн түвшин, голын усны оргил түвшин, усны найдвартай түвшин, салхины оргил хурд)-ийг харгалзан үзэх хэрэгтэй эсэх	1	Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас төслийн бүрэлдэхүүнд боломжит нөлөөлөл бий болгохоос сэргийлж, гидрологийн үзүүлэлтийг дахин шалгах шаардлага гарч болзошгүй.
Материал, засвар үйлчилгээ	Цаг уурын одоогийн ба цаашдын нөхцөл (т: зуны халуун, өвлийн хүйтэн өдрүүдийн хоорондох чийгшилийн түвшин, температурын зөрүү давамгайлах, салхи, чийгшлийн усны цаг уурын үзүүлэлтэд илрэх байдал) төслийн үр дүнгийн хугацаанд төслөөс оруулах орц (т: барилгын материал)-ын сонголтонд нөлөөлөх магадлалтай эсэх	1	Төслийн үр дүнд нөлөөлж болох эрсдэлийг бууруулахын тулд барилгын материалын чанар, төслийн дэд бүтцийн засвар, үйлчилгээний давтамж зэрэг асуудлыг дахин нягтлах шаардлага гарч болзошгүй.
	Цаг агаарын одоогийн болон цаашдын нөхцөл, холбогдох эрс тэс үзэгдэл төслийн үр дүнгийн засвар үйлчилгээний ажил (хуваарь, зардал)-д нөлөөлөх магадлалтай эсэх	1	
Төслийн үр дүнгийн гүйцэтгэл	Цаг агаар, уур амьсгалын нөхцөл, холбогдох эрс тэс үзэгдэл төлөвлөсөн ажлын хугацааны туршид төслийн үр дүн (т:усан цахилгаан станц)-ийн гүйцэтгэл (т: цахилгааны жилийн үйлдвэрлэл)-д нөлөөлөх магадлалтай эсэх	1	Зарим судалгаа, материалаас үзвэл Монгол оронд уур амьсгалын өөрчлөлт эрчимтэй явагдаж байгаа тул төслийн үр дүнд нөлөөлж болзошгүй.

Асуулт ба хариултын оноог доор харуулав:

Хариулт	Оноо
Магадлалгүй	0
Магадлалтай	1
Их магадлалтай	2

Хариултын оноог нэмэхэд 0 гарч байвал бага эрсдэлтэй төсөл гэж үзнэ. Хэрэв бүх хариултыг нэмэхэд хариу нь 1-4 гарч, нэг ч асуулт 2 онооны хариулт аваагүй тохиолдолд төслийг дүнд зэргийн эрсдэлтэй ангилалд оруулна. Нийт онооны нийлбэр 5 ба түүнээс дээш (бүх хариултанд 1 оноо өгсөн) гарсан эсвэл нэг асуултанд 2 онооны хариулт өгсөн тохиолдолд өндөр эрсдэлтэй төсөл гэж ангилна.

¹ Хэрэв боломжтой бол төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн уур амьсгалын нөхцөлд эмзэг мэдрэмтгий байдлын тухай дэлгэрэнгүй мэдээлэл өгөх хэрэгтэй. Үүнд тухайлбал: дэд бүтцийн бүрэлдэхүүн хэсгүүдийн зураг төслийн стандартад уур амьсгалын үзүүлэлтүүдийг хэрхэн тусгасан, уур амьсгалын гол үзүүлэлтүүд, далайн түвшний

өөрчлөлт төслийн байршил, зам, барилгын материалын сонголт ба төлөвлөлт, гүйцэтгэл болон төслийн үр дүнгийн засвар, үйлчилгээний зардал, төлөвлөлтөнд хэрхэн нөлөөлөх тухай нарийвчилсан мэдээлэл орно.

ХОТ БАЙГУУЛАЛТ
ХУУДАС 5/5

Анхны үнэлгээний дүн (Бага, Дунд, Их): Дунд

Бусад санал: Монгол орны эрс тэс цаг агаар, уур амьсгалын өөрчлөлтийн үйл явц эрчимтэй явагдаж, улам бүр анхаарад татаж байгаатай холбогдох эрсдэлээс үндсэндээ шалтгаалж, түс төслийг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөх дунд зэргийн эрсдэлтэй гэж үзэж байна.

Бэлтгэсэн: Шотаро Сасаки, Байгаль орчны ахлах мэргэжилтэн, БОХХ

ХАВСРАЛТ В: АСХХОХ-Т ХОЛБОГДОХ БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ БА СТАНДАРТУУД

Хуулийн нэр	Холбогдох бүлэг	Хариуцсан яам
1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль		Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ)
Бодлого, стратеги, хөтөлбөрийн хамрах хүрээ, нөлөөллийн тухай эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг зохион	19	
3. Усны тухай хууль		Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Усны нөөцийг хамгаалах	22	
Усны нөөцийг бохирдохоос хамгаалах: Хаягдал усыг их хэмжээгээр хаях эсвэл холбогдох стандартыг мөрдөөгүй тохиолдолд ус ашиглах эрхийг цуцлах	24	
Ус бохирдуулсны болон усны нөөцийг хомсдуулсны нөхөн төлбөрийг Засгийн газраас тогтоох	25	
Ус ашиглах гэрээг цуцлах нөхцлүүд	29	
Ус ашиглагчийн хүлээх үүрэг	30	
Ус ашигласны төлбөр	31	
4. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль		БОАЖЯ
Ус бохирдуулсны төлбөр төлөгч, түүнийг бүртгэх	4	
Ус бохирдуулсны төлбөр төлөх зүйл	5	
Ус бохирдуулсны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх	8	
Хотын ус хангамжийн сүлжээ ба ариутгах татуургын ажиллагаа	9	
Хотын ус хангамжийн сүлжээ ба ариутгах татуургын зохицуулах хорооны бүрэлдэхүүн, үүрэг	9	
Хотын ус хангамжийн сүлжээ ба ариутгах татуургын ажиллагааны техникийн тодорхойлолт	11	
Тусгай зөвшөөрөл, лиценз	12	
Гэрээ	13	
Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний байгууллагын үүрэг Үйлчилгээний байгууллагууд хэрэглэгчдийн эрхэд хуулийн үндэслэлгүй саад болох, техникийн тодорхойлолт авах хүсэлтээс татгалзах эрхгүй	14	
Ашиглагчдын эрх, үүрэг	15	
Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээг цуцлах нөхцөл	16	
Ариутгах татуургын хамгаалалтын бүс, ариутгах татуургаас 6 метрийн дотор барилга байгууламж барихыг хориглоно.	17	
Хаягдал ус цэвэршүүлэх байгууламжийн байршилд тавигдах техникийн шаардлага	18	
5. Газрын тухай хууль		БОАЖЯ ба БХБЯ
Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх	39	

Хуулийн нэр	Холбогдох бүлэг	Хариуцсан яам
Газар эзэмших гэрчилгээний хугацаа дуусгавар болоход газрыг чөлөөлөх	41	
Гэрээний хугацаа дуусахаас өмнө бусдын эзэмшил газрыг солих буюу эргүүлэн авахад нөхөн олговор олгох	43	
Газрыг тусгай ба нийтийн зориулалтаар ашиглах	46	
Бусдын эзэмшилд байгаа газрыг түр хугацаагаар ашиглах, дайран өнгөрөх	48	
Газрыг зохистой ашиглахад тавих шаардлага	50	
Газар ашиглах эрүүл ахуйн шаардлага	51	
Хот, тосгон, бусад суурины газрыг зохистой ашиглах	56	
Газарт учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх	61	
6. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль		БХБЯ
Хот, суурин газрыг дахин хөгжүүлэхэд Хот байгуулалтын тухай хуулийн 4.1-р зүйлд заасан шаардлага, зарчмыг баримтална. Оршин суугчдын эрх ашгийг хамгаалахад тэргүүлэх ач холбогдол өгнө.	5	
Хот, сууринг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны төрөл, үүнд 12.1.3 гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах	12	
Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах тухайд	17	
Төсөл хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг	23	
Төсөлд оролцогч талууд буюу газар өмчлөгч, эзэмшигч, төсөл хэрэгжүүлэгч болон аймаг, сумын Засаг даргын хооронд 3 талт гэрээ байгуулах	24	
Газар өмчлөх, эзэмших эрхийг 3 талт гэрээний нөхцлийн дагуу төсөл хэрэгжүүлэгчид шилжүүлэх	25	
7. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль		БХБЯ
Газар өмчлөгч иргэний эрх, үүрэг	27	
Иргэний газар өмчлөх эрх дуусгавар болох	31	
Газар өмчлөх эрхийг улс эргүүлэн авах	32	
Газар өмчлөх эрхийг хязгаарлах эрх	33	
Газрыг хураах	35	
Нүүлгэн шилжүүлэх нөхцөл	37	
8. Газрын төлбөрийн тухай хууль		БХБЯ
Газрын төлбөр төлөгчийг тодорхойлох	3	
Төлбөр ногдуулах газар	4	
Газрын төлбөрөөс чөлөөлөх	8	
Газрын төлбөр төлөгчдийн хүлээх хариуцлага	12	
9. Байгаль орчныг хамгаалах тухай хууль		БОАЖЯ
Байгаль орчныг хамгаалах талаархи иргэний эрх, үүрэг	4	
Байгалийн баялгийг хамгаалах	6	
Байгаль орчныг бохирдлоос хамгаалах	21	
Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг	31	
Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх	49, 57	
10. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль		БОАЖЯ
Хөрс хамгаалах арга хэмжээ	6	
Хөрсөнд учруулсан хохирлын нөхөн төлбөр	9	
11. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль		БОАЖЯ
Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)	8	
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)	9	
Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийн үүрэг	14	
БОНБУ хийх эрх бүхий байгууллагын эрх, үүрэг	15	
Санхүүгийн байгууллагууд байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөлтөй төслүүдийг дэмжихээс зайлсхийх үүрэгтэй	17	
БОНБУ хийхдээ олон нийттэй зөвлөлдөх уулзалт хийх	18	
БОНБУ ба БОМТ-г хэрэгжүүлээгүйгээс гарсан хохирлыг нөхөн төлүүлэх	20	
12. Агаарын тухай хууль		БОАЖЯ

Хуулийн нэр	Холбогдох бүлэг	Хариуцсан яам
Байгууллага, иргэний эрх, үүрэг	9	
Агаарын чанарын тухай мэдээлэл	12	
Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагаа, үндсэн зарчим	13	
Агаарын чанарыг сайжруулах бүс	15	
Агаарын чанарыг сайжруулах бүсэд хориглох зүйлс	16	
Агаар дах ялгарал	20	
Барилга байгууламж барихад агаар хамгаалах талаар тавигдах шаардлага	21	
13. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль		БОАЖЯ
Агаарын бохирдлын төлбөр төлөгч, түүнийг бүртгэх	4	
Төлбөр ногдуулах биет нэгж	6	
Төлбөрийн хэмжээ	7	
Төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх	8	
14. Барилгын тухай хууль		БХБЯ
Барилгын ажлын зөвшөөрөл	7	
Барилгын зураг төсөл, барилгын материал, барилгын ажилд тавигдах техникийн шаардлага	11,12,13	
Барилгын ажлын талбайд тавих шаардлага	16	
Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу сервитут тогтоох	17	
Барилгын ажлын захиалагч зохиогчооч урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр оригинал зураг төслийг өөрчлөх эрхгүй	37	
15. Амьтны тухай хууль		БОАЖЯ
Амьтан хамгаалах	6	
Амьтны нөөцөд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх	37	
16. Ургамал хамгааллын тухай хууль		БОАЖЯ
Ургамал хамгааллын талаархи иргэн, хуулийн этгээдийн үүрэг	13	
Ургамлын хорио цээр тогтоох	14	
17. Соёлын өвийг хамгаалах тухай хууль		Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам (БСШУЯ)
Соёлын өвийн бүртгэлийн бүрдэл	21	
Түүх, соёлын дурсгалт газарт уул уурхай, газар тариалан, дэд бүтцийн барилга байгууламж барихтай холбоотой үйл ажиллагааг хориглоно.	38	
18. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль		Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) ба Эрүүл мэндийн яам (ЭМЯ)
Барилга, үйлдвэрлэлийн орчинд тавих шаардлага	7	
Машин механизм, тоног төхөөрөмжид тавих шаардлага	9	
Галын аюулгүй байдалд тавих шаардлага	13	
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар ажил олгогчийн үүрэг	28	
Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын үед авах арга хэмжээ	29	
Төрийн захиргааны хяналт	33	
19. Галын аюулгүй байдлын тухай хууль		Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ)
Галын аюулгүй байдлыг хангах талаархи иргэний эрх, үүрэг	16	
Галын аюулгүй байдлыг хангах талаар тавих ерөнхий шаардлага	19	
Гал унтраах тоног төхөөрөмжид тавих шаардлага	23	
20. Хог хаягдлын тухай хууль 2016		БОАЖЯ
Хог хаягдлын талаар игэн, аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий эрх, үүрэг	9	
Хог хаягдлыг зайлуулах	11	
Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх	12	

Хуулийн нэр	Холбогдох бүлэг	Хариуцсан яам
21. Химийн хорт болон аюултай бодисын тухай		БОАЖЯ
Химийн хорт болон аюултай бодис ашиглахад тавих үндсэн шаардлага	13	
Эрсдлийн үнэлгээ	17	
22. Эрүүл ахуйн тухай хууль		БОАЖЯ
Хүрээлэн байгаа орчинд тавих эрүүл ахуйн шаардлага	4	
Хот төлөвлөлт, барилга байгууламжид тавих эрүүл ахуйн шаардлага	5	
Ажлын байранд тавих эрүүл ахуйн шаардлага	6	

АСХХОХ-т холбогдох үндэсний стандартууд

Код	Стандартын нэр
MNS 17.5.1.18:1983	Байгаль хамгаалал: Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Эвдэрсэн газрын ангилал.
MNS 17.5.1.19:1992	Байгаль хамгаалал: Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага
MNS 3473:1983	Байгаль хамгаалал. Газар, газар ашиглалт. Нэр томъёо. Тодорхойлолт
MNS 17.5.13:1980	Байгаль хамгаалал: Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо. Тодорхойлолт
MNS 17.0.0.06:1979	Байгаль орчны хамгааллын стандартын систем. Үндсэн дүрэм
MNS 5914:2008	Байгаль хамгаалал: Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо. Тодорхойлолт
MNS 5918:2008	Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага
MNS 17.2.0.07:1979	Агаарыг бохирдуулах бодис. Ангилал
MNS 17.2.1.17:1980	Агаар мандлыг бохирдуулах үйлдвэрлэлийн бодис. Нэр томъёо. Тодорхойлолт
MNS 4585:2016	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
MNS 3383:1982	Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр. Нэр томъёо. Тодорхойлолт
MNS 5885:2008	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага
MNS 3113:1981	Агаарын бохирдуулах бодисыг тодорхойлох аргад тавих ерөнхий шаардлага
MNS 17.2.3.16:1988	Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам
MNS 6063:2010	Агаарын чанар: Бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ
MNS ISO 14064-2:2015	Хүлэмжийн хий-Хэсэг 2: Хүлэмжийн хийн ялгаралтын бууралт ба шингээлтийн өсөлтийг тооцоолох, мониторинг хийх, тайлагнах тухай зааварчилсан удирдамж
MNS 3384:1982	

Код	Стандартын нэр
	Агаарын чанар. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага
MNS 17.1.1.10:1979	Усан мандал, ус ашиглалт. Нэр томъёо. Тодорхойлолт
MNS 4047:1988	Усан мандал. Гадаргын усны чанарыг хянах журам
MNS 3342:1982	Усан мандал. Газар доорхи усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага
MNS 6148:2010	Усны чанар: Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
MNS 0899:1992	Унд ахуйн зориулалттай усны төвлөрсөн хангамжийн эх булгийг сонгох журам ба эрүүл ахуйн шаардлага
MNS 0900:2005	Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага ба чанар, аюулгүй байдлын үнэлгээ
MNS ISO 5667:1:2002	Усны чанар. Дээж авах: 1-р хэсэг: Ундны усны дээж авах
MNS ISO 5667-3:1999	Усны чанар. Дээж авах: 3-р хэсэг: Дээж авах ба хадгалах заавар
MNS ISO 5667:6:2001	Усны чанар. Дээж авах: 6-р хэсэг: Гол горхины уснаас дээж авах заавар
MNS 4943:2015	Усны чанар: Хаягдал ус. Ерөнхий шаардлага
MNS BS 8525-1:2015	Саарал усны систем. Ерөнхий шаардлага
MNS ISO 5667-10:2001	Усны чанар. Дээжлэлт: 10-р хэсэг: Хаягдал уснаас дээжлэлт хийх удирдамж
MNS ISO 5667-7:2002	Усны чанар. Дээж авах: 7-р хэсэг: Уурын зуухны ус болон уураас дээж авах заавар (НОВ)
MNS 4288:1995	Бохир ус цэвэршүүлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи түвшинд тавих үндсэн шаардлага
MNS 3297:1991	Хөрс: Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм
MNS 5850:2008	Хөрсний чанар: Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
MNS 3298:1991	Хөрсний чанар: Хөрсний дээж авах ерөнхий шаардлага
MNS 3985:1987	Хөрс. Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл
MNS 2305:1994	Хөрс. Дээж авах, савлах, хадгалах журам
MNS 4968:2000	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа: Ажлын байрны ерөнхий шаардлага
MNS 4994:2000	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа: Долгионы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
MNS 5146:2002	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа: Цахилгааны аюулгүй ажиллагаа. Газардуулга. Тэлэлт

Код	Стандартын нэр
MNS 5145:2002	Цахилгааны аюулгүй ажиллагаа: Хүрэх хүчдэл ба гүйдлийн зөвшөөрөх дээд түвшин
MNS 5002:2000	Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага: Шуугиан норм
MNS 0012.4.005:1985	Хөдөлмөр хамгаалал. Багаж хэрэгсэл ба төрөл
MNS 4244:1994	Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага
MNS 5390:2004	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл
MNS 6458:2014	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага
MNS 3474:2003	Ургамал хамгаалал: Нэр томъёо. Тодорхойлолт
MNS 5344:2011	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
MNS 5872:2008	Цахилгаанаар хангагчаас хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний шаардлага
MNS 4084:1988	Нарны панель бүхий ус халаах зуухны техникийн ерөнхий шаардлага
MNS 5682:2006	Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам
MNS 4597:2014	Замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага
MNS 4759:2014	Замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага
MNS 4596:2014	Замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм
MNS 5342:2007	Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага

ХАВСРАЛТ С: МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН КОНВЕНЦУУД

Олон улсын конвенци, протокол	Нэгдэн орсон он	Хариуцсан яам, агентлаг
Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн үндэстний байгууллагын суурь конвенци	1993 (г)	БОАЖЯ
Киотогийн протокол	1999 (а)	БОАЖЯ
Биологийн олон янз байдлын тухай конвенци	1993 (г)	БОАЖЯ
Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн конвенци	1996 (а)	БОАЖЯ
Озон (озон давхарга) задалдаг бодисын тухай Монреалийн	1996 (а)	БОАЖЯ
Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Вашингтоны конвенци	1996 (а)	БОАЖЯ
Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенци	2004 (г)	БОАЖЯ, Гадаад харилцааны яам (ГХЯ)

(а) нэгдэн орсон, (е) хүчин төгөлдөр болсон, (г) гарын үсэг зурсан.

ХАВСРАЛТ D: БОТБУ, БОНБУ, БОМТ-НИЙ ХУРААНГУЙ ЖИШИГ АГУУЛГА

96. БОТБУ эсвэл БОНБУ-ний ерөнхий агуулгыг дор танилцуулав²⁰. БОТБУ ба БОНБУ-ний ялгаа нь үнэлгээний хамрах хүрээ. Өөр өөр хэсгүүдийн давамгайлах дараалал нь үнэлгээний агуулгаас хамаарч бага зэрэг өөр байж болно.

Гүйцэтгэлийн хураангуй

Энэ хэсэгт чухал баримт фактууд, олж мэдсэн томоохон зүйлс болон зөвлөмж болгож буй арга хэмжээг товч танилцуулна.

Танилцуулга

Төсөл, төслийн зорилтууд болон үнэлгээ хийх үндсэн орчин нөхцөл (байгаа бол)-ийг танилцуулна.

Бодлого, хууль эрх зүй, захиргааны хүрээ

Энэ хэсэгт байгаль орчны үнэлгээ хийгдэх үндэсний болон орон нутгийн хууль эрх зүйн ба институцийн хүрээг авч үзнэ. Мөн Монгол Улс нэгдэн орсон бөгөөд төсөлд холбогдох олон улсын гэрээнүүдийг тогтоож өгнө.

Төслийн тайлбар

Энэ хэсэгт санал болгож буй төсөл, түүний гол бүрэлдэхүүн хэсгүүд, газар зүй, экологи, нийгэм, орон зайн орчин нөхцөл, үүнд төслөөс шаардагдаж буй холбогдох байгууламж (т: зам, цахилгаан станц, усан хангамж, карьер ба цооногийн нүх болон бохирыг зайлуулах цэг)-ийн хамт танилцуулна. Үүнд төслийн байршлын схем болон бүрэлдэхүүн хэсгүүд, төслийн ажлын талбай болон нөлөөллийн бүсийг харуулах зураг, газрын зураг агуулагдана.

Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн суурь түвшний тайлбар

Энэ хэсэгт судалгааны талбайн доторх физик, биологи, нийгэм-эдийн засгийн холбогдох нөхцлүүдийг танцилуулна. Мөн төслийн нөлөөллийн бүсийн доторх өнөөгийн боон санал болгож буй хөгжлийн үйл ажиллагаа, үүнд төсөлд шууд үл хамаарах үйл ажиллагааг хамруулан авч үзнэ. Үүнд өгөгдөл мэдээний үнэн зөв, найдвартай байдал болон эх сурвалжийг зааж өгнө.

Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл ба бууруулах арга хэмжээ

Энэ хэсэгт төслийн нөлөөллийн бүсийн физик, биологи, нийгэм-эдийн засгийн (үүнд ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, олон нийтийн эрүүл ахуй, аюулгүй мэнд, эмзэг өртөмтгийн бүлгүүд ба жендэрийн асуудал, байгаль орчны орчин нөхцлөөр дамжин амьжиргаанд үүсэх нөлөөлөл) болон соёлын биет нөөц баялагт төслөөс бий болох магадлалтай эерэг болон сөрөг, шууд ба дам нөлөөллийн төсөөлөл, үнэлгээ хийн, аль болох тоон угаар илэрхийлж, нөлөөллийг бууруулах арга хэмжээ болон бууруулах боломжгүй аливаа үлдэгдэл, сөрөг нөлөөллийг тогтоож, сайжруулах боломжийг эрж хайн, байгаа өгөгдөл мэдээний хэмжээ ба чанар, үндсэн өгөгдөл мэдээний зөрүү болон төсөөллийн тодорхой байдлыг тогтоон, тооцоолж, цаашид анхаарах шаардлагагүй сэдвүүдийг онцлон зааж, нийт ерөнхий, хил дамнан үүсэх болон хурааж хуримтлагдах нөлөөллийг шинжилж үзнэ.

²⁰ ХБББ (2009)-ийн Хавсралт 1-ийн нэмэлт хавсралт 1-ийн зүүлт тайлбар 1-ээс шууд авах

Бусад хувилбарын шинжилгээ

Энэ хэсэгт төслийн ажлын санал болгож буй талбай, технологи, төлөвлөлт болон үйл ажиллагааны бусад хувилбарууд, үүнд эс хувилбарыг хамруулан, байгаль орчинд үзүүлэх боломжит нөлөөлөл, тэдгээр нөлөөллийг бууруулах техник-эдийн засгийн боломж, тэдгээрийн капиталын болон урсгал зардал, орон нутгийн нөхцөлд тохиромжтой эсэх, мөн институци, сургалт, хяналт шинжилгээний шаардлага зэргийн хувьд шинжилж үзнэ. Мөн төслийн санал болгож буй төлөвлөлтийг тусгайлан сонгох болсон үндэслэлийг дурдаж, зөвлөмж болгож буй ялгарлын түвшин болон бохирдлоос сэргийлэх, бууруулах аргазүйг тайлбарлана.

Мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох, зөвлөлдөх ба оролцоог хангах

Энэ хэсэгт:

- (i) Төслийн төлөвлөлт, бэлтгэл хийх үе шатанд оролцогч талуудыг хэрхэн оролцуулах, үүнд төслийн нөлөөлөлд өртөх хүмүүс болон бусад оролцогч талуудад мэдээллийг нээлттэй болгох, тэдэнтэй зөвлөлдөх үйл явцыг танилцуулна.
- (ii) Төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүс болон бусад оролцогч талуудаас ирсэн санал, шүүмжийг нэгтгэж, тэдгээрийг төслийн төлөвлөлт болон нөлөөллийг бууруулах арга хэмжээнд хэрхэн шийдвэрлэх, ингэхдээ эмзэг өртөмтгий бүлэг, үүнд эмэгтэйчүүд, орлого багатай хүмүүс, уугуул иргэдэд хэрхэн тусгайлан анхаарал тавих тухай тусгана.
- (iii) Мэдээллийг олон нийтэд нээлттэй болгохоор төлөвлөсөн арга хэмжээ (үүнд олон нийтэд түгээх мэдээллийн төрөл, түгээх арга) болон нөлөөлөлд өртөж болзошгүй хүмүүстэй зөвлөлдөх уулзалт хийж, тэднийг төслийн хэрэгжилтэд оролцуулах үйл явцын тухай танилцуулна.

Гомдол барагдуулах механизм

Энэ хэсэгт гомдол барагдуулах хүрээ (албан ба албан бус шугамаар)-г танилцуулж, байгаль орчны гүйцэтгэлийн талаар гарсан гомдлыг шийдвэрлэх хугацаа, механизмыг тайлбарлана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Энэ хэсэгт төсөл хэрэгжих явцад байгаль орчны сөрөг нөлөөллөөс зайлхийх, бууруулах, даван туулах эсвэл үүссэн сөрөг нөлөөллийг нөхөн төлөх (тухайн ач холбогдлын дарааллаар) зорилгоор авч хэрэгжүүлэх нөлөөллийг бууруулах болон менежментийн багц арга хэмжээг танилцуулна. Үүнд хэд хэдэн менежментийн төлөвлөгөө, арга хэмжээ багтаж болно. Дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ (төслийн нөлөөлөл, эрсдэлд пропорциональ нарийвчлалын түвшинд). Үүнд:

Нөлөөллийг бууруулах

- a) Байгаль орчинд бий болно гэж төсөөлж буй сөрөг нөлөөлөл, эрсдлийг тодорхойлж, нэгтгэнэ.
- b) Нөлөөллийг бууруулах арга хэмжээ тус бүрийг техникийн дэлгэрэнгүй мэдээлэл, үүнд холбогдох нөлөөллийн төрөл, мөн ямар нөхцөлд шаардлагатай болох (т: тасралтгүй хэрэгжүүлэх эсвэл магадлашгүй нөхцөл үүсэн тохиолдолд) талаар, зохих зураг төсөл, тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлага болон үйл ажиллагааны дотоод журмын хамт

танилцуулна.

- с) Төсөлд шаардлагатай байгаа бусад нөлөөллийг бууруулах (т: сайн дурын нүүлгэн шилжүүлэлт, уугуул иргэд эсвэл онцгой байдлын хариу арга хэмжээ) төлөвлөгөөтэй холбож өгнө.

Хяналт шинжилгээ

- а) Хяналт шинжилгээний арга хэмжээг техникийн дэлгэрэнгүй мэдээлэл, үүнд хэмжилт хийх параметрууд, хэрэглэх арга, дээж авах байршил, хэмжилт хийх давтамж, илрүүлэх хязгаар болон засаж залруулах арга хэмжээ авах шаардлага бий болсныг илтгэх хязгаар үзүүлэлтүүдийн тодорхойлолтын хамт танилцуулна.
- б) Нөлөөллийг бууруулах тодорхой арга хэмжээ авах шаардлага бий болсон нөхцлийг эрт илрүүлэх, нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны явц болон үр дүнг баримтжуулах зорилгоор хяналт шинжилгээний болон тайлагнах журмыг танилцуулна.

Хэрэгжүүлэх зохион байгуулалт

- а) Хэрэгжүүлэх хуваарийг үе шаттайгаар, төслийн ерөнхий хэрэгжилттэй уялдуулан гаргаж, танилцуулна.
- б) Институцийн эсвэл байгууллагын зохион байгуулалт, үүнд нөлөөллийг бууруулах, хяналт шинжилгээний арга хэмжээг хэн хариуцаж гүйцэтгэх тухай танилцуулна. Тэдгээр арга хэмжээнд байгаль орчны менежментийн чадавхийг сайжруулах дараах нэмэлт сэдвээс нэг, хоёр нь орж болно. Үүнд: техникийн туслалцааны хөтөлбөр, сургалтын хөтөлбөр, байгаль орчны менежмент, хяналт шинжилгээний холбогдох тоног төхөөрөмж, туслах материал худалдан авах, зохион байгуулалтын өөрчлөлт г.м.
- с) Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх капиталын болон урсгал зардлын тооцоог гаргаж, санхүүжилтийн эх үүсвэрийг танилцуулна.

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

Төслөөс хүлээгдэж буй үр дүнг тогтсон хугацаануудад аль болох их хэмжээнд хэмжих болох зүйлс, т: гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хүлээн зөвшөөрөгдөх шалгуур үзүүлэлт г.м.-ээр тайлбарлана.

Дүгнэлт ба зөвлөмж

- БОТБУ эсвэл БОНБУ-ний ерөнхий дүгнэлт, мөн хамаарах бол төслийн ямар нэмэлт үнэлгээ шаардлагатай байгааг зааж өгнө. БОМТ-г хэрэгжүүлэхэд өгөх зөвлөмжийг хүснэгтээр оруулна.

ХАВСРАЛТ Е: АСХХОХ-ИЙН ОЛОН НИЙТТЭЙ ЗӨВЛӨЛДӨХ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН УДИРДАМЖ

Аймаг, сумын хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр Аймаг,

сумын төв

он, сар, өдөр

**Байгаль орчны асуудлаар олон нийттэй зөвлөлдөх
уулзалтын**

УДИРДАМЖ

Ерөнхий

ХАБ-ны *Хамгааллын бодлогын баримт бичиг* (2009)-т заасан шаардлагын дагуу төслийн төлөвлөлтөд эмэгтэйчүүд, орлого багатай иргэд г.м. өртөмтгий, эмзэг бүлгийн хүмүүс ижил тэгш оролцох боломжийг бүрдүүлэхийн тулд оролцогч талуудтай зөвлөлдөх стратегид *ач холбогдолтой* байх, ил тод байх, оролцоог хангах болон хүртээмжтэй байх зарчмуудыг тусгана.

Зөвлөлдөх уулзалтын тоо

Төсөлд хамрагдах гэр хорооллын дэд төвүүдэд оролцогч талуудтай зөвлөлдөх албан ёсны уулзалтыг наад зах нь 1 удаа хийнэ. Байгаль орчны асуудал эсвэл гэр хорооллын дэд төвийн асуудлаар оролцогч талуудтай зөвлөлдөхдөө ХБББ (2009)-ийн дэмжлэгтэй дараах журмаар гүйцэтгэнэ.

Оролцогч талуудыг тодорхойлох

Оролцогч талуудыг хамтын оролцоотойгоор тодорхойлон, оролцуулах ба уулзалтыг ХА, ТХН (ГЗБГЗЗГ, БАХХ) нь БХБЯ болон БОНБУ-ний зөвлөхийн дэмжлэгтэй зохион байгуулна. Уулзалт тус бүрд дараах оролцогч талуудын төлөөлөл оролцоно. Үүнд:

- АСХХОХ-ийн ТХН, ХА
- Төслийн нөлөөлөлд өртөх бүх өрхийн төлөөлөл
- Нөлөөлөлд өртөх бизнесийн ААН-ийн төлөөлөл
- АСХХОХ-ийн сөрөг нөлөөлөлд шууд болон дам байдлаар өртөж болзошгүй газрууд, тэдгээрийн ойролцоох хашаанд оршин суугчдын төлөөлөл
- Эмэгтэйчүүдийн бүлэг, уугуул иргэд эсвэл шашны бүлэг г.м. орон нутгийн олон нийтийн байгууллагын төлөөлөл
- АСХХОХ-ийн үр дүн, нөлөөлөлд ашиг сонирхол бүхий бусад байгууллага, хувь хүн.

Зөвлөлдөх үйл явц

Зөвлөлдөх уулзалт тус бүрд дараах чухал алхамуудыг дагаж мөрдөнө. Үүнд:

1. Аймгийн ТХН, ХА (ГЗБГЗЗГ, БАХХ) болон АСХХОХ-ийг хэрэгжүүлэгч БХБЯ-ны төлөөлөл зөвлөлдөх уулзалтыг нээх.
2. АСХХОХ-ийн БОНБУ хийх компанийн (2 ажилтан) зөвлөлдөх уулзалтын зорилго, зорилтыг танилцуулах.

3. Аймгийн ТХН оролцогчдод АСХХОХ-ийн шатлалыг танилцуулж, АСХХОХ-ийн бүрэлдэхүүн хэсгүүд болон тэдгээр нь хаана хэрэгжих тухай тайлбарлаж өгөх. ТУН төсөлд хамрагдах дэд талбарууд, дэд төвийн бүрэлдэхүүн хэсгүүдийн том хэмжээтэй газрын зураг болон тоон мэдээг танилцуулах.
4. БОНБУ-ийн компанийн ажилтан хэлэлцүүлгийг эхлүүлж, хөтлөн явуулах.
5. Аймгийн ТХН (ГЗБГЗЗГ, БАХХ), ХА эсвэл БХБЯ-ны төлөөлөл оролцогчдын бүх асуулт, шүүмжид хариулах.
6. БОНБУ-ийн компанийн ажилтан бүх яригдсан асуудал, шүүмж болон ТХН, БХБЯ-наас өгсөн хариуг бичиж тэмдэглэж авах.

Хэлэлцүүлгийн удирдамж

АСХХОХ-ийн байгаль орчны асуудлаар хэлэлцүүлэг хийхэд оролцогчийг чиглүүлэхийн тулд асуулт, хариултын хэсэг эхлэхээс өмнө оролцогчдод байгаль орчны бүрдэл хэсгүүдийн жагсаалт (хүснэгт 1)-ыг танилцуулах ёстой. Хүснэгт 1 дэх байгаль орчны бүрдэл хэсгүүдийн жишээ “байгаль орчин” гэдгээр юуг хэлж байгааг ойлгуулна. Оролцогчид байгаль орчны өөрсдийн бүрдэл хэсгийг тодорхойлон, нэмэж хэлэлцүүлэхэд уриалах нь зүйтэй.

Хүснэгт 1. Оролцогч талуудын хэлэлцүүлэг хийх байгаль орчны бүрдэл хэсгийн жишээ

• Ундны усны чанар, хүртээмж • Гадаргуугийн усны чанар, хүртээмж • Газрын доорх усны чанар, хүртээмж • Агаарын чанар • Уур амьсгал • Газар ба хөрсний чанар • Гол, усан сан • Мод, бусад ургамалжилт • Эх газрын нөөц баялаг, т: ой мод, эрдэс баялаг, хөрс	• Эх газрын ба усны амьтад, т: загас, шувуу, жижиг хөхтөн • Тусгай хамгаалалттай газар нутаг (т: ТХГН, дархан цаазтай газар), • Газар ашиглалт (т: ХАА, загас агнуур, ойн АА, навигаци, загас үржүүлэг, арилжаа, бусад), • Нийтийн аюулгүй ажиллагаа • Нийтийн хөдөлгөөн, орох, гарах зам • Биет соёлын үнэт зүйлс (т: сүм хийд, булш бунхан, хөшөө дурсгал)
---	---

Оролцогчдыг байгаль орчны асуудлаар хэлэлцүүлэг хийж, санал шүүмж гаргуулахын тулд 5 нээлттэй асуулт, мэдээлэл авах хүсэлт тавих ёстой (хүснэгт 2).

Хүснэгт 2. Оролцогч талуудын хэлэлцүүлгийг чиглүүлэх асуулт, мэдээлэлавах хүсэлт

1. АСХХОХ-ийн үр шим юу бэ? АСХХОХ-ийн үр шимийг жагсаана уу. 2. Танд АСХХОХ-т байгаль орчны хувьд хэлэх санал, шүүмж байна уу? АСХХОХ-т байгаль орчны хувьд хэлэх санал шүүмжээ жагсаана уу. 3. Танд АСХХОХ-ийн барилгын ажлын тухайд байгаль орчны хувьд хэлэх санал шүүмж байна уу?

Барилгын үе шатны ажлын хувьд хэлэх байгаль орчны санал шүүмжээ жагсаана уу.

4. Танд АСХХОХ хэрэгжиж, үйл ажиллагааны үе шат дуусах тухайд байгаль орчны хувьд хэлэх санал шүүмж байна уу?

АСХХОХ хэрэгжиж, үйл ажиллагааны үе шат дуусах тухайд байгаль орчны хувьд хэлэх санал шүүмжээ жагсаана уу.

5. Та байгаль орчин эсвэл олон нийтэд нөлөөлөл үүсэхээс сэргийлэхийн тулд АСХХОХ-ийн төлөвлөлт, үйл ажиллагааг өөрчлөх нь нь зүйтэй гэж бодож байна уу?

Та АСХХОХ-өөс байгаль орчин эсвэл олон нийтэд сөрөг нөлөөлөл үүсэхээс сэргийлнэ эсвэл бууруулна гэж бодож байгаа өөрчлөлтүүдээ жагсаана уу.

Олон нийтийн хэлэлцүүлгийн хураангуй

Байгаль орчны асуудлаар зөвлөлдөх уулзалтаас дараах мэдээлэл бэлтгэгдсэн байх ёстой. Үүнд:

- a) Уулзалтанд оролцсон бүх оролцогчдын нэр, хаяг, гарын үсэг
- b) Оролцогчдоос гаргаж ирсэн бүх асуудал, санал шүүмжийн бүрэн бүртгэл
- c) Оролцогчдын асуулт, санал шүүмж тус бүрд ТХН, ХА эсвэл БХБЯ-наас өгсөн хариулт
- d) Уулзалтын фото зураг.

Төслийн нөлөөлөлд өртөх гэр хорооллын дэд төвд зөвлөлдөх уулзалт хийх бүрд доорх хүснэгт 3-ыг бөглөх.

Хүснэгт 3. Амаг, сумын төвийн оролцогчдын саналыг бүртгэх хуудас

Аймаг, сумын төвийн нэр	Асуудал, шүүмж	ТУН, ХА (ГЗБГЗЗГ, БАХХ) эсвэл БХБЯ-ны хариулт	БОНБУ хийх компанийн хариулт

ХАВСРАЛТ F: ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ

АСХХОХ-ийн гомдол барагдуулах механизм


97. Төслийн хэмжээнд нийгэм, байгаль орчны гүйцэтгэлийн талаар гомдол гаргагчийн санал, шүүмж, гомдлыг хүлээн авч, үнэлгээ хийн, шийдвэрлэх боломжийг бүрдүүлэхийн тулд төсөлд тусгайлан зориулсан гомдол барагдуулах механизм (ГБМ)-ыг бэлтгэсэн. ГБМ (зураг 1) нь төсөлд холбогдох нийгмийн болон байгаль орчны санал шүүмж гаргах, түүнийг түргэн шуурхай, ил тод шийдвэрлэх механизмыг бүрдүүлэх зорилготой. Төсөл хэрэгжүүлэх бүх яам, байгууллага, төслийн нөлөөлөлд өртөх оролцогч талуудад ГБМ-ыг танилцуулах бөгөөд төслийн аливаа асуудал, гомдлыг ХА, ТХН-үүдэд хэрхэн мэдээлэх талаар тайлбарлаж өгнө.

98. Аймгуудын төвд байгуулагдах ТХН-үүд нь төслийн нийгэм, байгаль орчны аливаа санал шүүмж, гомдлыг хүлээн авч, шийдвэрлүүлэхийн тулд ГБМ-ыг бүрдүүлж, ажиллуулна. 2 аймгийн ТХН Өмнөговь, Дэлүүн сумдын төвд ажиллах орон тооны ГБМ-ын ажилтныг томилж, тухайн ажилтнууд ГБМ-ыг сумын түвшинд хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. ГБМ төслийн сөрөг нөлөөлөлд өртсөн хүмүүсийн асуудлыг жендэрийн мэдрэмжтэй, соёлын хувьд тохиромжтой, бүх оролцогч тал үнэ төлбөргүй, ямар нэг саадгүй олж авах боломжтой бөгөөд ойлгомжтой, ил тод үйл явцаар түргэн шуурхай шийдвэрлэнэ. ГБМ нь улсын хууль тогтоомжийн системд нэвтрэхэд саад болохгүй.

99. ГБМ-ыг олон нийттэй зөвлөлдөх дагалдах уулзалтуудын үеэр танилцуулж, 3 аймаг, 2 сум дундын төвийн оролцогч талуудад нээлттэй болгоно. Гомдол гарсан тохиолдолд аймаг, сумын төвийн түвшин тус бүрд дараах 3 үе шатаар барагдуулна. Үүнд:

- (iv) Үе шат 1 (дээд тал нь 7 хоног): Барилгын ажлын явцад санал шүүмж гарвал сөрөг нөлөөлөлд өртсөн хүн буюу гомдол гаргагч тухайн асуудлыг гэрээт ажил гүйцэтгэгч, аймгийн ТХН-ийн ГБМ ажилтан, төсөл хэрэгжүүлэх, хяналт тавихад дэмжлэг үзүүлэх зөвлөх (ТХХТЗ)-үүд эсвэл олон нийтийн төлөөлөлд хандан гаргаж тавина. Бүх яам, байгууллага ГБМ-ыг мэдэж байх ба ямар нэг тохиолдол гарсан даруйд ТХН-ийн ГБМ ажилтанд мэдэгдэнэ. Тухайн асуудал гомдол гаргагч болон гүйцэтгэгчийн дунд шууд шийдэгдсэн бол дагалдах арга хэмжээ шаардлагагүй. Гэхдээ ГБМ-ын бүртгэлийн дэвтэрт бичиж, аймаг эсвэл сумын ТХН-ийн офист хадгална.
- (v) Үе шат 2 (дээд тал нь 15 хоног): Тухайн гомдол аймгийн нэгжийн түвшинд шийдэгдээгүй бол ТУН-ийн “нэг цэгийн үйлчилгээ” рүү уламжлах бөгөөд тэнд ГЗБГЗЗГ ба БХБЯ эсвэл БАХХ ба ХХААХҮЯ оролцоно. ТУН-ийн “нэг цэгийн үйлчилгээ” болон ГЗБГЗЗГ эсвэл БАХХ-ны аль хамааралтай нь 2 долоо хоногийн дотор хариу өгч, бүх үйл явцыг бичгээр бүртгэж авна.
- (vi) Үе шат 3 (дээд 15 хоног): Тухайн асуудал шийдэгдээгүй хэвээр байгаа бол ТУН, гомдол гаргагчтай харилцан тохиролцож, БХБЯ болон холбогдох олон нийтийн төлөөлөлтөй уулзалт хийж, асуудлыг тодорхойлно. Үүгээр асуудлыг шийдвэрлэж чадахгүй бол дээд шатны эрх бүхий байгууллагад уламжилна. БХБЯ үе шат 1-3 хүртэл аль ч үед ТУН-ийн дэмжлэгтэйгээр тухайн үйл явцыг АХБ-нд мэдээлж болох боловч үе шат 3 хүрсэн бол нэн даруй мэдээлнэ.

Зураг 1. Гомдол барагдуулах механизм



БХБЯ – Барилга, хот байгуулалтын яам, ГЗБГЗЗГ – Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, БАХХ – Бэлчээр ашиглагчдын холбоо

100. *Олон нийт* – Олон нийтэд мэдээлэл хүргэх өргөн хүрээний кампанит ажил хийж, кампанит ажлын турш гомдол барагдуулах механизмын талаар мэдээлэл олгоно. Төслийн удирдах нэгж (ТУН)-ийн (байгаль орчин, нийгмийн) асуудал хариуцсан ажилтан болон олон нийтийн хөгжлийн зөвлөхүүд тус кампанит ажлыг гүйцэтгэж, гомдол барагдуулах журам ба эрхийн талаар ядуу, эмзэг өрхүүдэд мэдээлэл өгч, тэдний гомдлыг барагдуулахын тулд ХА, ТХН болон төсөл хэрэгжүүлэх, хяналт тавихад дэмжлэг үзүүлэх зөвлөх (ТХХТЗ)-үүдтэй хамтран ажиллана.

101. *Гомдол гаргагч* (ГГ) гомдол барагдуулах эсвэл санал хүсэлт авах маягтыг бөглөж БХБЯ-аас суурилуулах “нэг цэгийн үйлчилгээ”-нд уламжлах эсвэл ойролцоо байршил дахь телефон утаснаас төлбөргүй дугаар руу ярих, цахим шуудан илгээх, захидал илгээх, “нэг цэгийн үйлчилгээ”-ний гомдлын бүртгэлд гомдлоо бичиж үлдээх г.м. уян хатан нөхцлөөр хангагдана.

102. Бүх барилгын ажлын талбай, нийгмийн үйлчилгээний барилга байгууламж, олон нийтийн төвд хүмүүс бичгээр үйлдсэн санал, асуудлаа албан ёсоор илгээх, цаг агаарын нөхцлөөс хамгаалсан хамгаалалт бүхий *гомдол саналын хайрцаг* байрлуулна. Бүх хайрцганд ТХН, орон нутгийн гүйцэтгэгч, орон нутгийн төслийн нэгжийн харилцах хүмүүсийн нэр бүхий мэдээллийг байлгаж, шинэчилж байна. Мөн хайрцаг бүрд энгийн маягт болон үзэг, бал хийж, харилцаа холбооны үйл явцын нөхцлийг бүрдүүлнэ.

103. Гомдол гаргагчийн нэр, гомдол хүлээн авсан он, сар, өдөр, тухайн хүний хаяг, холбоо барих хаяг, асуудалтай газрын байршил болон тухай асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн бүртгэлийг сайтар баримтжуулж авна. Төслийн удирдах нэгж (ТХН)-ийн ГБМ ажилтан (нийгэм, байгаль орчны асуудал хариуцна) байгаль орчин, нийгмийн хамгааллын асуудлаар гомдлыг түргэн шуурхай барагдуулах ерөнхий үүргийг хүлээнэ.

2. Бүртгэл хөтлөх

104. Аймаг, сумын ТХН болон ГБМ ажилтан бүх хүлээн авсан гомдлын бүртгэл, үүнд гомдол гаргагчийн холбоо барих хаяг, гомдол хүлээн авсан он, сар, өдөр, гомдлын шинж чанар, засаж залруулахаар харилцан тохиролцсон арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлсэн он, сар, өдөр болон эцсийн үр дүнг бүртгэж хадгална. Бүртгэгдсэн ба шийдвэрлэгдсэн гомдлын тоо, үр дүнг ТХН, БХБЯ, ГЗБГЗЗГ, ХХААХҮЯ, БАХХ-ны офис болон цахим хуудсанд нээлттэй, ил байршуулах ба хагас жил тутамд АХБ-нд илгээх хяналт шинжилгээний тайланд оруулна.

3. Хуваарьт хяналт хийх ба авсан сургамжийг баримтжуулах

105. Аймгийн ТХН-ийн ажилтнууд холбогдох ХА (БХБЯ, ГЗБГЗЗГ, ХХААХҮЯ, БАХХ)-ийн байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан ажилтнуудын дэмжлэгтэйгээр төслийн талбай тус бүрд ГБМ хэрхэн хэрэгжиж байгааг хянаж үзэн, механизмын үр дүн, ялангуяа гомдол гарахаас сэргийлэх, гарсан гомдлыг шийдвэрлэх төслийн чадавхийн мэдээллийг бүртгэж авна.

ХАВСРАЛТ G: БОНБУ-ИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨХИЙН АЖЛЫН ДААЛГАВРЫН ЖИШЭЭ

**Аймаг, сумын хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр
(АСХХОХ)-ийн
Байгаль орчны магадлан шинжилгээ хийх**

**Санал авах хүсэлт
ба
Ажлын даалгавар**

Он, сар, өдөр

ТАНИЛЦУУЛГА

Азийн хөгжлийн банк (АХБ) нь Аймаг, сумын хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр (АСХХОХ) –т Монгол улсад санал болгож буй төсөлд бэлтгэх техникийн туслалцаа (ТБТТ) –г баталсан болно. Төслийг хариуцан гүйцэтгэх агентлаг (ГА) нь Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ) байна. Аймаг, сумын хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр (АСХХОХ) нь Монгол Улсын тэргүүлэх аймгуудын хот, суурин газрын үйлчилгээг сайжруулахад оршино⁵. Энэхүү хөтөлбөр нь зорилтот бүс нутагт ногоон, хүртээмжтэй, өрсөлдөх чадвартай нутаг дэвсгэрийн хөгжлийг дэмжих зорилгоор бодит хөрөнгө оруулалт хийж одоо хэрэгжиж буй бодлогын хүрээг бэхжүүлэх, уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн доройтолд улс орны эмзэг байдлыг бууруулах болно. Хөтөлбөр нь газарзүйн хувьд чиглэгдсэн, цогц аргачлал нь эдийн засгийн өсөлт, төрөлжилтийн хөдөлгүүр болох боломж бүхий бүс нутгийн - орон нутгийн эдийн засгийн кластеруудыг тэргүүлэх чиглэлд чиглүүлнэ.

АСХХОХ нь олон шатлалт санхүүгийн зээлийн шугам (ОШСЗШ)-аар санхүүжинэ. ОШСЗШ-ын 1-р шатлал нь баруун гурван аймгийн Увс аймгийн Улаангом, Баян-Өлгий аймгийн Өлгий, Ховд аймгийн Жаргалант, Увс, Баян-Өлгий аймгийн Өмнөговь, Дэлүүн гэсэн хоёр сумын төвүүдэд чиглэгдэнэ.

Бүс нутгийн болон хот суурин газрын олон салбарт эдийн засгийн өсөлтийг АСХХОХ нь сонгогдсон гурван аймгийн төв, хоёр сумын төвүүдэд хөрөнгө оруулалтын гол төрөл нь дараах хөрөнгө оруулалтыг санхүүжүүлнэ. Үүнд:

- (i) Хотын үндсэн үйлчилгээ, барилга байгууламж болон дэд бүтэц,
- (ii) Хөдөө аж ахуйн бизнесийн хөгжил

ХИЙХ АЖЛЫН ЗОРИЛГО БА ЗОРИЛТУУД

Зөвлөх үйлчилгээ нь хоёр зорилттой: 1) АСХХОХ–т Монгол Улсын хууль, журамд нийцүүлэн БОНБУ хийж батлуулах болон 2) АСХХОХ–т АХБ-ны байгаль орчныг хамгаалах шаардлагад нийцүүлэн тайлан гаргаж батлуулах болно. Зорилтыг дэлгэрүүлэн доор дурдав:

⁵ Аймаг нь Монгол Улсын засаг захиргааны нэгж бөгөөд мжутаг дүйнэ. 21 аймагтай, аймаг бүр аймгийн төвтөй. Аймаг нь сумдаас бүрдэх ба сум нь бас сумын төвтөй. Монгол Улс нийт 304 сумтай (аймгуудын төвийг эс тооцон). Сум дундажаар 4 000 хүн амтай, 5 000 орчим км² нутаг дэвсгэртэй.

Зорилт #1:

АСХХОХ–ийн БОНБУ–г Монгол Улсын хууль, журамд нийцүүлэн бэлтгэж, батлуулах:

- а) БОАЖЯ-наас баталсан Байгаль орчны үнэлгээний тухай хууль (2012)-ийн дагуу АСХХОХ–ийн хүрээнд байгаль орчны магадлан шинжилгээ болон нөлөөллийн үнэлгээг хийж, гүйцэтгэх талаар БХБЯ-наас тавьсан бүхий л шаардлагыг биелүүлэхэд БХБЯ болон БХБЯ-ны харьяа хэрэгжүүлэгч агентлаг, аймгийн Төсөл хэрэгжүүлэгч нэгжүүд (ГЗБГЗЗГ, БАХХ)-д чиг үүргээр хангаж, туслалцаа үзүүлэх.
- б) АСХХОХ–ийн байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ (БОНЕУ)-ийн дүгнэлтийг БОАЖЯ–аар гаргуулахад шаарддагдах орон нутгийн албан бичиг болон БОАЖЯ–аас гаргуулах холбогдох бичиг баримтыг бэлтгэн хүргүүлэх.
- в) Ерөнхий үнэлгээний дүгнэлтийг үндэслэн АСХХОХ-т зориулан байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОННУ) болон байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-г бэлтгэх, боловсруулах, БОННУ эсвэл БОМТ-ийн баримт бичиг, тайланг боловсруулах, БОАЖЯ, аймаг, нийслэлийн Байгаль орчны газраар батлуулах.

Зорилт #2:

АХБ-ны Байгаль орчныг хамгаалах бодлогын шаардлагыг хангахын тулд (ХБББ, 2009) АСХХОХ–ийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээ (БОТБУ)-г хийхэд олон нийтийн хэлэлцүүлгийг хийж, байгаль орчны суурь түвшний үнэлгээг хийх.

- а) АХБ-ын шаардлагыг хангах зорилгоор сонгон авсан сумын төвүүдийн төсөл хэрэгжих талбай дахь нөлөөлөлд өртсөн айл өрхүүд болон төслийн бусад оролцогч талуудтай байгаль орчны асуудлын талаар хэлэлцүүлэг зохион байгуулах. АХБ-ны олон нийтийн хэлэлцүүлэг хийх ажлын удирдамж, зааварчилгааг А хавсралтад харуулав.
- б) Хавсралт В-д тусгасан мэдээлэл, агуулгын хүснэгтийг ашиглан АСХХОХ–ийн БОТБУ хийх зорилгоор АСХХОХ хэрэгжүүлэхээр сонгон авсан сумын төвүүдэд байгаль орчны суурь түвшний үнэлгээ хийж гүйцэтгэнэ.

Зөвлөх үйлчилгээний хүрээнд санал болгож буй ажлууд:

Зорилт #1:

АСХХОХ–ийн БОНБУ–г Монгол Улсын хууль, журамд нийцүүлэн бэлтгэж, батлуулах:

БОНЕУ:

- 1. АСХХОХ–ийн БОНЕУ хийлгэхэд шаардлагатай мэдээллийг тодруулах зорилгоор ТХН ХА, БХБЯ, БОАЖЯ, аймаг, орон нутгийн байгаль орчны хэлтэстэй уулзах, хамтран ажиллах.
- 2. БОНЕУ хийлгэхэд шаардлагатай өргөдлийг бэлтгэх (жишээлбэл, байгаль орчны төлөв байдал, АСХХОХ-ийн тодорхойлолт, орон нутгийн удирдлагын зөвшөөрөл г.м.)
- 3. Бэлэн болсон БОНЕУ-г БОАЖЯ-аас хүлээн авч, орчуулан ТБТТ-д хүргүүлэх.

БОННУ эсвэл БОМТ:

- 4. ТУН-тэй хамтран БОАЖЯ, аймаг, орон нутгийн байгаль орчны газрын шаардлагад нийцсэн БОННУ болон БОМТ-ний тайланг бэлтгэх, өргөн барих.
- 5. Төсөл хэрэгжүүлэх нэгж/хэрэгжүүлэгч агентлагийн тусламжтай БОННУ болон БОМТ-

ийг БОАЖЯ-аар хэзээ батлуулсан тухай ТБТТ-д бичгээр мэдэгдэх.

Зорилт #2:

Олон нийтийн хэлэлцүүлэг болон байгаль орчны төлөв байдлын үнэлгээг хийж АХБ-ны анхан шатны БОННУ-нд тайлагнах.

Олон нийтийн хэлэлцүүлэг:

1. Хавсралт А-д тусгасан ажлын удирдамжийг ашиглан ТУН / БХБЯ-тай хамтарч олон нийтийн хэлэлцүүлэх уулзалтуудын байршил, оролцогчид, хугацааг тодорхой болгох.
2. Нөлөөлөлд өртөх олон нийтийн удирдагчидтай зөвлөлдөх уулзалт зохион байгуулах.
3. Оролцогчдыг урьж, зөвлөлдөх уулзалтыг товлох.
4. Зөвлөлдөх уулзалт зохион байгуулах.
5. Зөвлөлдөх уулзалтын тайланг бэлтгэх.
6. БОТБУ-ний байгаль орчны суурь түвшин
7. Боломжтой өгөгдөл, мэдээллийг ашиглан Хавсралт Б-д заасан ажлын даалгаврын дагуу БОТБУ-ний суурь түвшинг тодорхойлох.

ЗӨВЛӨХ КОМПАНИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

1. Монгол Улсын БОАЖЯ-наас БОНБУ хийх тусгай зөвшөөрөл авсан байх.
2. Зөвлөхүүд нь ярианы болон бичгийн англи хэлний мэдлэгтэйг нотлох.
3. БОАЖЯ-нд дэд бүтцийн төслүүдэд БОННУ бэлтгэж БОАЖЯ-нд танилцуулж, хамгаалж байсан болон БОННУ-ийн дүгнэлтийн баримт бичиг бүрдүүлж байсан туршлагатайг нотлох.
4. АХБ-ны байгаль орчныг хамгаалах шаардлагад нийцүүлэн ажил гүйцэтгэж байсан туршлагатайг нотлох (ХБББ, 2009).

ЗӨВЛӨХИЙН САНАЛД ШААРДЛАГДАХ МЭДЭЭЛЭЛ

Санал ирүүлэх он, сар, өдөр:

Саналыг өртгийн тооцооллын хамт англи хэлээр бэлтгэж, дор заасан хаягаар ирүүлэх он, сар, өдөр:

Зөвлөх компанид тавигдах шаардлага:

1. БОАЖЯ-аас БОНБУ-ний тусгай зөвшөөрөл авсан он (тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргана).
2. БОАЖЯ-аар баталгаажсан болон одоо хийж гүйцэтгэж байгаа БОННУ-ийн ажлын жагсаалт.
3. БОАЖЯ-аар батлагдсан БОННУ-ний тайлангийн жагсаалт ирүүлэх. Бүх төслүүдийн захиалагч болон нэрийг тодорхой бичих.
4. АХБ-ны байгаль орчныг хамгаалах шаардлагад нийцүүлэн гүйцэтгэсэн ажлын жагсаалт (ХБББ, 2009).

Техникийн санал

Зорилт #1: АСХХОХ-ийн дагаж мөрдөх, үндэсний, бүх БОНБУ-ийн болон хамгааллын шаардлага (БОНЕУ, БОННУ, БОМТ)-ыг хэрхэн гүйцэтгэж, дуусган, БОАЖЯ-аар хэрхэн батлуулах тухай тодорхой тайлбарлах.

Зорилт #2: Доорхи ажлыг хэрхэн гүйцэтгэх тухай тодорхой танилцуулах:

- а) АХБ-ны ХБББ-ийн шаардлагын (2009) дагуу сонгосон сумын төвүүдийн нутаг дэвсгэрийн байгаль орчны талаархи олон нийтийн хэлэлцүүлгийг хэрхэн зохион байгуулах, явуулах, тайлагнах тухай
- б) БОТБУ-нд зориулж байгаль орчны төлөв байдал (хууль түвшин)-ыг тодорхойлох.

Санхүүгийн санал

Энэхүү ажлын даалгаврын хоёр зорилгын хүрээнд дор жагсаасан гэрээт ажлын үр дүнг бэлтгэх, гүйцэтгэхэд шаардлагатай зардлын задаргааг АНУ-ын доллараар гаргах. Гэрээ нь гэрээний эцсийн шатны гүйцэтгэл дуусмагц зарцуулсан мэргэжилтний хөлс, зардлыг олгох замаар хийгдсэн болно. Гэрээний дагуу гүйцэтгэх ажил доор жагсаасан дарааллаар хийгдэх албагүй.

Гэрээний дагуу бэлтгэх тайлан, баримт бичиг:

Зорилт #1:

- А) АСХХОХ-ийн БОНЕУ-г БОАЖЯ-аар батлуулж, орчуулж, ТБТТ-д өргөн барих.
- В) АСХХОХ-ийн БОННУ болон БОМТ-г боловсруулж БОАЖЯ, аймгийн Байгаль орчны газраар батлуулах, баталсан тухай албан бичгийг ТБТТ-г орчуулан өргөх барих.

Зорилт #2:

- С) Хавсралт В-д тусгасан удирдамжийн дагуу АСХХОХ-ийн БОТБУ-нд зориулж нөлөөлөлд өртөх газруудын байгаль орчны төлөв байдлын судалгааг хийж гүйцэтгэн, англи хэл дээр бэлтгэж, ТБТТ-д өргөн барих.
- Д) АХБ-ны Байгаль орчны талаархи олон нийтийн хэлэлцүүлгийн нарийвчилсан төлөвлөгөө, үүнд сонгосон сумын төвүүдийн нөлөөлөлд өртсөн хүн ам, оролцогчид, байршил, хуваарь зэргийг хавсралт А-д тусгасан удирдамжийн дагуу бэлтгэж, ТБТТ-аар хянуулсан байх.
- Е) АХБ-ны Олон нийтийн зөвлөлдөх уулзалтын үр дүнг нэгтгэн, тайланг хавсралт А-ийн удирдамжийн дагуу ТБТТ-аар хянуулах.

Нийт төлбөр, зардлаар зөвлөх үйлчилгээний үнийн задаргааг оруулах. Ажилтнуудын тоо, нийт даалгаврыг гүйцэтгэхэд ажилтнуудыг хэрхэн ажиллуулах талаар тодорхой мэдээлэл өгөх.

Гэрээт тайлан, баримт бичгийг бэлтгэх хуваарь

АСХХОХ-ийг хэрэгжүүлэхэд тавигдаж буй Монгол Улсын болон АХБ-ны байгаль орчны аюулгүй байдлын шаардлагыг бүрэн гүйцэт биелүүлэхийн тулд хугацааг нарийн төлөвлөж, мөрдөж ажиллах тул АСХХОХ-ийг батлагдахаас өмнө гэрээт ажлыг гүйцэтгэж, тус хөтөлбөрийн хэрэгжилтийг даруй эхлүүлэх боломжийг бүрдүүлэх ёстой.

Тиймээс, зөвлөх үйлчилгээний санал нь аль болох богино хугацаанд хийхээр төлөвлөх хэдий ч төслийн гэрээнд заасан ажил үүргийг гүйцэтгэх, хүлээлгэн өгөх хугацаа бодит байх ёстой.

Ажлын гүйцэтгэх хуваарийг гэрээ байгуулах үед хянаж үзнэ.

АХБ-ны бүрэлдэхүүн хэсгийг хасах магадлал

АСХХОХ–т АХБ-ны хамгааллын бодлогоор дэмжлэг үзүүлэх бусад боломжийн учраас ТБТТ нь гэрээ байгуулах эрх олгох ба хэлэлцээ хийх үед ажлын даалгаврын АХБ-ны бүрэлдэхүүн хэсгийг хасах эрхтэй. АХБ-ны бүрэлдэхүүн хэсэг гэдэг нь дээрх Зорилт 2 ба Гэрээний дагуу бэлтгэх тайлан, баримт бичгийн C, D, E зэрэг болно.

АСХХОХ-ийн талаар холбоо барих

Өртгийн тооцоолол бүхий саналыг АСХХОХ-ийн _____ хандан _____ хаягаар ирүүлэх

АСХХОХ-ийн тухай мэдээлэл авах хүсэлт эсвэл Санал авах хүсэлтийн талаар асууж, тодруулах зүйл байвал _____ хаягаар илгээх.

ХАВСРАЛТ Н: БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

Зорилт

Энэхүү зөвлөх үйлчилгээний зорилго нь Аймаг, сумын төвийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр (АСХХОХ)-ийг байгаль орчны хувьд ээлтэй, тогтвортой байдлаар явуулах, АСХХОХ боловсруулахад байгаль орчны холбогдох асуудлуудыг авч үзэхэд оршино. Энэ зорилгын хүрээнд тухайн газар нутгийн газар зүй, экологи, нийгэм, эдийн засаг, соёлын нөөцөд байгаль орчны талаас хэрхэн нөлөө үзүүлэхийг тодорхойлохын тулд АХБ-ны Хамгааллын бодлогын баримт бичгийн (2009) дагуу тухайн төсөлд байгаль орчны төлөв байдлын үнэлгээ (БОТБҮ) болон байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) бэлтгэх юм.

Ажлын хамрах хүрээ

Зөвлөх дараахь ажил үүргийг гүйцэтгэнэ:

- Үндэсний зөвлөхийн тусламжтай эхний мэдээллийг (одоо мэдээлэл байхгүй бол суурь мэдээллийг ашиглана) цуглуулах, дүн шинжилгээ хийх.
- Дэд төслүүдэд өмнө хийгдсэн экологийн, геотехникийн, гидрогеологийн болон бусад холбогдох судалгаа зэрэгт дүн шинжилгээ хийх.
- Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, тэдгээрийг бууруулах арга хэмжээг боловсруулах.
- Төслийн байршил, дизайн, технологи, мөн "төсөл хэрэгжихгүй байх хувилбар" зэрэг төслийн боломжит хувилбаруудыг судлах, дүн шинжилгээ хийх.
- Үндэсний зөвлөхийн тусламжтайгаар нөлөөлөлд өртсөн хүмүүс, төрийн бус байгууллага, эмэгтэйчүүд зэрэг бүх оролцогч талуудын оролцоог хангах уулзаж, ярилцах, олон нийтийн хэлэлцүүлэг хийх (БОНБҮ-ний хүрээнд дор хаяж хоёр удаа, анхан шатны БОТБҮ-д нэг удаа), Хэлэлцүүлэгт оролцсон хүмүүсийн нэрсийн жагсаалт, хэзээ, хаана болсон, хэлэлцүүлгийн явцад ямар асуудлыг ярилцсан зэрэг мэдээллийг системтэйгээр тэмдэглэл хөтөлж, БОНБҮ / БОТБҮ-ний тайланд хавсаргах.
Байгаль орчны асуудлаар оролцогч талуудын гаргасан гомдлыг хүлээн авч шийдвэрлэх зорилгоор Гомдол барагдуулах механизмыг бий болгох.
- БОМТ бэлтгэх.
- АХБ-ны Хамгааллын бодлогын баримт бичгийн (2009) Хавсралт 2-ийн Хавсралт 1-ийн дагуу анхан шатны БОТБҮ болон БОМТ бэлтгэх.

ХАВСРАЛТ I: БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ТОЙМ

Гүйцэтгэлийн хураангуй

Энэ хэсэгт төслийн гол чухал мэдээлэл, үнэлгээний үр дүн, нөлөөллийг бууруулах, арилгахад чиглэсэн үйл ажиллагааг үнэн зөв тодорхойлно.

Бодлого, хууль эрх зүй, захиргааны хүрээ

Тус хэсэгт байгаль орчны үнэлгээтэй холбоотой үндэсний болон тухайн орон нутгийн хууль эрх зүй, байгууллагын тогтолцоог авч үзэх болно. Түүнчлэн тус улсын нэгдэн орсон төсөлтэй холбоотой байгаль орчны олон улсын гэрээ, хэлэлцээрийг тодорхойлно.

Төслийн танилцууга

Энд тухайн төслийн талаар танилцуулна. Үүнд төслийн гол бүрэлдэхүүн хэсэг; түүний газарзүй, экологи, нийгмийн нөхцөл байдал, мөн төслийн шаардлагатай болон түүнд холбогдох бусад байгууламж (жишээлбэл, төслийн зам, цахилгаан станц, усан хангамж, нүх цооног, хог хаягдлыг зайлуулах, устгах гэх мэт) хамаарна. Ихэвчлэн төслийн зураг, холбогдох байгууламжийн байршил, төслийн хэрэгжих талбай, төслийн нөлөөллийн бүсийг харуулсан зураг, газрын зургийг багтаана.

Байгаль орчны (суурь мэдээ) танилцуулга

Энэ хэсэгт судалгааны талбайд хамаарах физик газар зүй, биологи, нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлыг тайлбарлана. Төслийн нөлөөллийн бүс дэх төсөлд дам байдлаар холбоотой одоогийн нөхцөл байдал болон төслийн бүтээн байгуулалтын ажлуудыг авч үзнэ. Үнэн зөв, найдвартай мэдээллийн эх сурвалжтай байна.

Байгаль орчинд үүсэх нөлөөлөл, тэдгээрийг бууруулах арга хэмжээ

Энэ хэсэгт төсөл хэрэгжих газар нутгийн байгаль орчин, биологи, нийгэм эдийн засагт (хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдал, эмзэг бүлэг, жендертэй холбоотой асуудлууд, хүрээлэн буй орчны мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүн амын амьжиргаанд нөлөөлөл [Хавсралт 2, 6-р заалт]) үзүүлэх эерэг ба сөрөг, шууд болон дам нөлөөлөл, төслийн нөлөөллийн бүс дэх соёлын биет өв, дурсгалд үзүүлэх нөлөөллийг боломжтой бол тоон утгаар урьдчилан таамаглаж, үнэлнэ. Мөн нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнчлэн бууруулах боломжгүй аливаа үлдэх сөрөг нөлөөллийг тодорхойлно; Цаашид сайжруулах боломжийг судлана; Боломжит мэдээллийн цар хүрээ, чанар, орхигдсон мэдээлэл, тодорхой бус байдлыг тодорхойлж, үнэлэх ба цаашдын анхаарал хандуулах шаардлагагүй сэдвийг тусад нь тодорхойлж өгөх; шаардлагатай бол дэлхийн, хил дамнасан, хуримтлагдах нөлөөллийг судалж үзнэ.

Бусад хувилбарын шинжилгээ

Энэ хэсэгт санал болгож буй төслийн хэрэгжих талбай, технологи, зураг төсөл, үйл ажиллагаануудын хувилбарууд мөн төсөл хэрэгжихгүй байх хувилбарыг байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хувьд авч үзэх; мөн эдгээр нөлөөллийг багасгах боломж; капитал болон урсгал зардал; тэдгээрийн орон нутгийн нөхцөлд тохирсон байдал; тэдгээрийн институци,

сургалт, хяналт мониторинг хийх шаардлага зэрэгт дүн шинжилгээ хийнэ. Мөн төслийн дизайны эцсийн хувилбарыг сонгох үндэслэлийг тодорхойлж, төслөөс ялгаруулж болох хүлэмжийн хийн хэмжээг тогтоож, байгаль орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, багасгах арга барилыг санал болгоно.

Мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах, хэлэлцүүлэг хийх, оролцоог хангах

Энэ хэсэгт:

(i) Төслийг боловсруулах, бэлтгэх явцад төслөө танилцуулах, нөлөөлөлд өртсөн хүмүүс болон бусад оролцогч талуудтай зөвлөлдөх, хэлэлцэх зэрэг оролцогч талуудыг татан оролцуулах үйл явцыг дүрслэнэ.

(ii) Нөлөөлөлд өртөх хүмүүс болон бусад оролцогч талуудаас ирүүлсэн санал, гомдлыг төслийн дизайн болон нөлөөллийг бууруулах арга хэмжээнд хэрхэн шийдвэрлэсэн талаар ялангуяа эмзэг бүлгийн, тэр дундаа эмэгтэйчүүд, ядуу, уугуул иргэдийн хэрэгцээ, шаардлагад онцгой анхаарал хандуулж, мөн төслөө танилцуулах төлөвлөсөн арга хэмжээ (танилцуулах хэлбэр, арга зүй) болон нөлөөлөлд өртсөн хүмүүстэй зөвлөлдөх, хэлэлцүүлэг хийсэн байдал, төслийн хэрэгжүүлэх явцад тэдний оролцоог хангасан үйл явцыг тайлбарлана.

Гомдол барагдуулах механизм

Энэ хэсэгт гомдлыг шийдвэрлэх арга (албан бус болон албан ёсны аль алинд нь), байгаль орчны гүйцэтгэлийн талаархи гомдлыг шийдвэрлэх хугацаа, механизмыг тодорхойлно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Энэхүү хэсэгт байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, багасгах, нөхөн төлбөр өгөх зорилгоор төслийг хэрэгжүүлэх үе шатанд хэрэгжүүлэх менежментийн цогц арга хэмжээг авч үздэг. Үүнд олон төлт менежментийн төлөвлөгөө, арга хэмжээ орно. Үүнд дараах үндсэн хэсгүүд багтана (төслийн нөлөөлөл ба эрсдлийн хэмжээг нарийвчилан тодорхойлно):

(i) Нөлөөллийг бууруулах арга хэмжээ:

- (a) Байгаль орчны сөрөг нөлөөлөл, эрсдлийг тодорхойлж, нэгтгэн дүгнэх.
- (b) Нөлөөллийн төрөл, нөхцөл байдал (жишээ нь, үргэлжлэх эсвэл болзошгүй нөхцөл байдал), төслийн дизайн, тоног төхөөрөмж, үйл ажиллагаатай холбоотой нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлно.
- (c) Бусад холбогдох төслүүдтэй холбож өгөх (жишээлбэл, сайн дураар нүүх, уугуул иргэд, эсвэл яаралтай хариу арга хэмжээ).

(ii) Хяналт шижнилгээ:

- (a) Хэмжих параметрууд, ашигласан арга, дээж судлагаа авсан байршил, хэмжилтийн давтамж, илрүүлэх хязгаарлалт, залруулах шаардлагатай босго түвшин зэрэг техникийн нарийвчилсан мэдээллийн дагуу хяналт шинжилгээний арга хэмжээг тодорхойлно.
- (b) Нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах шаардлагатай нөхцлийг эрт илрүүлэх, үр дүнг баримтжуулах зорилгоор хяналт тавих, тайлагнах журмыг тайлбарлана.

(iii) Хэрэгжүүлэх зохион байгуулалт:

- (a) Төслийн хэрэгжилтийн үе шат, хэрэгжүүлэх хуваарийг тусгана.
- (b) Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, хянах арга хэмжээг хариуцдаг

байгууллага зохион байгуулалтын бүтцийг тодорхойлно. Үүнд, байгаль орчны менежментийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор дараахь нэг буюу хэд хэдэн сэдвийг багтаасан байж болно: техникийн туслалцаа, сургалтын хөтөлбөр, байгаль орчны менежмент, хяналт шинжилгээтэй холбоотой тоног төхөөрөмж худалдан авах, байгууллагын өөрчлөлт зэрэг асуудал орж болно.

- (с) Капитал болон урсгал зардлыг тооцоолж, байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлно.

(iv) Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд: хүссэн үр дүнг боломжтой бол хэмжих, тухайлбал гүйцэтгэлийн үзүүлэлт, зорилтот түвшин, хүлээн авах шалгуур зэргийг тодорхойлно.

Дүгнэлт ба зөвлөмж

Энэ хэсэгт үнэлгээнд үндэслэн дүгнэлтийг гаргаж, зохих зөвлөмж өгнө.

Байгаль орчны хяналтын хагас жилийн тайлангийн тойм

Зээлдэгч/захиалагч нь төслийн БОМТ-ний хэрэгжилтийн явц, байгаль орчны нийцэл, залруулах арга хэмжээний талаархи хяналт шинжилгээний хугацаат тайланг бэлтгэх үүрэгтэй. Тайлангийн хамрах хүрээг доор харуулав. Бүх бүлгийг хамрахгүй байж болно. Байгаль орчны нийцэх, нөлөөллийг бууруулах арга хэмжээний үр нөлөөг үнэлэх зэрэглэх систем нь зөвхөн жишээ бөгөөд шаардлагатай бол өөрчилж болно.

Танилцуулга

1.1. Тайлангийн зорилго

1.2. Төслийн хэрэгжилтийн явц

1.2.1. Төслийн талбайн ажил (төслийн талбай дах ажил, байршил, төлөвлөсөн гүйцэтгэлийг тодорхойлох)

1.2.2. Өмнөх үйл ажиллагаа (өмнөх саруудад хийгдсэн барилгын ажил: газар шорооны ажил, хөрсөн бүрхэвчийг хуулах, хог хаягдлыг зайлуулах, барилгын ажилчдын байр сууц барих, бусад барилга байгууламжтай холбоотой ажлуудыг нарийвчлан тодорхойлох (жишээлбэл бетон зуурмагийн үйлдвэр, асфальт зуурмагийн үйлдвэр, бутлах үйлдвэр гэх мэт), нүх суваг шуудуу ухах талбайн байршил, хугацаа, хуваарь, огноо гэх мэт.

1.2.3. Дараагийн саруудад хийх барилгын ажлын хуваарь (дээрхтэй төстэй мэдээллийг оруулна уу)

АХБ-ны зээлийн гэрээ, Засгийн газрын холбогдох хууль тогтоомж, журам, шаардлагад нийцэх

2.1. АХБ-ны зээлийн гэрээний шаардлагыг дагаж мөрдөх байдал: байгаль орчны зээлийн гэрээний жагсаалтыг гаргаж, дагаж мөрдөх хэм хэмжээ заана уу)

2.2. Засгийн газрын байгаль орчны хууль дүрэм журмыг дагаж мөрдөх байдал: уг төсөлтэй холбоотой засгийн газраас баталсан байгаль орчны хууль журам (зөвшөөрөл, гэх мэт), барилга байгууламжтай үйл ажиллагааны жагсаалтыг гаргаж, дагаж мөрдөх түвшинг тодорхойлж, төсөл, барилга байгууламжтай холбоотой үйл ажиллагаанд шаардлагатай байгаль орчны зөвшөөрөл / лиценз / зөвшөөрөл авах эсэхийг нягтлана.

Төслийн хамрах хүрээнд өөрчлөлт хийх

Үүнд: АХБ-аас гаргасан байгаль орчны үнэлгээний тайланд (жишээ нь: БОТБҮ) тодорхойлсон төслийн хамрах хүрээ, хэрэв шаардлагатай бол холбогдох хамгаалалтын арга хэмжээ зэргийг харгалзан үзэх замаар хөгжлийн чиглэл, дэд бүтцийн өөрчлөлт, төслийн нэмэлт бүрэлдэхүүн хэсэг / хэсгийг хэрэгжүүлэх гэх мэт өөрчлөлтүүд. холбогдох боломжтой.

Төслийн гэрээний зохион байгуулалтад байгаль орчны шаардлагыг шинэчлэн тусгах

БОМТ-ний шаардлагыг гэрээлэгчтэй хийх гэрээний зохицуулалтад тусгаж өгөх арга.

Байгаль орчны нөлөөллийг бууруулах, нөхөн төлбөр олгохоор хэрэгжүүлсэн арга хэмжээний тойм

БОМТ-нд үндэслэн агаарын чанар, усны чанар, дуу чимээний чанар, бохирдлоос урьдчилан сэргийлэх, биологийн олон янз байдал, байгалийн нөөц, эрүүл мэнд, аюулгүй байдал, соёлын нөөц, чадавхийг бэхжүүлэх, бусадтай холбогдох арга хэмжээг хамруулж болно. БОМТ-д заасан байгаль орчны нөлөөллийг бууруулах арга хэмжээ, гүйцэтгэлийг хураангуйлж, хүснэгт / матрицаар үзүүлэх.

<i>БОМТ-ийн шаардлага (БОМТ-д заасан бүх арга хэмжээг жагсаах)</i>	<i>Нийцэл (Тийм, Үгүй, Хэсэгчилэн)</i>	<i>Нийцлийг хэсэгчилэн эсвэл огт хангаагүй шалтгаан</i>	<i>Цаашид авах арга хэмжээ, хугацаа</i>
1.			
2.			
3.			
etc.			

Байгаль орчны хяналтын тойм

6.1. Нийцлийг хянах, шалгах

- 6.1.1. Хяналт шалгалтын ажлын хураангуй
- 6.1.2. Нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийцэл²¹
- 6.1.3. Нөлөөллийг бууруулах арга хэмжээний үр ашиг²²

6.2. Хүлэмжийн хийн ялгаруулалт, бохир ус (эх үүсвэр)-ыг хянах хөтөлбөр (БОМТ-тэй холбоотой болон шаардлагатай бол)

- 6.2.1. Хяналт шинжилгээний хураангуй
- 6.2.2. Үр дүн

6.3. Орчны мониторингийн хөтөлбөр, жишээлбэл, агаарын чанар, дуу чимээ, усны чанар гэх мэт (БОМТ-д холбоотой эсвэл шаардлагатай бол)

- 6.3.1. Хяналт шинжилгээний хураангуй
- 6.3.2. Үр дүн

6.3.3. Үнэлгээ²³

²¹ Нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагыг биелүүлсэн эсэхийг чанарын хувьд тодорхойлох эсвэл дараахь байдлаар зэрэглэлийн системд үндэслэн үнэлэх боломжтой:

1. Маш сайн (шаардлагатай бүх арга хэмжээг хэрэгжүүлсэн)
2. Сайн (шаардлагатай арга хэмжээнүүдийн дийлэнх нь хэрэгжсэн)
3. Дунд (зарим бууруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн)
4. Муу (цөөн тооны арга хэмжээ хэрэгжүүлсэн)
5. Маш муу (маш цөөхөн эсвэл огт арга хэмжээ аваагүй).

Шаардлагатай бол нэмэлт тайлбар өгнө.

²² Нөлөөллийг бууруулах үр нөлөөг чанарын хувьд тодорхойлж, эсвэл дараахь байдлаар зэрэглэх системд үндэслэн үнэлэх боломжтой:

1. Маш сайн (бууруулах арга хэмжээ өндөр үр дүнтэй)
2. Сайн (бууруулах арга хэмжээ нь ерөнхийдөө үр дүнтэй)
3. Дунд зэрэг (бууруулах арга хэмжээний зарим нь үр дүнтэй)
4. Муу (бууруулах арга хэмжээ нь ерөнхийдөө үр дүнгүй)
5. Маш муу (арга хэмжээ огт үр дүнгүй)

Шаардлагатай бол нэмэлт тайлбарыг өгнө.

Байгаль орчны тулгамдаж буй гол асуудлууд

- 7.1. Гол асуудлууд (жишээ нь, зээлийн гэрээний шаардлага, БОМТ эсвэл байгаль орчны хууль, дүрэм, журмыг мөрдөөгүй, эсвэл төслийн нөлөөлөл, осол, аваар ослыг бууруулах арга хэмжээ хангалтгүй байх).
- 7.2. Авсан арга хэмжээ, залруулах арга хэмжээний төлөвлөгөө (үл нийцэл болон бусад асуудлуудыг шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх арга хэмжээ, залруулах ажиллагааны төлөвлөгөөг зааж өгнө. Ийм үйл ажиллагааны төлөвлөгөө нь тухайн асуудлыг шийдвэрлэхэд хийх тодорхой ажлуудыг нарийвчилж өгөх хэрэгтэй. Мөн шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, хариуцах хүн, үйл ажиллагааны төлөвлөгөөг доорхи ямагаар хүснэгт / матриц хэлбэрээр гаргаж болно. Залруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцын талаар АХБ-д тайлагнах хугацаа, үүрэг хариуцлагыг мөн энэ бүлэгт зааж өгөх ёстой.

Асуудал	Учир шатлгаан	Шаардлагатай арга хэмжээ	Хүлээх үүрэг	Хугацаа (зорилто т он, сар, өдөр)	Шийдэл ба хугацааны тайлбар (бодит)
Өмнөх тайланд тодорхойлсон асуудлууд					
1.					
2.					
Одоогийн тайланд тусгагдсан шинэ асуудлууд					
1.					
2.					

7.3. Шаардлагатай нэмэлт арга хэмжээ

²³ Орчны нөхцлийг БОМТ-д тусгасан орчны холбогдох стандарт ба / эсвэл гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулах шаардлагатай. Стандарт хэмжээнээс хэтэрсэн тохиолдол бүрийг анхааралдаа авч, эргэн хянах хэрэгтэй. Үүнээс гадна орчны нөхцөл байдлыг суурь нөхцөлтэй харьцуулж (суурь мэдээлэл байгаа бол) чанарын хувьд тодорхойлж, эсвэл дараахь байдлаар зэрэглэлд үндэслэн үнэлэх боломжтой:

1. Маш сайн (ерөнхий нөхцөл байдал сайжирсан)
2. Сайн (нөхцөл байдал бага зэрэг сайжирсан)
3. Дунд зэрэг (нөхцөл байдал өөрчлөгдөөгүй)
4. Муу (нөхцөл байдал бага зэрэг доройтсон)
5. Маш муу (нөхцөл байдал маш ихээр доройтсон)

Шаардлагатай бол нэмэлт тайлбарыг өгнө.

Санал, гомдол

- 8.1. Санал, гомдолын дэлгэрэнгүй мэдээлэл (Орон нутгийн хүн ам болон бусад оролцогч талуудын байгаль орчны төлөв байдал, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар өргөдөл гаргасан гомдлын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг өгөх (гомдол гаргагч, гомдлын шинж чанар, гомдлыг аль өдөр хүлээн авсан, аль байгууллага нь хүлээн авсан гэх мэт))
- 8.2. Авсан арга хэмжээ (дараахь зүйлийг заах замаар гомдлыг хэрхэн шийдвэрлэж, шийдвэрлэх талаар баримтжуулна:
 - i. Гомдлыг хүлээн авах, баримтжуулах, шийдвэрлэхэд оролцсон Гомдлыг бууруулах ажилтан, гүйцэтгэх байгууллага, төслийн менежментийн хэсэг, орон нутгийн засаг захиргаа, гүйцэтгэгч эсвэл хяналт шалгалтын зөвлөх дэх тодорхой ажилтан, албан тушаалтнуудын нэр, томилгоо.
 - ii. гомдлыг шийдвэрлэх талаар тодорхой арга хэмжээ авах, холбогдох хугацаа.

Дүгнэлт ба зөвлөмж

- 9.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт хэрэгжилтийн явц²⁴
- 9.2. Тодорхойлсон асуудлууд ба шийдвэрлэхээр зөвлөмж болгосон арга хэмжээ
- 9.3. Хяналт шинжилгээний тохируулга (хяналт шинжилгээний туршлага, чиг хандлага, оролцогч талуудын хариултад суурилан зөвлөмж болгосон хяналт шинжилгээний өөрчлөлт).

Хавсралтууд

1. Төслийн ажлын талбайд хийсэн үзлэг шалгалт, хяналт шинжилгээний тайлангууд
2. Эх үүсвэрийн ба орчны мониторингийн үр дүн (лабораторийн шинжилгээний дүн)
3. Фото зураг
4. Дээж авсан цэгүүдийн байршлыг харуулсан газрын зураг
5. Байгаль орчны зөвшөөрөл, баталгааны хуулбц
6. Бусад холбогдох мэдээлэл, баримт бичиг.

²⁴ Байгаль орчны менежментийн явцыг чанарын үзүүлэлтүүдээр тайлбарлаж болно эсвэл дараахь байдлаар зэрэглэх системд үндэслэн үнэлж болно. Үүнд:

1. Маш сайн
2. Сайн
3. Дунд
4. Муу
5. Маш муу

Шаардлагатай бол нэмэлт тайлбар өгнө.

ХАВСРАЛТ J. АСХХОХ-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭРСДЭЛ БА БАТАЛГАА

Байгаль орчин

1. Зээлдэгч нь БХБЯ-аар салбарын зээлийн хүрээнд санхүүжүүлсэн АСХХОХ-ийн I шатлал ба дараа дараагийн шатлалын бэлтгэл ажил, зураг төсөл, барилга угсралт, хэрэгжүүлэх, ашиглалтад оруулах ажлыг (a) Зээлдэгчийн байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбогдох бүх хууль тогтоомж, дүрэм журам, (b) Хамгаалалтын бодлогын баримт бичиг, (c) БОУХХ, (d) аймгийн БОМТ, БОТБҮ-ийн шатлалд тусгасан бүх арга хэмжээнүүд, Хамгаалалтын хяналтын тайланд тусгагдсан аливаа засвар, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд нийцүүлэн ажилуулах үүрэгтэй.
2. Зээлдэгч нь БХБЯ-ыг АСХХОХ-ийн шатлалын дурын бүрэлдэхүүн хэсгүүд агробизнес, бэлчээрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хамт тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН), эсвэл ховор тохиолддог амьдрах орчинд ойрхон байрлуулахаас зайлхийлгэх үүрэгтэй.
3. Зээлдэгч нь тогтвортой ус хангамж, газрын доорхи ус, гадаргын усыг ус их шаарддаг төслийн бүрэлдэхүүн хэсгүүд болон усны нөөцийг ашиглагч бусад хэрэглэгчдэд хүртээмжтэй байлгахын тулд газар дээрхи нарийвчилсан хэмжилтийг БХБЯ-аар хийлгүүлэх үүрэгтэй.
4. Зээлдэгч нь БХБЯ-ыг АСХХОХ-ийн хэрэгжилтийн явцад дараахийг хангуулах үүрэгтэй:
(a) хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй аливаа төслийн өөрчлөлтийг хянана, (b) АХБ-тай зөвшилцсөний дагуу хүрээлэн буй орчны хяналт-шинжилгээ, нөлөөллийг бууруулах арга хэмжээг байгаль орчны бүрэн нийцлийг хангах зорилгоор шинэчлэн боловсруулна, (c) дизайн, барилга угсралт, ашиглалтад шаардагдах нөлөөллийг бууруулах арга хэмжээний санал болгосон өөрчлөлтийг 60 хоногийн дотор АХБ-д өгөх.
5. Зээлдэгч нь БХБЯ-ыг ажил гүйцэтгэгчдэд дараахь нөхцлийг бүрдүүлэлт хийлгүүлэх үүрэгтэй: (a) БХБЯ-ны Байгаль орчны хэлтсээс бүх карьерийн талбай сонгох, нүх ухах, хаягдлыг устгах зөвшөөрөл авах, (b) барилгын ажил эхлэхээс өмнө олж авсан олдвор, шаардагдах хэмжээний хөрсийг олборлох, нүх ухах, карьерын газрыг сонгох, (c) төслийн ажлын талбайг БОМТ-д заасан шалгуурын дагуу сонгосон гэдгийг баталгаажуулсан байх, (d) БОМТ-нд тусгасан заалтуудын дагуу ажлын талбайн менежмент хийх.
6. Зээлдэгч нь БХБЯ-ыг Аймгийн БОМТ-д заасны дагуу аймгийн төвүүд дэх дахин төлөвлөсөн Багуудын барилга, хашааг нураалгах, АХБ-ийн “Хөрсний бохирдол ба газар дээрх ариутгал” (Буцалтгүй тусламжийн төсөл: 49113-00) төслийн техникийг ашиглан газар нутгийг цэвэрлэх ажлыг эрхлүүлэх үүрэгтэй. Дахин боловсруулалт хийх боломжгүй нурсан бүх барилгын материалыг дээр дурдсанчлан БХБЯ-ны зөвшөөрөгдсөн хогийн цэг дээр хаях ёстой.
7. Зээлдэгч нь БХБЯ-ыг БОМТ-ий дагуу барилгын ажлын явцад төслийн бүх хэсэгт байрлах олон нийтийн усны ТҮЦ-ийн өнөөгийн хүртээмжийг тасалдуулахгүйн тулд онцгой анхаарал тавиулах үүрэгтэй. Шаардлагатай тохиолдолд Зээлдэгч нь барилгын ажлын үеэр гэр бүлийн бүх гишүүд ТҮЦ-үүдэд хялбар, аюулгүй нэвтрэх боломжийг олгох зорилгоор Аймгийн ТХН-ээр дамжуулан явган хүний гарц эсвэл аюулгүй явган хүний зам тавьж өгнө.
8. Зээлдэгч нь эко хорооллын орон сууцны барилга байгууламж, соёлын үнэт дурсгалт зүйл, түүнчлэн бүх сургууль, олон нийтийн төвүүдээс зайлсхийх эсхүл малтлага, ухлагын хооронд хаалт, хашлага хийн саад тотгор учруулахгүй байх талаар нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай. Тухайлбал, Зээлдэгч нь: (a) тухайн аймгийн БОМТ-д заасны дагуу эдгээр байгууламжид нэвтрэх боломжгүй соёлын болон олон нийтийн байгууламжийн ойролцоо, хүнд даацын машин, ачааны машин байрлуулахгүй байхыг анхаарна.

9. Зээлдэгч нь БХБЯ-аар байгуулах, ажиллуулах, ашиглалтад оруулахад чиглэсэн бүх багц тоног төхөөрөмжид хамгийн сайн туршлагыг ашиглуулахыг баталгаажуулах ёстой. БХБЯ-ны хяналт дор гүйцэтгэгч нь Дэлхийн Банк (ОУСК) БОЭААБ-ийн удирдамжид заасан олон улсын удирдамжийг 1) *Цемент ба шохойн үйлдвэрлэл*, 2) *Барилгын материал олборлох*; дагаж мөрдөх ёстой, 3) *Газрын тосны жижиглэнгийн сүлжээнд* дагаж мөрдөнө. Батлагдсан USEPA (2014) Бетон зуурмагийн боловсруулалтын туршилтын журам талаар зөвлөгөө авах боломжтой.

10. Зээлдэгч нь БХБЯ-ны зүгээс: (a) төслийн хэрэгжилтийг хангах зөвлөхүүд, түүний дотор хамгаалалтын мэргэжилтнүүдийг цаг тухайд нь ажиллуулах, (b) аймгийн БОМТ-ийн хүрээнд батлагдсан хяналтын төлөвлөгөөний дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын мониторингийг тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудаар давтамжтай хийлгэхээр гэрээ байгуулан ажиллах, (c) аймгийн БОМТ-д тодорхойлсон чадавхийг нэмэгдүүлэх хөтөлбөр, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө нь зөвлөхүүд оролцсон өдрөөс эхлэн төсөл дуусах хүртэл төлөвлөсөн байдлаар хэрэгждэг.

Хамгааллын шаардлагыг хэрэгжүүлэх боловсон хүчний ба санхүүгийн нөөц

11. Зээлдэгч нь БХБЯ-ыг аймгийн БОМТ, НШТ-г бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, хүний нөөцийг бүрдүүлэлт хийлгэх үүрэгтэй.

12. Зээлдэгч нь БХБЯ-аар: (a) Төслийн хамгааллын мэргэжилтнүүдийг оролцуулан төслийг хэрэгжүүлэх зөвлөхүүдийг цаг тухайд нь хамруулах, (b) батлагдсан хяналтын төлөвлөгөөний дагуу байгаль орчны нөлөөллийн хяналт шинжилгээг үе үе тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар хийлгэх, (c) аймгийн БОМТ болон НШТ-д тусгасан чадавхийг хөгжүүлэх хөтөлбөр нь Төсөл дуусах хүртэл зөвлөхүүд оролцсон өдрөөс хэрэгжүүлэхийг хангуулах үүрэгтэй.

Тендерийн баримт бичиг, ажил гүйцэтгэх гэрээний хамгаалалттай холбоотой заалт

13. Зээлдэгч нь БХБЯ-наас ажлын бүх тендерийн баримт бичгүүд гэрээнд гэрээлэгчээс дараахь зүйлсийг агуулсан байхыг хангуулах үүрэг хүлээнэ:

- a. БОТБУ, Аймгийн БОМТ, НШТ-д заасан гүйцэтгэгчтэй холбогдох арга хэмжээ (барилгын ажлын явцад өртсөн хүмүүст үзүүлэх нөлөөллөөс хамаарч), түүнчлэн хамгааллын хяналтын тайланд тусгасан аливаа засварласан, урьдчилан сэргийлэх арга хэмжээг дагаж мөрдөх.
- b. Байгаль орчин, нийгмийн бүхий л арга хэмжээний төсөв гаргах.
- c. БХБЯ-нд БОТБУ, аймгийн БОМТ, НШТ-д тооцоолоогүй боловч төслийг барьж байгуулах, хэрэгжүүлэх, ажиллуулах явцад хийсэн аливаа нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой үүсэх эрсдэл, нөлөөллийн талаар бичгээр мэдэгдэх.
- d. Богино хугацаанд зам, бусад орон нутгийн дэд бүтцийг төслийн өмнөх нөхцөл байдалд аль болох дөхүүлэх, бүтээн байгуулалтын ажил дууссахаас өмнө нөхөн сэргээх.

Хамгааллын арга хэмжээний хяналт шинжилгээ, тайлагнал

14. Зээлдэгч БХБЯ-аар дараахь зүйлийг гүйцэтгүүлэх үүрэг хүлээнэ:

- a) Төслийн барилгын ажил болон ашиглалтын буюу БОМТ-ний хэрэгжилтийн хугацаанд жил тутам БОМТ-нд илүү урт хугацаа заагаагүй бол АХБ-ны төслийн гүйцэтгэлийн тайлан гаргах хүртэл хугацаанд Байгаль орчны хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх дагаж мөрдөх журам, Аймгийн БОМТ-нүүдийн хүрээнд АХБ-нд Хамгаалалтын арга хэмжээний хяналтын тайланг танилцуулж, ийм тайлангуудаас холбогдох мэдээллийг Байгаль орчны хамгаалал, албадан нүүлгэн шилжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх явцад өртсөн хүмүүст нэн даруй

мэдээлэх.

- b) Төслийг барьж байгуулах, хэрэгжүүлэх, ажиллуулах явцад анхан шатны БОТБҮ, аймгийн БОМТ, НШТ-д тооцоолоогүй аливаа байгаль орчин ба/эсвэл нийгмийн эрсдэл, нөлөөлөл үүсвэл АХБ-д ийм эрсдэл, нөлөөлөл бий болсон талаар мэдээллийг үйл явдлын дэлгэрэнгүй тодорхойлолт, санал болгож буй залруулах арга хэмжээний төлөвлөгөөний хамтаар нэн даруй мэдэгдэх.
- c) Нийгмийн хамгааллын хяналтын явцад бий болсон мэдээллийг боловсруулах, аливаа гадны мэргэжилтнүүдийн хяналт шалгалтын ажлыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор АХБ-ны хүлээн зөвшөөрсөн ажлын даалгавар сонголтын ажлын хүрээнд нийгмийн хамгааллын хөндлөнгийн мэргэшсэн, туршлагатай ажилтанг томилон ажиллуулах
- d) Тухайн аймгийн БОМТ-д тогтоосон арга хэмжээ, шаардлагыг дагаж мөрдөхөд үүсэх бодит болон болзошгүй зөрчлийг тухай бүрт нь мэдэгдэж, зөрчлийг мэдсэн даруйд мэдээлэх.

Хөрөнгө оруулалт хийхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалт

15. Зээлдэгч Хамгаалалтын бодлогын баримт бичгийн 5-р хавсралтад заасан хөрөнгө оруулалтын хориглосон жагсаалтад багтсан аливаа үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулагдсан зээлийн хөрөнгийг зарцуулахгүй байхыг БХБЯ-аар гүйцэтгүүлэх үүрэг хүлээнэ.

Гомдол барагдуулах механизм

16. Зээлдэгч нь ТУН, аймгийн БОМТ, НШТ-ний хүрээнд, хамгааллын талаар гомдлыг харгалзан үзэх зорилгоор БХБЯ-нд АХБ-д хүлээн зөвшөөрөгдсөн тусгайлсан хамгааллын гомдол барагдуулах зарчмыг холбогдох БОМТ ба НШТ-д заасан хугацаанд баталсан байхыг үүрэг болгоно.

Хөдөлмөрийн стандарт, эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа

17. Төслийг хэрэгжүүлэх явцад Зээлдэгч нь хөдөлмөрийн үндсэн хэм хэмжээ, Зээлдэгчийн холбогдох хууль тогтоомж, журмыг дагаж мөрдөхийг БХБЯ-аар гүйцэтгүүлэх үүрэг хүлээнэ. Зээлдэгч нь БХБЯ-ыг Төслийн дагуу АХБ-аас санхүүжүүлсэн тендерийн баримт бичиг, гэрээнд: (a) Зээлдэгчийн хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжийг дагаж мөрдөх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны холбогдох нормуудыг тусгах, (b) хүүхдийн хөдөлмөрийг ашиглахгүй байх, (c) ажилчин, ажил мэргэжлээрээ ялгаварлан гадуурхахгүй байх, (d) албадан хөдөлмөр эрхлэхгүй байх, (e) ажилчдад хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой гомдол, санал бодлоо илэрхийлэх, эрхээ хамгаалах арга хэрэгслийг хөгжүүлэхийг хязгаарлахгүй байх, (f) төсөлд хамрагдсан гэрээт ажилчдын ажилтнууд болон төслийн бүс нутгийн эргэн тойрны орон нутгийн гишүүд, ялангуяа эмэгтэйчүүдэд бэлгийн замын халдварт өвчин, тэр дундаа ХДХВ/ДОХ-ын эрсдлийн талаарх мэдээллийг түгээх, эсвэл холбогдох үйлчилгээ үзүүлэгчдийг татан оролцуулах гэх мэт тодорхой заалтууд оруулахыг гэрээлэгчээс шаардахыг үүрэг болгоно. Зээлдэгч нь БХБЯ-аар энэ хэсэгт заасан шаардлагыг чандлан хянаж, хагас жилийн тайланг АХБ-д гаргуулах үүрэг хүлээнэ.